

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ БАГЦ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

- Хавсралт 1 Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам
- Хавсралт 2 Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам
- Хавсралт 3 Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн журам
- Хавсралт 4 Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам
- Хавсралт 5 Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах журам
- Хавсралт 6 Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай журам
- Хавсралт 7 Үнэт цаасны брокер, дилер андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам
- Хавсралт 8 Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны зохицуулалтын журам
- Хавсралт 9 Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх тухай журам
- Хавсралт 10 Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх журам
- Хавсралт 11 Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны ерөнхий журам
- Хавсралт 12 Үнэт цаасны зах зээлийн маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааны журам
- Хавсралт 13 Мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох болон үйл ажиллагааг зохицуулах журам
- Хавсралт 14 Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг батламжлах, бүртгэх тухай заавар

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны
тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн
зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны
багц журам”-ын нэгдүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1-24.1.11, 24.1.14-д заасан үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд (цаашид “зохицуулалттай этгээд” гэх)-д тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоохтой холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

ХОЁР.ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

2.1.Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 25, 28 дугаар зүйлд зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1.энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

2.1.2.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол хавсран ажил эрхэлдэггүй байх;

2.1.3.хувьцаа эзэмшигч (хувьцаат компанийн хувьд нийт хувьцааны таваас дээш хувийг эзэмшигч), ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтан болон мэргэжилтэн нь дараах шалгуурыг хангасан байна:

2.1.3.1.Эрүүгийн хуульд заасан авлигын, эдийн засгийн болон терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх, хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээгээгүй, эсхүл хүлээж байгаагүй байх;

2.1.3.2.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байх;

2.1.3.3.сүүлийн таван жилд зөрчлийн улмаас зөвшөөрөл нь хүчингүй болсон санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагаар ажиллаагүй байх;

2.1.3.4.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь өөр зохицуулалттай этгээдийн тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэггүй байх;

2.1.3.5.Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан бусад шаардлагыг хангасан байх.

2.1.4.үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэл, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журамтай, түүнийг хэрэгжүүлэх хараат бус дотоод хяналтын ажилтантай байна;

2.1.5.зуун хувийн гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээдийн мэргэжилтнүүдийн 70-аас доошгүй хувь нь Монгол Улсын иргэдээс бүрдсэн байх;

2.1.6.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь хариуцлагын даатгалд даатгуулсан байх.

2.2.Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд, үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд, үнэт цаасны арилжаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь энэ журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.2.1.үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай программ хангамж, техник, тоног төхөөрөмжтэй байх;

2.2.2.үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалттай байх;

2.2.3.үндсэн үйл ажиллагааг эрхлэх чиглэлийн болон мэдээлэл, технологийн бие даасан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

2.2.4.үйл ажиллагаанд ашиглах программ хангамж мэдээллийн нууцлал, мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангасан байх;

2.2.5.бусад дэд бүтцийн байгууллагын цахим сүлжээнд холбогдсон байх;

2.2.6.үнэт цаасны өмчлөх эрхийн болон хадгаламжийн байгууллагын хувьд дотоод мэдээлэл эзэмшигчдийн, харилцагчдаас ирсэн санал гомдлыг шийдвэрлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх.

2.3.Брокерийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь энэ журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.3.1.үнэт цаасны арилжаа эрхлэх, тооцооны байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, программ хангамжийн шаардлагыг тус тус хангасан байх;

2.3.2.брокерийн үйл ажиллагаа эрхлэх хоёроос доошгүй мэргэжилтэнтэй байх;

2.3.3.харилцагчдыг хүлээн авч үйлчлэх ажлын байрны хэсгийг брокероос бусад ажилтны албан өрөөнөөс тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байх;

2.3.4.“Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”, нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан шаардлагад нийцсэн, шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь гаргах бүрэн боломжтой, мөн харилцагчтай байгуулсан гэрээ, харилцагчийн бүртгэл, тэдний хөрөнгийн хөдөлгөөнтэй холбогдох гүйлгээний мэдээллийг хадгалах, мэдээлэл өгөх бэк оффис (back office)-ын программ хангамжтай байх.

2.4.Дилерийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь энэ журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.4.1.үнэт цаасны арилжаа эрхлэх, тооцооны байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх;

2.4.2.үнэт цаасны брокерийн үйл ажиллагааг нэг жилийн хугацаанд эрхэлсэн байх;

2.4.3.дилерийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэнтэй байх.

2.5.Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь энэ журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.5.1.үнэт цаасны үнэлгээ, үнийн тооцооллыг хийх, төсөл, судалгаа, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчтай харилцах чиглэлээр дагнан ажиллах гурваас доошгүй мэргэжилтэнтэй байх;

2.5.2.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журамтай, энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэнтэй байх;

2.5.3.үнэт цаас гаргагч этгээдтэй байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний стандарт нөхцөл нь дараах зүйлийг тусгасан байх:

2.5.3.1.гэрээ хүчин төгөлдөр байх хугацаа;

2.5.3.2.талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

2.5.3.3.нийтэд санал болгож буй үнэт цаасны захиалгын хугацаа;

2.5.3.4.үнэт цаасны захиалгыг авах, хуваарилах арга аргачлал;

2.5.3.5.үнэт цаасны үнийг тогтворжуулах хугацаа, арга хэлбэр;

2.5.3.6.үйлчилгээний хураамжийн хэмжээ.

2.5.4.үнэт цаасны зах зээлд брокерийн, эсхүл дилерийн үйл ажиллагааг хоёр жилийн хугацаанд эрхэлж, арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагаас гишүүнчлэлийн үүрэг хангалттай биелүүлсэн талаарх дүгнэлт ирүүлж, Хорооны баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байх.

2.6.Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь энэ журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.6.1.хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжилтэнтэй байх;

2.6.2.хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний гэрээ, хэлцлийг боловсруулж, хянах хуулийн мэргэжилтэнтэй, эсхүл үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээс энэ чиглэлээр тогтмол үйлчилгээ авахаар гэрээ байгуулсан байх;

2.6.3.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журамтай, энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэнтэй байх.

2.7.Үнэт цаасны итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь энэ журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.7.1.ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байх;

2.7.2.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журамтай, энэ чиглэлээр ажиллах мэргэжилтэнтэй байх;

2.7.3.эрх бүхий албан тушаалтан нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

2.7.4.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь гадаадын, эсхүл өөрийн орны санхүүгийн зах зээлд гурваас доошгүй жил хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах түвшний албан тушаал эрхэлж байсан туршлагатай байх.

2.8.Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн

этгээд нь энэ журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.8.1.хувьцаа эзэмшигч нь дараах этгээд байна:

2.8.1.1.Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллага;

2.8.1.2.Монголбанкны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй банк;

2.8.1.3.сүүлийн таван жилд жилийн аудитлагдсан тайлангаар үйл ажиллагааны борлуулалтын орлого нь нэг тэрбум төгрөгөөс доошгүй, Монгол улсад бүртгэлтэй компани;

2.8.1.4.зэрэглэл тогтоох үйл ажиллагааг гурваас доошгүй жил эрхэлж буй гадаад улсын зэрэглэл тогтоох байгууллага;

2.8.1.5.Компанийн нийт гаргасан хувьцааны 20 ба түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэггүй иргэн.

2.8.2.тав буюу түүнээс дээш гишүүнтэй ТУЗ-тэй байх ба тэдгээрийн олонх нь хараат бус гишүүн байх;

2.8.3.ТУЗ-өөс дараах дүрэм, журам, аргачлал, тэмдэглэгээ, тайлангийн загварыг баталсан байна:

2.8.3.1.зэрэглэл тогтоох аргачлал, тэмдэглэгээ, зэрэглэл тогтоох үйл ажиллагааны тайлангийн загвар;

2.8.3.2.Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO – International Organization of Securities Commissions)-аас гаргасан зөвлөмж (Code of Conduct Fundamentals for Credit Rating Agency)-д нийцүүлэн боловсруулсан “Зэрэглэл тогтоох үйл ажиллагааны журам болон ёс зүйн дүрэм”;

2.8.3.3.үйлчлүүлэгчийн дотоод мэдээлэл, баримт материалыг ашиглах, хадгалах, хамгаалах журам;

2.8.3.4.тогтоосон зэрэглэлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх журам;

2.8.3.5.шинжээчтэй байгуулах гэрээний үндсэн загвар;

2.8.3.6.арга, аргачлал, үзүүлэлт, тэмдэглэгээ, тодорхойлолтын тухай танилцуулга.

2.8.4.Олон нийтэд мэдээлэл хүргэх цахим хуудастай байх;

2.8.5.Таваас доошгүй гишүүдээс бүрдсэн Зэрэглэлийн хороотой байх бөгөөд гишүүд нь энэ журамд заасан мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх;

2.8.6.Зэрэглэл тогтоох чиглэлээр ажилласан ажлын туршлагатай хоёроос доошгүй шинжээч мэргэжилтэнтэй байх, эсхүл эдийн засаг, санхүүгийн шинжилгээ, эрсдэлийн удирдлагын чиглэлээр таваас доошгүй жил ажилласан дөрвөөс доошгүй шинжээч мэргэжилтэнтэй байх.

2.9.Кастодианы үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь энэ журмын 2.1-т зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.9.1.тусгай зөвшөөрөл хүсэгч нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага бол Компанийн тухай хуульд заасан шаардлага хангасан төлөөлөн удирдах зөвлөлтэй байх;

2.9.2.мэргэжилтнүүд нь банк, санхүү, хөрөнгийн зах зээл дээр ажиллаж байсан туршлагатай, үнэт цаасны зах зээл дээр ажиллах эрх авсан, гурваас дээш жил ажилласан зургаа болон түүнээс дээш мэргэжилтэнтэй байх;

2.9.3.Монголбанк, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, бусад мэргэжлийн оролцогч болон харилцагчтай мэдээлэл солилцох, төлбөр тооцоо гүйцэтгэх тоног төхөөрөмж, техник, программ хангамжийг бүрдүүлсэн байх;

2.9.4.кастодианы үйл ажиллагаа явуулах сүлжээ, программ хангамжид гэмтэл, саатал гарсан, давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тэдгээрт байгаа харилцагчдын мэдээллийн бааз, бусад өгөгдлийг давхар хадгалах, сэргээх системтэй байх;

2.9.5.нийтэд холбогдох мэдээлэл хүргэх өөрийн тогтмол ажилладаг цахим хуудастай байх;

2.9.6.тусгай зөвшөөрөл хүсэгч нь банк бол энэ хэсэгт заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.9.6.1.кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгаар, бие даасан нэгжтэй байх;

2.9.6.2.кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгж нь харилцагчид үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг хангасан дэд бүтэцтэй байх;

2.9.6.3.кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжийн бүртгэл, тайлан, тооцоо болон албан бичиг хэрэг хөтлөлт нь банкны үндсэн болон бусад үйл ажиллагааны бүртгэл, тайлан, тооцоо, албан бичиг хэргээс тусдаа хөтлөгдөх нөхцөл боломжоор хангасан, эдгээр мэдээлэлд зөвхөн кастодианы үйл ажиллагаа эрхлэх нэгжид ажиллаж буй ажилтнууд нэвтрэх боломжтой байх;

2.9.6.4.банкны үйл ажиллагааг гурван жилээс доошгүй хугацаанд эрхэлсэн байх;

2.9.6.5.гурваас доошгүй гишүүнээс бүрдсэн төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд тэдгээрийн нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх.

2.10.Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэхийг хүссэн зохицуулалттай этгээд нь энэ журамд зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.10.1.Хорооноос тогтоосон төлбөрийн чадварын харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн дөрвөн улирал дараалан хангаж ажилласан байх;

2.10.2.Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар сайн болон хангалттай үнэлгээ авсан, шалгалтын дүнгээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байх.

2.11.Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн зохицуулалттай этгээд нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.11.1.400.0 сая төгрөгөөс доошгүй хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх;

2.11.2.үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн бэк оффис (back office)-ын программтай байх ба тус программ нь гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын болон кастодиан банкны системд нийцсэн, тухайн улсын хадгаламжийн болон кастодиан, брокерийн компанийн дүрэм, журамд нийцүүлэн

харилцагчийн хөрөнгийн бүртгэлийг хөтөлдөг байх;

2.11.3.энэ журмын 2.11.2-т заасан программ нь харилцагч өөрийн данс дахь хөрөнгийн талаарх мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр авах боломжоор хангасан байх;

2.11.4.харилцагчийн данс хариуцсан мэргэжилтэнтэй байх ба уг мэргэжилтэн нь үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн чиглэлээр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй байх;

2.11.5.ТУЗ-өөс баталсан гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах брокерийн үйл ажиллагааны журамтай байх;

2.11.6.гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг эрхлэхэд баримтлах бодлого, бизнесийн төлөвлөгөө, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тооцоололтой байх.

2.12.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.5-д заасны дагуу зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэх тохиолдолд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.12.1.хувьцааг худалдан авч буй мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны байх;

2.12.2.шинэ хувьцаа эзэмшигч нь энэ журмын 2.1.3-т заасан шаардлагыг хангасан байх;

2.12.3.хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулсан байх;

2.12.4.хувьцааг тэргүүн ээлжид худалдан авахтай холбоотой Компанийн тухай хуульд заасан ажиллагааг хэрэгжүүлсэн байх.

2.13.Салбар, төлөөлөгчийн газар байгуулахыг хүссэн зохицуулалттай этгээд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.13.1.сүүлийн хоёр улиралд Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан;

2.13.2.салбар, төлөөлөгчийн газар нь байнгын үйл ажиллагаа явуулах хаяг, байршил нь тодорхой ажлын байртай, тухайн салбар, төлөөлөгчийн газарт тогтмол ажиллах эрхлэгч мэргэжилтэнтэй байх;

2.13.3.салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;

2.13.4.ТУЗ-өөс баталсан салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны журамтай байх.

ГУРАВ.ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.Брокерийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай этгээд нь үнэт цаас худалдах, худалдан авах талаар шийдвэр гаргахад шаардлагатай дараах мэдээллээр харилцагчийг хангана. Үүнд:

3.1.1.үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан үнэт цаасны сүүлийн зургаан сарын арилжааны идэвх, үнэ ханш, арилжаатай холбоотой мэдээ;

3.1.2.үнэт цаас гаргагчийн хаяг, ерөнхий болон санхүүгийн байдлын талаарх

мэдээлэл (Үүнд тухайн үнэт цаас гаргагчаас нийтэд мэдээлэхээр заасан санхүүгийн мэдээллүүд хамаарна);

3.1.3.нийтэд мэдээлэхийг хуулиар хориглоогүй бусад мэдээлэл.

3.2.Брокерийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай этгээд нь харилцагчийг зөвхөн мэдээллээр хангах үүрэг хүлээх бөгөөд үнэт цаас худалдан авах, худалдахтай холбоотой аливаа зөвлөгөө өгсөн тохиолдолд түүнийг зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх ба энэ нь брокерийн компанийг тухайн хөрөнгө оруулагчид учруулсан хохирлыг барагдуулах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

3.3.Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.8-д заасны дагуу харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан харилцагч тус бүрээр тусгайлан, нэр төрлөөр нь балансын гадуур дэлгэрэнгүй бүртгэнэ. (Харилцагчийн гадаад улсын үнэт цаасны зах зээлээс үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгө, худалдан авсан үнэт цаас, түүнтэй холбоотой орлогыг тайлангийн тодруулгын “балансын гадуурх бүртгэлийн тодруулга” хэсэгт тусгана.)

3.4.Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах этгээд нь харилцагчийн мөнгөн хөрөнгийн бүртгэл, арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн ерөнхий мэдээллийг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

3.5.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд Хороонд урьдчилан мэдэгдэж, хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, нэмж гаргасан хувьцааг худалдан авах этгээд нь холбогдох хууль, энэ журам болон Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангаж буй эсэхээ тогтоолгосны дараа өмчлөх эрх шилжих, гүйлгээ хийх ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.6.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтныг томилох тохиолдолд Хороонд урьдчилан мэдэгдэж, шинээр томилогдож буй этгээд нь холбогдох хууль, энэ журам болон Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангаж буй эсэхээ тогтоолгосны дараа томилох ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.7.Гүйцэтгэх удирдлагаар томилохоор санал болгож байгаа этгээд нь энэ журмын 3.6-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн зохицуулалттай этгээд гүйцэтгэх захирлаар томилох өөр этгээдийг нэг сарын дотор санал болгоно.

3.8.Зохицуулалттай этгээд нь салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хязгаарлах, байршлыг нь өөрчлөх тухай бүрд зохицуулалттай этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэрийг гаргуулж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Хороонд мэдэгдэнэ.

3.9.Зохицуулалттай этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь тухайн байршилд тогтмол, байнгын үйл ажиллагаа явуулж, салбарын үйл ажиллагааны тайланг улирал тутам Хороонд ирүүлнэ.

3.10.Зохицуулалттай этгээд нь өөрийн оршин байгаа газрын хууль ёсны хаяг өөрчлөх тохиолдолд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор энэ журмын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргасан өргөдлийг Хороонд ирүүлнэ.

3.11.Хороо зохицуулалттай этгээдийн хүсэлтийн дагуу хаяг байршлын өөрчлөлт, холбогдох ажлын байр нь хууль болон энэ журмын шаардлага хангаж байгаа эсэхийг нягталж, ажлын таван өдөрт багтаан хариуг албан бичгээр мэдэгдэнэ.

3.12.Зохицуулалттай этгээд нь оноосон нэрээ өөрчлөх тохиолдолд Хороонд урьдчилан мэдэгдэж, Иргэний хуулийн 27.3-т “хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй” гэж заасан болон харилцагч, олон нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй байх шаардлагыг хангаж буй эсэхээ тогтоолгосны үндсэн дээр оноосон нэрийн өөрчлөлтийг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

3.13.Энэ журмын 3.12-т заасан шаардлагыг хангаж бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн тохиолдолд зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, шинээр олгож, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

3.14.Хорооноос гүйцэтгэх удирдлагаар томилох, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх болон салбар, төлөөлөгчийн газар байгуулагдах, оноосон нэр өөрчлөх тухай шийдвэр гаргаснаар зохицуулалттай этгээдийн зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, хүсэлт гаргагч нь бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох өөрчлөлтийг хийлгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн шинэчилсэн хуулбарыг ажлын 15 өдөрт багтаан Хороонд ирүүлнэ.

3.15.Зохицуулалттай этгээд нь үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэхэд үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн ерөнхий, эсхүл шууд гишүүнээр элссэн байхаас гадна Хороонд урьдчилан албан бичгээр мэдэгдэж, энэ журамд заасан шаардлагыг хангаж буй эсэхээ тогтоолгосон байна.

3.16.Зохицуулалттай этгээд нь мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын номинал данс эзэмшиж харилцагчид үйлчилгээ үзүүлэхдээ дараах шаардлагыг хангасан байна:

3.16.1.нэг тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний өөрийн хөрөнгөтэй, Хорооноос баталсан “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам”-ын шаардлагыг сүүлийн дөрвөн улирал дараалан хангасан байх;

3.16.2.мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг гүйцэтгэх, харилцагч бүрийн дансны бүртгэлийг хөтлөх, мэдээлэл авах, хэвлэх, дансаа удирдах боломжоор хангагдсан төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон арилжааны банктай холбогдож, мэдээлэл солилцох, цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан программ хангамжтай байх; (Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэгч болон программ хангамж нийлүүлэгчээс тодорхойлолт гаргуулсан байх)

3.16.3.үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан номинал данс хариуцсан мэргэжилтэнтэй байх бөгөөд тухайн мэргэжилтэн нь бусад албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

3.16.4.харилцагчийн мөнгөн хөрөнгийн орлого, зарлага, үлдэгдлийн мэдээллийг цахимаар сар бүрийн 10-ны өдрийн дотор тооцооны үйл ажиллагаа эрхлэгч этгээд болон Хороонд ирүүлэх бөгөөд нууцлалтай холбоотой асуудлыг хоорондын гэрээнд тусгасан байх;

3.16.5.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.8-д заасны дагуу харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан харилцагч тус бүрээр хөтөлж, мөнгөн орлого,

зарлагын гүйлгээг санхүүгийн тайлан тэнцэлд дэлгэрэнгүй бүртгэж, Хорооноос баталсан “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам”-д заасан өөрийн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн зохистой харьцаанд хамруулан тооцохгүй байх;

3.16.6.дотоод хяналтын ажилтан нь энэ журмын 3.27-д заасан мэдээллийг нэгтгэн боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргэх, номинал данс хариуцсан ажилтны үйл ажиллагаа болон харилцагчаа таньж мэдсэн байдал, харилцагчийн дансны шилжүүлэг, гүйлгээнд тогтмол хяналт тавьж ажиллах, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг дагаж мөрдөх;

3.16.7.мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын номинал дансны үйл ажиллагааг зохицуулсан нарийвчилсан журмыг хувьцаа эзэмшигч, эсхүл ТУЗ-ийн хурлаар батлуулж, журмын хавсралтаар харилцагчаа таньж мэдэх маягтын загварыг баталсан байх;

3.16.8.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.8-36.10 дахь хэсгийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, номинал данс дахь харилцагчийн зарлагын гүйлгээг арилжааны төлбөр тооцоотой холбоотой гүйлгээ хийхээс бусад тохиолдолд зөвхөн харилцагчийн нэр дээрх арилжааны банкны дансанд шилжүүлэх;

3.16.9.мөнгөн хөрөнгийн номинал данс нь арилжааны банкинд тусгайлан нээсэн, ҮЦК-ийн нэр дээрх харилцагчдын мөнгөн хөрөнгийн нэгдсэн данс байх бөгөөд тус данс дахь харилцагчдын мөнгөн хөрөнгөөр ҮЦК нь ямарваа нэг үүргийн гүйцэтгэл хангуулах, харилцагчийн зөвшөөрөлгүйгээр мөнгөн хөрөнгийг шилжүүлэхгүй байх;

3.16.10. жилийн санхүүгийн тайланд Хороонд бүртгэлтэй аудитын компаниар аудит хийлгэх хүрээнд номинал дансны мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын үйл ажиллагаанд аудит хийлгэж, гаргасан дүгнэлтийг тооцооны үйл ажиллагаа эрхлэгч этгээд болон Хороонд дараа оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэх;

3.16.11.үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх төлөвлөгөө (BCP, DRP), үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага болон мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоотой байх, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааны аудит хийлгэсэн байх.

3.17.Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд нь үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэхдээ дараах шаардлагыг хангасан байна:

3.17.1.нэг тэрбум 500 сая төгрөгөөс доошгүй хэмжээний өөрийн хөрөнгөтэй байх, Хорооноос баталсан “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам”-ын шаардлагыг сүүлийн дөрвөн улирал дараалан хангасан байх;

3.17.2.мөнгөн хөрөнгийн номинал дансны үйлчилгээг нэгээс дээш жилийн хугацаанд тасралтгүй эрхэлж, энэ журмын 3.16.10-д заасан аудитын дүгнэлт гаргуулсан байх;

3.17.3.үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын гишүүнчлэлийн шаардлагыг хангаж, гишүүнээр элссэн байх;

3.17.4.номинал данс хөтлөх тусгаар, бие даасан нэгжтэй байх ба тухайн нэгж нь брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаанаас тусдаа зохион байгуулалтын бүтэцтэй байх бөгөөд зөвхөн харилцагчийн зөвшөөрлөөр түүний үнэт цаасны орлого, зарлагын гүйлгээг гүйцэтгэж, өмчлөх эрхийг бүртгэх үүрэгтэй;

3.17.5.энэ журмын 3.17.4-т заасан нэгж нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан, мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан хоёроос доошгүй мэргэжилтэнтэй байх бөгөөд тухайн мэргэжилтнүүд нь бусад албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

3.17.6.харилцагчийн үнэт цаасны шилжүүлэг, үлдэгдлийн мэдээллийг сар бүрийн 10-ны өдрийн дотор үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд болон Хороонд ирүүлж байх;

3.17.7.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.8-д заасны дагуу харилцагчийн үнэт цаасыг өөрийн үнэт цааснаас тусгаарлан харилцагч тус бүрээр тусгаарлаж, орлого, зарлагын гүйлгээ бүрийг тайлан тэнцлийн гадуур дэлгэрэнгүй бүртгэж байх;

3.17.8.үнэт цаасны номинал дансны үйл ажиллагааг зохицуулсан нарийвчилсан журмыг хувьцаа эзэмшигч, эсхүл ТУЗ- ийн хурлаар батлуулж, тухайн журамд харилцагчийг таньж мэдэх, тайлан хуулга хүргэх, үнэт цаастай холбоотой мэдээлэл хүргэх тухай зохицуулалт тусгасан байх ба журмын хавсралтаар харилцагчийг таньж мэдэх маягтын загварыг баталсан байх;

3.17.9.үнэт цаасны номинал данс хөтөлж, харилцагчид үйлчилгээ үзүүлэхэд баримтлах бодлого, эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх;

3.17.10.үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, арилжааны банк, төлбөр тооцооны байгууллагатай мэдээлэл солилцох, төлбөр тооцоог гүйцэтгэх техник төхөөрөмж, программ хангамжийг бүрдүүлсэн талаарх тодорхойлолтыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас гаргуулсан байх;

3.17.11.үнэт цаасны номинал дансны үйл ажиллагаанд ашиглах программ нь кастодианы удирдлагын программтай ижил, эсхүл төсөөтэй шинжтэй, программ нь багц, эсхүл байгууллагын оюуны өмчийн эрхтэй (proprietary) байж болох бөгөөд үнэт цаасны номинал дансны үйл ажиллагаа явуулахад шаардлагатай функцтэй байх; (тухайлбал, үнэт цаасны болон харилцагчийн мэдээллийн сан, данс удирдах программ, харилцагчаас өгөх зааварчилгааг боловсруулах, удирдах, арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх, компанийн үйл ажиллагааны гүйлгээ хийх боломжтой талаарх тодорхойлолтыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас гаргуулсан байх);

3.17.12.үнэт цаасны номинал дансны үйл ажиллагаа явуулах сүлжээ, программ хангамжид гэмтэл, саатал гарсан, эсхүл давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тэдгээрт байгаа харилцагчдын мэдээллийн бааз, бусад өгөгдлийг давхар хадгалах, сэргээх системтэй байх;

3.17.13.бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, дотоод хяналтын болон комплаенсийн тогтолцоотой, Хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны талаар хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх.

3.18.Зохицуулалттай этгээд нь дотоод хяналтыг хэрэгжүүлэх журамтай байх ба дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотойгоор хувьцаа эзэмшигчид, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтны үүрэг, хариуцлагыг зааглан тодорхойлсон байна.

3.19.Зохицуулалттай этгээдийн дотоод хяналтын тогтолцоо нь түүний нягтлан бодох бүртгэл, эрсдэлийн удирдлагыг бүрэн хамаарч чадахуйц, үйл ажиллагааны үе шат бүрд хяналт тавьж болохуйцаар зохион байгуулагдсан байна.

3.20.Зохицуулалттай этгээдийн төв болон салбарын үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах

зээлийн хууль тогтоомж болон компанийн дотоод үйл ажиллагааны журмуудад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих орон тооны дотоод хяналтын ажилтантай байна.

3.21.Дотоод хяналтын ажилтан нь хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлэх ба эрх бүхий этгээд, удирдлагаас өгсөн үүрэг, даалгавраар тухайлсан шалгалтыг гүйцэтгэж болно. Дотоод хяналтын ажилтан нь шалгалтын тайлан, дүгнэлтийг тухай бүр хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагад танилцуулна.

3.22.Дотоод хяналт шалгалтын тайланд шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулах талаар хугацаатай үүрэг, даалгавар, гүйцэтгэлийг хангуулах, хариуцлагын харилцааг тодорхой тусгасан байна.

3.23.Дотоод хяналтын ажилтан нь үр дүнтэй, шударга хяналтыг хэрэгжүүлж чадахуйц мэдлэг, туршлагатай байх ба компанийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага нь түүнийг бие даасан, хараат бус хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлөөр хангах үүрэгтэй.

3.24.Дотоод хяналтын ажилтан нь компанийн бүх төрлийн баримт бичиг, бүртгэлийг шалгах эрхтэй, хөндлөнгийн аудитор, хянан шалгах зөвлөлд мэдээлэл өгөх үүрэгтэй байна.

3.25.Дотоод хяналтын ажилтан нь зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, Хорооноос тогтоосон санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хангалт, эрсдэлийн удирдлага, хяналтыг тогтмол мөрдүүлж ажиллана.

3.26.Дотоод хяналтын ажилтан нь зохицуулалттай этгээдийн ерөнхий болон хүний нөөц, санхүү, нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээлэлд орсон өөрчлөлтийг тухай бүр удирдлагадаа танилцуулж, тухайн байгууллагаас Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

3.27.Дотоод хяналтын ажилтан нь Хорооноос өгсөн үүрэг даалгавар болон улсын байцаагчийн албан шаардлагын биелэлт, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийн хангалт, биелэлтэд давхар хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

3.28.Дотоод хяналтын ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүдэн харилцагчид хохирол учруулсан тохиолдолд тухайн зохицуулалттай этгээд хариуцна.

3.29.Брокерийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай этгээд нь харилцагчтай байгуулах гэрээний төсөлд дараах зүйлсийг тусгахгүй ба стандарт гэрээний төслийг Хороонд ирүүлнэ. Үүнд:

3.29.1.брокерийн компанийн хууль бус үйл ажиллагааны улмаас харилцагчид хохирол учруулснаас үүсэх хариуцлагын хязгаарлалт, учирсан хохирлыг барагдуулах төлбөрийн дээд хэмжээг заах;

3.29.2.харилцагчийн хууль тогтоомж болон гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлэх, гэрээг цуцлах эрхийг хязгаарлах, эсхүл аль нэг талд давуу эрх олгох;

3.29.3.Иргэний хуулийн 198.1 дэх хэсгийн дагуу үгийн шууд утгаар харилцагчид ойлгогдох боломжгүй, маргаан гарсан тохиолдолд өөрт ашигтай утгаар тайлбарлах боломжтой заалт.

3.30.Брокерийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай этгээд нь Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох шинжтэй захиалгыг биелүүлэхгүй талаар харилцагчтай байгуулах гэрээнд тусгана.

3.31.Кастодианаас бусад зохицуулалттай этгээд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн гурваас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах сан

байгуулна.

3.32.Зохицуулалттай этгээдийн баримт бичгийг хадгалах, архивын нэгж болгох нийтлэг харилцааг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулиар, нарийвчилсан харилцааг арилжаа эрхлэх болон үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын дотоод журмаар зохицуулна.

3.33.Зохицуулалттай этгээд нь дараах баримт бичгийг өөрийн архивд таваас доошгүй жилийн хугацаагаар хадгалах үүрэгтэй. Үүнд:

3.33.1.харилцагчтай байгуулсан данс нээх гэрээ, захиалгын гэрээ, харилцагчаа таньж мэдэх маягт, итгэмжлэл;

3.33.2.харилцагчийн ерөнхий мэдээллийн бүртгэл;

3.33.3.үнэт цаас худалдах, худалдан авах захиалгатай холбоотой баримт бичиг, дуу хоолойны болон дүрст бичлэг;

3.33.4.харилцагчийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой баримтууд;

3.33.5.андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой баримтууд;

3.33.6.хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой баримтууд;

3.33.7.санхүүгийн тайлан, түүний нэмэлт тодруулга;

3.33.8.компанийн холбогдох этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл;

3.33.9.өөрийн данс дахь үнэт цаас, мөнгөн хөрөнгө, тэдгээртэй холбоотой хэлцлийн бүртгэл;

3.33.10.дотоод хяналт шалгалтын тайлан, дүгнэлт, түүний үр дүнд хийгдсэн ажлын тайлан, холбогдох баримт бичиг;

3.33.11.харилцагчаас ирүүлсэн өргөдөл, гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал, зөвшөөрлийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой баримт бичиг, гэрээ хэлцэл зэрэг бусад баримт бичиг.

3.34.Энэ журмын 3.33-г заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу баримт бичгийг холбогдох архивд шилжүүлнэ.

3.35.Зохицуулалттай этгээдийн зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд брокерийн компани зөвхөн харилцагчийн үнэт цаасны худалдах, худалдан авах захиалгыг биелүүлж болох бөгөөд харин өөрийн компанийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн захиалгыг биелүүлэхгүй ба зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл шаардлагыг арилгахгүйгээр нэг сарын хугацаа өнгөрсөн нөхцөлд харилцагчийн захиалгыг биелүүлэх эрхийг түр зогсоож, харилцагчийг өөр брокерийн компаниар үйлчлүүлэх арга хэмжээг Хорооноос авч хэрэгжүүлнэ.

3.36.Зохицуулалттай этгээдийн зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ журмын 3.33-д заасан баримт бичгийг арилжаа эрхлэх, төлбөр, тооцоо болон үнэт цаасны хадгаламжийн байгууллагын архивд шилжүүлнэ.

3.37.Зохицуулалттай этгээдийн зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд харилцагчдыг шилжүүлэх ажиллагааг Хорооноос холбогдох журмын дагуу хэрэгжүүлнэ.

3.38.Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшиж байсан компанийн зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд дараах баримт бичгийг архивын журмын дагуу нэгж

болгон цэгцэлж, хавтаслан арилжаа эрхлэх байгууллагын архивд хүлээлгэн өгнө:

3.38.1.үйл ажиллагаа явуулсан хугацаанд харилцагчдаас хүлээн авсан үнэт цаас худалдах, худалдан авах захиалгын гэрээнүүд;

3.38.2.мөн хугацааны захиалгын бүртгэлүүд;

3.38.3.мөн хугацааны дилерийн даалгаврууд;

3.38.4.мөн хугацааны харилцагчдын бүртгэлүүд;

3.38.5.харилцагчийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой бусад үндсэн баримтууд;

3.38.6.зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэрт заасан бусад баримтууд.

3.39.Зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэрт хүлээлгэн өгөх баримт бичиг, хугацааны талаар тодорхой заана.

3.40.Энэ журмын 3.39-т заасан Хорооны шийдвэрт холбогдох баримт бичгийг зохих журмын дагуу хүлээлгэн өгөөгүйн улмаас харилцагчдад учруулсан хохирлыг зөвшөөрөл эзэмшиж байсан компанийн хувьцаа эзэмшигч, хэрэв зөвшөөрөл эзэмшигч нь хувьцаат компани бол тухайн үеийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан эрх бүхий этгээдүүд хариуцаж барагдуулна.

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай Хорооны шийдвэр гарснаас хойш уг үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж Зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

4.2.Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд Зөвшөөрлийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.3.Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
нэгдүгээр хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЗАРИМ ЭТГЭЭДИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ**

№	Эрхлэх үйл ажиллагаа	Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ (сая.төгрөг)
1	Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа	30.0
2	Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа	100.0
3	Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа	200.0
4	Андеррайтерийн үйл ажиллагаа	1,000.0
5	Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа	2,000.0
6	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа	2,000.0
7	Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа	2,000.0
8	Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа	2,000.0
9	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа /кастодиан/	1,000.0
10	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох	200.0

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
хоёрдугаар хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХИЙГ ХҮССЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр						
Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан уу?	Тийм О		Үгүй О			
<i>Тийм бол дараах мэдээллийг бөглөнө үү.</i>						
Бизнесийн аль салбарт үйл ажиллагаа явуулж байсан бэ?						
Ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан бэ?						
Өмнө нь тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлж байсан уу?	Тийм О		Үгүй О			
Тийм бол хэдэн онд?						
Татгалзсан шалтгаан?						
1. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлөө сонгоно уу.						
<input type="radio"/> Төрөл 1 үнэт цаасны брокерийн						
<input type="radio"/> Төрөл 2 үнэт цаасны дилерийн						
<input type="radio"/> Төрөл 3 үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн						
<input type="radio"/> Төрөл 4 андеррайтерийн						
<input type="radio"/> Төрөл 5 үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн						
<input type="radio"/> Төрөл 6 үнэт цаасны арилжааны тооцооны						
<input type="radio"/> Төрөл 7 үнэт цаасны арилжааны төлбөрийн						
<input type="radio"/> Төрөл 8 үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн						
<input type="radio"/> Төрөл 9 үнэт цаасны арилжаа эрхлэх						
<input type="radio"/> Төрөл 10 үнэт цаасны итгэмжлэн удирдах						
<input type="radio"/> Төрөл 11 кастодиан						
<input type="radio"/> Төрөл 12 санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох						
I. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ						
Үүсгэн байгуулагч этгээд нь аль болохыг сонгоно уу.			<input type="radio"/> Хуулийн этгээд <input type="radio"/> Иргэн			

1. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийн үнэн зөв бөглөнө үү.



Хуулийн этгээдийн нэр	Монгол					
	Англи					
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Хуулийн этгээдийн хэлбэр	О Хувьцаат компани хариуцлагатай компани			О Хязгаарлагдмал		
Хөрөнгө оруулалтын хэлбэр	О Дотоодын Гадаадын					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Үйл ажиллагааны цэвэр ашиг	₮					
Хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө						₮
Хаяг байршил	Аймаг/ хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим хуудас						
Цахим шуудангийн хаяг						
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?	Тийм О		Үгүй О			
Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.						
Оноосон нэр						
Компанийн хэлбэр	О Хувьцаат компани			О Хязгаарлагдмал хариуцлагатай компани		
Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болох	О толгой		О хараат			
	О охин		О зэргэлдээ			
Байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Үйл ажиллагааны төрөл						
Хаяг	Аймаг/ хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
Холбоо барих утас:						
Цахим хуудас:						
Цахим шуудангийн хаяг:						

2. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол доорх мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.

Овог	
Нэр	
Регистрийн дугаар	
Албан ёсны хаяг байршил	

Эрхэлж байгаа ажил, албан тушаал	
Ажлын хаяг	
Эзэмшсэн мэргэжил	
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	₮
Харилцах дансны үлдэгдэл	₮
Хадгаламжийн дансны үлдэгдэл	₮

II. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Хуулийн этгээдийн нэр	Монгол					
	Англи					
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Хуулийн этгээдийн хэлбэр	О Хувьцаат компани компани		О Хязгаарлагдмал хариуцлагатай			
Хөрөнгө оруулалтын хэлбэр	О Дотоодын		О Гадаадын			
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Хаяг байршил	Аймаг/ хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим хуудас						
Цахим шуудангийн хаяг						
 О Харилцах	Банкны нэр					
	Дансны дугаар					
	Валютын төрөл					
	Үлдэгдэл		₮		₮	
 О Хадгаламж	Банкны нэр					
	Дансны дугаар					
	Валютын төрөл					
	Үлдэгдэл		₮		₮	

Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/ оноосон нэр	Хувьцааны тоо (ш)	Хувьцааны төрөл		ХНХ-н хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
		О ДЭХ	О ЭХ		
		О ДЭХ	О ЭХ		
		О ДЭХ	О ЭХ		

Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)

Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл:

ТУЗ-тэй байх эсэх	Тийм О	Үгүй О	Бүрэлдэхүүний тоо	
-------------------	--------	--------	-------------------	--

Дотоод хяналтын нэгжтэй байх эсэх				Тийм О	Үгүй О				
Нийт ажилтан, албан хаагчдын тоо				Эрэгтэй ажилтны тоо					
				Эмэгтэй ажилтны тоо					
Албан тушаал	Овог	Нэр	Хүйс	Харьяалал	РД	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар	
ТУЗ-ийн дарга									
ТУЗ-ийн гишүүн									
Дотоод хяналтын нэгжийн дарга									
Дотоод хяналтын нэгжийн гишүүн									
Гүйцэтгэх захирал									
Нягтлан бодогч									
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг удирдах ажилтан бүрээр бичнэ.)</i>									
Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл									
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт			Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮		
				О	О				
				О	О				
<i>Тэмдэглэл: (Үйл ажиллагааны төрлөөс хамааран шаардлага хангасан техник, тоног төхөөрөмж, программ хангамжтай байна. Дээрх мэдээллийг техник, тоног төхөөрөмж бүрээр бичнэ.)</i>									
Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт			Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮		
				О	О				
				О	О				
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг программ хангамж бүрээр бичнэ.)</i>									
Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны төлөвлөлт									
Үзүүлэлтүүд				Он	Он	Он			
Харилцагч үйлчлүүлэгчдийн тоо									
Эх үүсвэрийн өртөг ₮									
Нийт орлого ₮									
Нийт зарлага ₮									
Хүлээгдэж буй ашиг	₮								
Өөрийн хөрөнгийн өгөөж	₮								
Активын өгөөж	₮								

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
гуравдугаар хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭД НЬ
ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЭМЖ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,
ЭНГИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл/хүсэлт гаргагч зохицуулалттай этгээдийн нэр						
Регистрийн дугаар						
Зөвшөөрлийн төрлийг сонгоно уу.						
<input type="radio"/> Тусгай зөвшөөрлийн хүрээнд нэмж эрхлэх үйл ажиллагаа <input type="radio"/> Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах <input type="radio"/> Зохицуулалттай этгээдэд салбар, төлөөлөгчийн газар байгуулах						
Тэмдэглэл: (тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина)						
1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд нэмж эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгоно уу.						
<input type="radio"/> Төрөл 1 үнэт цаасны брокерийн <input type="radio"/> Төрөл 2 үнэт цаасны дилерийн <input type="radio"/> Төрөл 3 үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн <input type="radio"/> Төрөл 4 андеррайтерийн <input type="radio"/> Төрөл 5 үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн <input type="radio"/> Төрөл 6 үнэт цаасны арилжааны тооцооны <input type="radio"/> Төрөл 7 үнэт цаасны арилжааны төлбөрийн <input type="radio"/> Төрөл 8 үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн <input type="radio"/> Төрөл 9 үнэт цаасны арилжаа эрхлэх <input type="radio"/> Төрөл 10 үнэт цаасны итгэмжлэн удирдах						
0 2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах						
<input type="radio"/> Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах <input type="radio"/> Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах						
А. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах						
Оноосон нэр /Овог, нэр	РД	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)						

Б. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах									
Этгээд	Оноосон нэр	Овог нэр	Харьяалал	РД	Хувьцааны тоо (ш)	ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)		
Хуулийн этгээд									
Иргэн									
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)</i>									
3. Зохицуулалттай этгээд салбар, төлөөлөгчийн газар байгуулах									
Зохицуулалттай этгээдийн оноосон нэр									
Салбар байгуулах шийдвэр		Он		Сар		Өдөр		Дугаар	
Нэгжийн хэлбэр		<input type="radio"/> Салбар			<input type="radio"/> Төлөөлөгчийн газар				
Чиглэл									
Хаяг байршил		Аймаг/ хот							
		Сум/дүүрэг							
		Баг/хороо							
		Гудамж, байр							
		Тоот							
		Холбоо барих утас							
Цахим хуудас									
Цахим шуудангийн хаяг									
Зохицуулалттай этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын ажилтны мэдээлэл									
Нэгжийн нийт ажилтан, албан хаагчдын тоо		Эрэгтэй ажилтны тоо							
		Эмэгтэй ажилтны тоо							
Албан тушаал	Овог	Нэр	Хүйс	Харьяалал	РД	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар	
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг ажилтан бүрээр бичнэ.)</i>									
Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл									

Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮
		0	0		
		0	0		

Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг техник, тоног төхөөрөмж бүрээр бичнэ.)

Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮
		0	0		
		0	0		

Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг программ хангамж бүрээр бичнэ.)

4. Зохицуулалттай этгээдийн оноосон нэр өөрчлөх

Зохицуулалттай этгээдийн хуучин нэр		Регистрийн дугаар	
Зохицуулалттай этгээдийн шинэчилсэн нэр			
Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгаан, үндэслэл			

5. Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах

Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	РД	Утасны дугаар

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
дөрөвдүгээр хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ХАЯГ
БАЙРШИЛ ӨӨРЧЛӨХ ТОХИОЛДОЛД ИРҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

1. Зохицуулалттай этгээдийн шинэ хаяг, байршлын талаарх мэдээлэл		
Зохицуулалттай этгээдийн хаяг, байршил өөрчилсөн эрх бүхий этгээдийн шийдвэрийн огноо, дугаар	_____ он _____ сар _____ өдөр Дугаар _____	
Хаяг байршил	Аймаг/ хот	
	Сум/дүүрэг	
	Баг/хороо	
	Гудамж, байр	
	Тоот	
	Холбоо барих утас	

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

**ПРОГРАММ ХАНГАМЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖЛЫН БАЙРНЫ
ТОДОРХОЙЛОЛТ**

Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Д/д	Техник, тоног төхөөрөмжийн төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан, түрээсэлсэн алин болох	Тоо, ширхэг

Зохицуулалттай этгээд нь дээрх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютероос гадна үнэт цаасны арилжааны, төлбөр тооцооны, хадгаламжийн болон бусад. (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах зориулалт бүхий программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ, болон –Г. (худалдан авсан, эсхүл худалдан авах гэрээ хийсэн) бөгөөд өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулалтын ажилд компьютерын (программ, түүнийг зохиосон байгууллагын нэр) программ ашиглах болно.

Зохицуулалттай этгээд нь үйл ажиллагаа явуулах байрыг:

худалдан авсан

түрээсэлсэн

бөгөөд энэхүү байр нь зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа эрхлэхэд тохиромжтой, аюулгүй байдлын хувьд бүрэн хамгаалагдсан болно.

Ажлын байрны шаардлага болон харуул хамгаалалтын найдвартай байдлыг хангасан гэж үзэж дор дурдсан бичиг баримтуудыг хавсаргав.

Худалдан авсан байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ

Түрээсэлсэн байрны түрээсийн гэрээ

Харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлбар

..... зохицуулалттай этгээдийг төлөөлж

/албан тушаал/

/...../

/гарын үсэг/

/...../

/овог, нэр/

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
Зургаадугаар хавсралт



ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчин нь дараах мэдээлэл

1. Ерөнхий мэдээлэл

3x4
Зураг

Ургийн овог:	
Овог нэр	
Регистрийн дугаар:	
Хүйс	
Иргэний харьяалал	
Зохицуулалттай этгээдэд эрхлэх албан тушаал:	
Оршин суугаа газрын хаяг	
Гар утасны дугаар	
Цахим хаяг	
Эрхэлж байгаа ажил, албан тушаал	

2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар	ҮЦЗЗ-д мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхийн дугаар

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

4. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага бусад боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

Компанийн тухай хуулийн 89.2-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

/...../ /...../...../

/Овог, нэр/ /гарын үсэг/

огноо

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
долоодугаар хавсралт

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан зөвшөөрөл хүссэн өргөдөл	
2	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигч эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар	
3	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (нотариатаар баталгаажуулсан, эсхүл e-mongolia.mn-аас авсан хүчинтэй лавлагаа)	
4	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох бичиг баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт	
5	Хөрөнгө оруулагч нь гадаадын хуулийн этгээд бол тухайн орныхоо бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, гадаадын иргэн бол овог нэр, оршин суух хаяг, холбоо барих утас, факс, цахим шуудангийн хаяг	
6	Хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, бусад баталгаа	
7	Татварын өргүй талаарх татварын байгууллагын тодорхойлолт	
8	Улсын бүртгэлд бүртгүүлсэн компанийн дүрэм. Тус дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлийг тусгасан байна	
	8.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл	
	8.2. хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах журам, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх	
	8.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон дотоод хяналтын нэгжийн эрх, үүрэг, хариуцлага	
	8.4. Зохицуулалттай этгээдийн хувьцаа арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааны зохицуулалт	
	8.5. Зохицуулалттай этгээд татан буугдах үндэслэл, удирдлага, мэргэжилтнүүдийн буруутай үйл ажиллагаанаас хөрөнгө оруулагч, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим	
9	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд дараах баримт бичгүүдийг нэмж бүрдүүлнэ:	
	9.1. Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагаас олгосон гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	
	9.2. Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн	

		хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг	
	9.3.	Харьяалах улс, оронд гааль, татварын өртэй эсэхийг харуулсан баримт бичиг	
	9.4.	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг	
	9.5.	Гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээд нь тухайн орны онцлогоос шалтгаалан дээрх заасан баримт бичгийг ирүүлэх боломжгүй бол гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигч эсхүл төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тодорхойлолт	
10		Брокер, дилер, андеррайтерийн компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн гурваас доошгүй хувьтай тэнцэх эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт	
11		Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр;	
12		Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн жилийн санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулж байгаа бол эхлэлтийн баланс	
13		Энэ журмын зургаадугаар хавсралтын дагуу таван хувиас дээш хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт	
14		Гүйцэтгэх удирдлага болон мэргэжилтнүүд нь энэ журмын 2.1.5-д заасан шаардлагуудыг хангасан болохыг нотлох баримт бичгүүд болон өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт	
15		Хуулийн этгээд нь хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бол тухайн хуулийн этгээдийн хувьцааны арилжааны сүүлийн нэг жилийн арилжааны тайлан	
16		Ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	
17		Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх гурваас доошгүй жилийн бизнесийн болон эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө	
18		Дотоод зохион байгуулалтын бүтэц, танилцуулга	
19		Зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тохиолдолд зохицуулалттай үйл ажиллагаа тус бүрийг дотооддоо удирдан зохион байгуулах нэгжийн талаарх танилцуулга	
20		Үндсэн үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмжийн жагсаалт, энэ журмын тавдугаар хавсралтын дагуу боловсруулсан ажлын байрны тодорхойлолт	
21		Зохицуулалттай үйл ажиллагаанд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам	
22		Зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх дотоод журам	
23		Банк, түүний нэгдэлд орсон болон банкны хувьцааны тав болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй аливаа хуулийн этгээд нь зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхэд татгалзахгүй талаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн албан бичиг	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
наймдугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР
ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Үндсэн үйл ажиллагаанд ашиглах программын танилцуулга	
2	Үнэт цаасны бүртгэлийн журам	
3	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47.2-т заасан дотооддоо мөрдөх журмууд	
4	Энэ журмын долоодугаар хавсралтын дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн анкет	
5	Арилжаа эрхлэх байгууллагын хувьцаа эзэмшигчдийн бүтэц	
6	Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагаас сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцохгүй, сонирхлын зөрчил үүсгэхгүй талаарх баталгаа	
7	Үнэт цаасны арилжааны төлбөрийн, тооцооны болон төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээний төсөл	
8	Гишүүнчлэлийн гэрээний төсөл	
9	Техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул хамгаалалтын асуудлыг шийдвэрлэсэн талаарх бусад этгээдтэй байгуулсан гэрээ, дэлгэрэнгүй танилцуулга	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
есдүгээр хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР
ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Үнэт цаасны төлбөрийн эрсдэлийн удирдлагын журам	
2	Хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдэлээс хамгаалах сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах нөхцөлийг тусгасан дотоод журам	
3	Үнэт цаасны тооцооны болон хадгаламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл	
4	Үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэхэд үүсэх эрх, үүргийг тусгасан төлбөрийн үйл ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулах гэрээний төсөл	
5	Үнэт цаасны арилжааны болон арилжааны бус хэлцлийн төлбөрийг хийж гүйцэтгэх журам, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
аравдугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР
ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Үнэт цаасны тооцооны үйл ажиллагааны журам	
2	Хөрөнгө оруулагчдыг тооцооны үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдэлээс хамгаалах сан байгуулах сангийн хөрөнгийг захиран зарцуулах нөхцөлийг тусгасан дотоод журам	
3	Үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөрийн болон хадгаламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл	
4	Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэхэд үүсэх эрх, үүргийг тусгасан тооцооны үйл ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулах гэрээний төсөл	
5	Үнэт цаасны арилжааны болон арилжааны бус хэлцлийн дүнд үүссэн тооцоог тодорхойлох, төлбөрийг хийж гүйцэтгэх журам	
6	Мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
арваннэгдүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР
ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх нэгжийн чиг үүргийг онцгойлон заасан үйл ажиллагааны журам	
2	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн хүрээнд дотооддоо мөрдөх журам, зааврууд	
3	Харилцагчдын хөрөнгийг эрсдэлээс хамгаалах зорилгоор даатгалын байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл	
4	Харилцагч байгууллагуудтай байгуулах хадгаламжийн гэрээний төсөл	
5	Харилцагчийн үнэт цаас худалдсан болон ногдол ашгийн мөнгөн хөрөнгийг байршуулан хадгалах арилжааны банктай байгуулах гэрээний төсөл	
6	Харилцагчдад үзүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ	
7	Үнэт цаасны хадгаламж, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам	
8	Гишүүн кастодиантай мэдээлэл тасралтгүй солилцох, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангах тухай үйл ажиллагааны журам	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
арванхоёрдугаар хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ӨМЧЛӨХ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР
ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааны журам	
2	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дотооддоо мөрдөх журмууд	
3	Харилцагчтай байгуулах өмчлөх эрхийн бүртгэлийн гэрээний төсөл	
4	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн харилцааг зохицуулсан дотоод үйл ажиллагааны журам: Үүнд доорх зүйлсийг тодорхой заана.	
5	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл хийхэд үндэслэх бичиг, баримт, мэдээлэл	
6	Харилцагчийн дансны хуулга, түүний хэлбэр, агуулга, хугацаа	
7	Үнэт цаасыг харилцагчийн дансанд бүртгэх, үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл хийхэд үндэслэсэн бичиг баримтыг хадгалах заавар	
8	Харилцагчдад үзүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ	
9	Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл, шилжүүлэг, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам	
10	Үнэт цаас гаргагчтай байгуулах үнэт цаасны бүртгэлийг хөтлөх гэрээний төсөл	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
арвангуравдугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР ХАВСРАЛТАД
ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Брокерийн үйл ажиллагааны журам	
2	Харилцагчдыг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааны тухай журам	
3	Харилцагч, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх тухай журам	
4	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тухайн брокерийн компанийг шинээр гишүүнээр элсүүлэхэд тавигдах шалгуур, арилжаанд оролцох шаардлагыг хангасан талаарх гаргасан дүгнэлт	
5	Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох шинжтэй захиалгыг биелүүлэхгүй талаар харилцагчтай байгуулах гэрээнд тусгаж болно	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
Арвандөрөвдүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ДИЛЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР ХАВСРАЛТАД
ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Дилерийн үйл ажиллагааны журмын эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хувь	
2	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тухайн дилерийн компанийг шинээр гишүүнээр элсүүлэхэд тавигдах шалгуур, арилжаанд оролцох шаардлагыг хангасан талаарх гаргасан дүгнэлт	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
Арвантавдугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ДОЛООДУГААР ХАВСРАЛТАД
ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх дотоод журам (Тус журамд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4-д зааснаас гадна дараах төрлийн аль хэлбэрээр үнэт цаас гаргагчтай ажиллахыг тусгана: хоёрдогч зах зээлд худалдах буюу өөрийн үнэт цаасны багцад хадгалах зорилгоор үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасыг бүхэлд нь худалдан авах, үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасны зарим хэсгийг худалдан авах, гаргасан үнэт цаасыг худалдан авахгүйгээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд арилжих үйл ажиллагааг зохион байгуулах, гаргасан үнэт цаас нь анхдагч зах зээлд арилжигдах боломжгүй нөхцөлд үнэт цаасыг нь тогтоосон үнээр худалдан авах баталгаа гаргах)	
2	Андеррайтерийн компани болон үнэлгээ, төсөл, судалгаа, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчтай харилцах чиглэлээр дагнан ажиллах мэргэжилтний хооронд байгуулсан гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
арванзургаадугаар хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР
ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Хөрөнгө оруулалтын зөвлөх компани болон үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхөөр ажиллах мэргэжилтний хооронд байгуулсан гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	
2	Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхөөр ажиллах мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм	
3	Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх мэргэжилтний үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ үзүүлэх эрхийн үнэмлэхийн хуулбар, мэргэшсэн байдлын тухай танилцуулга, нотлох баримт	
4	Мэргэжилтний үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр сургалтад хамрагдаж мэргэшсэн тухай үнэмлэх, сертификат, дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар	
5	Хөрөнгө оруулалтын зөвлөх компанийн хуулийн мэргэжилтний дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
арвандолоодугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ИТГЭМЖЛЭН УДИРДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР
ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм журам	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
арваннаймдугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ САНХҮҮЖИХ ЧАДАВХЫН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН
ДОЛООДУГААР ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА БҮРДҮҮЛЖ
ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Зэрэглэл тогтоох аргачлал, тэмдэглэгээ, тодорхойлолт, зэрэглэл тогтоох үйл ажиллагааны тайлангийн загвар	
2	Зэрэглэл тогтоох үйл ажиллагааны журам	
3	Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO – International for Credit Rating Agency)-д нийцүүлэн боловсруулсан “Зэрэглэл тогтоох үйл ажиллагааны үндсэн дүрэм буюу ёс зүйн дүрэм”	
4	Үйлчлүүлэгчийн дотоод мэдээлэл, баримт материалыг ашиглах, хадгалах, хамгаалах журам	
5	Тогтоосон зэрэглэлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх журам	
6	Шинжээчтэй байгуулсан ёс зүйн гэрээ	
7	Ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, тодорхойлох, түүнээс сэргийлэх журам	
8	Арга, аргачлал, үзүүлэлт, тэмдэглэгээ, тодорхойлолтын тухай танилцуулга	
9	Компанийн тухай хуульд заасан нэгдмэл сонирхолтой /холбогдох/ этгээдийн талаарх мэдээлэл, танилцуулга	
10	Веб хуудастайг нотлох баримт болон нэгээс доошгүй жил тухайн домэйн хаяг эзэмшихийг нотолсон гэрээ, төлбөрийн баримт	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
арванесдүгээр хавсралт

**КАСТОДИАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧ ХУУЛИЙН
ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА
БҮРДҮҮЛЖ ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Компанийн тухай хуульд заасан нэгдмэл сонирхолтой /холбогдох/ этгээдийн талаарх мэдээлэл, танилцуулга	
2	Харилцагчийн мэдээлэл, баримт бичгийг ашиглах, хадгалах, хамгаалах журам;	
3	Кастодианы үйлчилгээтэй холбоотой мэдээллийг харилцагчид хүргэх журам;	
4	Гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын ёс зүйн дүрэм;	
5	Сонирхлын зөрчлийг тодорхойлох, сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх журам;	
6	Давагдашгүй хүчин зүйл болон хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан гамшиг зэрэг гадны хүчин зүйл үүсэхэд сэргийлэх, авах арга хэмжээний тухай журам;	
7	Зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх журам;	
8	Эдийн засгийн болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;	
9	Эрсдэлийн удирдлагын бодлого;	
10	Энэ журмын 2.9.3, 2.9.4-т заасныг хангасан болохыг нотлох холбогдох Монголбанк, үнэт цаасны арилжаа эрхлэх, төвлөрсөн хадгаламжийн байгууллагын шаардлагын дагуу сүлжээнд холбогдон, мэдээлэл солилцох боломж бүрдүүлсэн байх бүрдсэн тухай холбогдох байгууллагаас гаргуулсан дүгнэлт болон программын танилцуулга	
11	Хороонд бүртгэлтэй аудитын компаниар, эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын компаниар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан;	
12	Банкны тухай хуулийн 6.4-д зааснаар кастодианы үйл ажиллагаа эрхлэхэд татгалзахгүй тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн албан бичиг;	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
хорьдугаар хавсралт

**ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЗАРИМ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАВСРАН ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ХҮССЭН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭД НЬ ЭНЭ ЖУРМЫН ДОЛООДУГААР
ХАВСРАЛТАД ЗААСНААС ГАДНА ДАРААХ БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛНЭ:**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Тухайн зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэх талаарх хувьцаа эзэмшигчдийн шийдвэр,	
2	Хавсран эрхлэх үйл ажиллагааны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан болохыг нотлох баримт бичиг	
3	Дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл	
4	Хавсран эрхлэх зохицуулалттай үйл ажиллагаа, оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага, үйл ажиллагааны эрсдэлийг тооцох аргачлал, харилцагчдын хохирлыг барагдуулах зохицуулалтыг тусгасан дотоод журам;	
5	Оноосон нэрээ өөрчлөх болсон шалтгаан, нөхцөлийг тайлбарласан дэлгэрэнгүй танилцуулга	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
хориннэгдүгээр хавсралт

ОНООСОН НЭРЭЭ ӨӨРЧЛӨХ ТОХИОЛДОЛД ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	
2	Бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан шинэ оноосон нэрийн баталгаажуулсан хуудас	
3	Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төсөл	
4	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	
5	Оноосон нэрээ өөрчлөх болсон шалтгаан, нөхцөлийг тайлбарласан дэлгэрэнгүй танилцуулга	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
хоринхоёрдугаар хавсралт

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА ӨӨРЧЛӨГДӨХ ТОХИОЛДОЛД ИРҮҮЛЭХ БАРИМТ
БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Гүйцэтгэх удирдлагаар томилох этгээдийн товч намтар, энэ журмын зургаадугаар хавсралтын дагуу бөглөн ирүүлсэн анкет	
2	Дээд боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
3	Өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт	
4	Үнэт цаасны зах зээлд ажиллах эрхийн үнэмлэхийн хуулбар	
5	Гүйцэтгэх удирдлагаар томилсон эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар	
6	Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг	

“Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай
үйл ажиллагаа эрхлэх журам”-ын
хорингуравдугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗААВАР

1. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх (цаашид “зохицуулалттай үйл ажиллагаа” гэх) тусгай зөвшөөрөл шинээр авах, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж авах, зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, зохицуулалттай этгээд салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах зөвшөөрөл авах болон гүйцэтгэх захирлыг томилох, оноосон нэрийг өөрчлөх зэргээс хамааран Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-д заасан шаардлагуудыг хангасан байна.
2. Шаардлага хангасан этгээд нь холбогдох маягтыг хамт бөглөх бөгөөд зөвшөөрөлтэй үйл ажиллагааны чиглэлээс хамааран холбогдох баримт бичгийг хавсаргаж Хороонд ирүүлнэ.
3. Маягтыг үнэн зөв бөглөх бөгөөд, худал, ташаа мэдээлэл ирүүлсэн тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзах, хүчингүй болгох үндэслэл болохыг АНХААРНА УУ!!!
4. Маягт бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, иргэний овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, сонгох тохиолдолд тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Энэхүү зааврын зорилго нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хүсэлт, гүйцэтгэх захирлыг томилох, оноосон нэрийг өөрчлөх тохиолдолд маягтыг бөглөх, тэдгээрт хавсаргах баримт бичгийг бүрдүүлэхэд зохицуулалттай этгээдийн үүсгэн байгуулагч, удирдлагуудад мөрдлөг болгон ашиглахад оршино.

ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧИГ БҮРДҮҮЛЭХ

А. Зөвшөөрлийн өргөдлийн маягтыг бөглөх

Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсний дараа үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд хандана.

Зөвшөөрлийн өргөдлийн маягтыг Хорооны цахим хуудсаас дахь “online” өргөдлийн маягт цонхонд хандаж цахимаар бөглөнө. Өргөдлийн маягтыг цаасаар бөглөх тохиолдолд Хорооны цахим хуудсаас татаж авна.

Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, хуулийн этгээдийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, иргэний овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, сонгох тохиолдолд тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

Хэсэг 1. Зохицуулалттай этгээдийн ерөнхий мэдээлэл

Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ дэх оноосон нэр, иргэн бол овог, нэрийг бүтэн бичнэ.

1.Өргөдөл гаргасан огноо: Он, сар өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.

2.Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр: Үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дэх оноосон нэрийг бичнэ.

3.Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан бол тийм гэсэн сонголт, явуулж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийнэ.

4.Бизнесийн аль салбарт, ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан тухайгаа товч бичнэ.

5.Өмнө нь тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлж байсан бол тийм гэсэн сонголт, ирүүлж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийнэ.

6.Тусгай зөвшөөрөл хүсэж байсан бол хэдэн онд ирүүлж байсан эсэх, яагаад татгалзсан тухай товч бичнэ.

7.Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлийг үйл ажиллагааны чиглэлээс хамааран сонгоно.

8.Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагдсан огноо, хуулийн этгээдийн хэлбэр, хөрөнгө оруулалтын хэлбэр, хаяг байршил, цахим хаяг зэрэг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг асуулгын дагуу нөхнө.

Хэсэг 2.Үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд, иргэний аль нь болохыг тодорхойлж, тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

1.Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн талаарх мэдээллийг бөглөхдөө:

1.Оноосон нэр: Монгол – хуулийн этгээдийн нэрийг кирилл үсгээр, бүтэн бичнэ.

Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.

2.Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан хурлын огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.

3.Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-хувьцаат компани, ХХК-Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.

4.Хөрөнгө оруулалтын хэлбэрээс тохирох нүдийг сонгоно.

5.Дотоодын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт хувьцааг /100 хувь/ Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд эзэмшдэг, гадаадын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуй нэгжийг тус тус ойлгоно.

6.Бизнесийн салбар, үйл ажиллагааны чиглэл: Үүсгэн байгуулагч хуулийн этгээд нь бизнесийн аль салбарт, ямар чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг болохоо бичнэ.

7.Үйл ажиллагааны цэвэр ашиг: Санхүүгийн тайланд тусгагдсан татвар төлсний дараах цэвэр ашгийн дүнг төгрөгөөр бичнэ.

8.Хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө: Үүсгэн байгуулагч хуулийн этгээдээс

оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр бичнэ.

9.Хаяг байршил: Хуулийн этгээдийн одоо байршиж байгаа эсхүл байршихаар гэрээ байгуулсан байрны хаягийг хүснэгт дэх асуулгын дагуу дэлгэрэнгүй бичих бөгөөд хаяг байршлыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлсэн байна.

10.Холбоо барих утас: Хуулийн этгээдийн холбоо барих суурин, гар утас, факсын дугаарыг бичнэ.

11.Цахим хаяг, цахим хуудас: Хуулийн этгээдийн албан ёсны цахим хаяг, хуудсыг бичнэ. Цахим хуудасгүй бол бөглөх шаардлагагүй.

2.Үүсгэн байгуулагч хуулийн этгээдийн компанийн нэгдлийн талаарх мэдээллийг бөглөхдөө:

1.Компанийн нэгдэлд хамрагддаг эсэхийг тодорхойлж, тийм, үгүй гэсэн сонголтоос тохирох нүдийг сонгоно.

2.Нэгдэлд оролцогч компаниудын оноосон нэр: Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх хуулийн этгээдийн нэр /Гадаадын хуулийн этгээд бол тухайн гадаад улсын зохих байгууллагаас олгосон гэрчилгээ дэх нэр/-ийг бичнэ.

3.Компанийн хэлбэр: Хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.

4.Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болохоо толгой, хараат, охин, зэргэлдээ гэсэн нүднээс сонгоно.

5.Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан огноог өдөр, сар он гэсэн дарааллаар бичнэ.

6.Нэгдэлд оролцогч компаниудын эрхэлж буй үйл ажиллагааны төрлийг бичнэ.

7.Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх регистрийн дугаар, эрхлэх үйл ажиллагааны төрлийг бичнэ.

8.Байгууллагын хаяг, утас, цахим хуудас, цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллийг хүснэгтэд оруулна.

Хэсэг 3.Хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч нь иргэн бол тэдгээрийн талаарх мэдээллийг бөглөхдөө:

Иргэний овог нэр, регистрийн дугаар, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны хаяг байршил, ажил эрхлэлт, мэргэжлийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бичнэ.

1.Үүсгэн байгуулагч иргэн бүрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээллийг бөглөхдөө:

Тэдгээрийн овог нэр, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийг төгрөгөөр бичнэ.

2.Үүсгэн байгуулагч иргэний холбогдох этгээдийн байдал хэсгийг бөглөхдөө:

1.Үүсгэн байгуулагч иргэний холбогдох этгээдийг тодорхойлж, холбогдох этгээдийн овог нэр, регистрийн дугаар, ажил эрхлэлтийн байдлыг хүснэгт дэх асуулгын дагуу оруулна.

Тайлбар: Холбогдох этгээд гэдэгт Компанийн тухай хуулийн 89.2-т заасны дагуу тэдгээрийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн, тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү, тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь

эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талуудыг ойлгоно.

Хэсэг 4.Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

Оноосон нэр, хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан огноо, хуулийн этгээдийн хэлбэр, хөрөнгө оруулалтын хэлбэр, хаяг байршил, цахим хаяг зэрэг мэдээллийг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг бөглөх зааврын дагуу бичнэ.

Шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн дансны мэдээллийг оруулахдаа дансны төрлийг сонгож, банкны нэр, дансны дугаар, валютын төрөл бүрээр банкин дахь харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийг нөхнө.

1. Тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээллийг бөглөхдөө:

Хуулийн этгээд, иргэнээс үүсгэн байгуулсан хуулийн этгээдэд оруулсан хувь хөрөнгийн хэмжээг хувьцааны тоо, хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь тус бүрээр хүснэгт дэх асуулгын дагуу нөхнө. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх бөгөөд хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

2. Тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээллийг бөглөхдөө:

- Төлөөлөн удирдах зөвлөл, дотоод хяналтын нэгжтэй эсэх талаар хариултыг сонгон, тэдгээрийн бүрэлдэхүүний тоог бичнэ.
- Ажилтан албан хаагчдын тоо хэсэгт хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах болон ажиллаж буй нийт ажилтны тоог бичнэ.
- Компанийн тухай хуулийн 84.1-д заасан удирдах албан тушаалтнуудын талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу гаргах бөгөөд удирдах албан тушаалтан нь гадаадын иргэн тохиолдолд регистрийн дугаар хэсэгт гадаад паспортын дугаарыг бичнэ.

Тайлбар: Удирдах албан тушаалтан гэдэгт гүйцэтгэх удирдлага, хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаанд оролцон ажиллах /ажилладаг/ ажилтнуудын мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бөглөж, тодорхойлолтыг зааврын хавсралтын дагуу гаргах бөгөөд тодорхойлолт гаргасан этгээд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

3. Ашиглах техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээллийг бөглөхдөө:

1.Үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжийг нэр, төрөл бүрээр түүний хүчин чадал, багтаамж, тоо ширхэг, үнийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бөглөх ба тухайн тоног төхөөрөмжийг худалдаж авсан түрээсэлсэн аль нь болохыг тодорхой бичнэ. Тоног төхөөрөмжийн үнэ нь худалдан авсан өртөг байна.

2.Программ хангамжийн зориулалт баганад тухайн программыг ямар зориулалтаар ашиглах талаар бичнэ. Жишээ нь нягтлан бодох бүртгэл, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах, өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулах гэх мэт.

4. Зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг бөглөхдөө:

Тухайн үйл ажиллагааг ямар хүрээнд явуулах, эх үүсвэрийн өртөг, хүлээгдэж буй ашиг, тухайн үйл ажиллагаанаас хүртэх өгөөжийн хэмжээг зэрэгцүүлсэн он, хүснэгтэд заасан

үзүүлэлт бүрээр тоон үзүүлэлтийг өссөн дүнгээр бичих бөгөөд энэ нь бизнес төлөвлөгөөнд тусгагдсан дүнтэй ижил байна.

Б. Тусгай зөвшөөрөл хүссэн баримт бичгийг бүрдүүлэх заавар

Зөвшөөрлийн өргөдлийн маягтаар гаргасан өргөдөлд “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана:

1. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь Санхүүгийн зохицуулах хороонд албан бичгээр хүсэлт гаргаж, гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

2. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан байна.

3. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг хувьцаат компани хэлбэрээр үүсгэн байгуулах тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу үнэт цаасаа Хороонд бүртгүүлж, нийтэд санал болгон арилжаална

4. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагааны төрлөөс хамааран эзэмшигчдээс хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулсан мөнгөн хөрөнгийн хэмжээ нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байна.

5. Хувьцаа эзэмшигчдээс хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн хууль ёсны орлогоос бүрдсэн байна.

6. Компанийн тухай хуулийн 14.3 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт тус мэдээллийг заавал тусгах бөгөөд шийдвэрт хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулна.

7. Үүсгэн байгуулагчид нь хүлээх үүрэг, худалдан авах хувьцаа болон бусад үнэт цаасны ангилал, төрөл тус бүрийн тоо, үнэ, худалдан авах хугацаа зэрэг асуудлыг тусгасан хамтран ажиллах гэрээг байгуулж, хувьцаа эзэмшигчдийн гарын үсэг, хуулийн этгээдийн тамга тэмдгээр баталгаажуулна.

8. Шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний иргэний үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбарыг нотариатаар гэрчлүүлсэн байна.

9. Хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг төгрөг болон валютаар тухайн хуулийн этгээдийн банканд байршуулсан болохыг нотолж, банкны тодорхойлолтыг дансны хуулганы хамт авна

10. Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан байна.

11. Компанийн тухай хуулийн 16.2-т нийцсэн дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан байна.

12. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу зээлийн гэрээ, баталгаагаар хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, ял шийтгэлгүй, санхүү, эдийн засгийн чиглэлийн мэргэжилтэй, тухайн салбарт ажилласан туршлагатай, тохиромжтой этгээд байна.

13. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2.5-д заасны дагуу техник тоног төхөөрөмж, ажлын байр нь үйл ажиллагааны найдвартай, тогтвортой ажиллагааг хангахуйц байх бөгөөд холбогдох этгээдтэй байгуулсан гэрээ хэлцлээр харуул хамгаалалтын асуудлыг шийдвэрлэсэн байна.

14. Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хувьд гүйцэтгэх удирдлага нь гадаадын иргэн байгаа нөхцөлд байнгын мэргэжлийн орчуулагчтай байх бөгөөд тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичгийг Монгол хэл дээр орчуулж, нотариатаар баталгаажуулсан байна.

15. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1.2-т заасны дагуу хяналт тавих ажилтныг гүйцэтгэх захирлын тушаалаар томилох бөгөөд дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу боловсруулсан дотоод хяналтын хөтөлбөр нь дараах мэдээллийг агуулсан байвал зохино:

15.1. Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх журам;

15.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж болон дээрх журын хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;

15.3. Хяналт тавих ажилтныг мэргэшүүлэх сургалтад хамруулах төлөвлөгөө, арга хэмжээ;

15.4. Өөрийн харилцагч, үйлчилгээ, бүтээгдэхүүний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагч, үйлчилгээ, бүтээгдэхүүний онцгой анхаарахад чиглэсэн арга хэмжээний цогц хөтөлбөр;

Анхаарах зүйл: Дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулахдаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны нэгдүгээр сарын 14-ний өдрийн 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-тай сайтар танилцана.

16. Зохицуулалттай үйл ажиллагаатай холбоотой дотоод журмууд:

16.1. Зохицуулалттай үйл ажиллагаанд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам;

16.2. Хорооны холбогдох журмын дагуу зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх дотоод журам;

17. Гурваас доошгүй жилийн хугацаатай бизнес төлөвлөгөө:

Бизнес төлөвлөгөөг гурваас доошгүй жилийн хугацаатай боловсруулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Бизнес төлөвлөгөө нь эмх цэгцтэй, ойлгомжтой, бүлэг хэсгүүд нь уялдаа бүхий, мэдээлэл нь цаг хугацаандаа, үнэн бодитой, үр дүн нь хэмжигдэхүйц байвал зохино. Бизнес төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгасан байна.

В. Бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

1. Бизнес төлөвлөгөө гэдэг нь зохицуулалттай этгээдийн зорилго зорилтуудыг тодорхойлж, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, санхүү, төлбөрийн

чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээ авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримтыг хэлнэ.

2.Зохицуулалттай этгээд нь бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд дараах зүйлүүдийг заавал тусгасан байна. Үүнд:

2.1.үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх зорилго, баримтлах бодлого, мэргэжлийн байгууллагын хэтийн төлөв байдал;

2.2.үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхэд ашигтай байх макро болон микро төвшин дэх боломжит нөхцөлүүд;

2.3.зохицуулалттай этгээдийн тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого зарлагын 3-5 жилийн төсөөлөл;

2.4.актив, пассивын бүтэц, хэмжээ түүний удирдлагыг сайжруулах төлөвлөгөө, хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлүүд, энэ талаар баримтлах бодлого;

2.5.үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ.

3.Бизнес төлөвлөгөөг үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулна. Бизнес төлөвлөгөө нь дараах хэсгээс бүрдэнэ.

3.1.Нүүр хуудас: Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:

3.1.1.мэргэжлийн байгууллагын нэр, хаяг,

3.1.2.бизнес төлөвлөгөөний нэр,

3.1.3.хувилбарын дугаар,

3.1.4.боловсруулсан огноо,

3.1.5.зохиогчийн нэр, хаяг,

3.1.6.зохиогчийн тэмдэглэл,

3.1.7.зохицуулалттай этгээдийн удирдлагын нэр, хаяг

3.2.Гүйцэтгэлийн хураангуй: Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллагын тухай, хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэгт ямар үйлчилгээ үзүүлэх, ямар үр дүнд хүрэхийг ойлгомжтой тодорхойлсон байна.

Зорилт гэдэгт эрхэм зорилгод хүрэхийн тулд шат дараалан хэрэгжүүлэх, хугацаатай, хэмжигдэхүйц бодитой үр дүн буюу хүрэх үр дүнгээ тодорхойлсон байна.

3.3.Бизнесийн танилцуулга: Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн мэргэжлийн байгууллагын нэр, хаяг, өсөж хөгжиж ирсэн түүх, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл төлөв байдал, эрхэлж байгаа үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавх ба байдал бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх

үүсвэр, зээлийг эргэж төлөх хугацаа, үр ашиг, борлуулалтын орлого, ашиг зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм. Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- 3.3.1. бизнес ба түүний түүх,
- 3.3.2. зах зээлийн нөхцөл төлөв байдал,
- 3.3.3. одоо явуулж байгаа үйл ажиллагаа,
- 3.3.4. удирдлага боловсон хүчин,
- 3.3.5. санхүүгийн төлөв байдал,
- 3.3.6. бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго

3.4. Маркетингийн төлөвлөгөө: Бизнес төлөвлөгөөний “маркетингийн төлөвлөгөө”-нд дараах гурван хэсгийг багтаана.

3.4.1. Зах зээлийн шинжилгээ: Маркетингийн төлөвлөгөөг боловсруулахын тулд юуны түрүүнд зах зээл буюу хэрэглэгчдийнхээ тухай судалж мэдэх, өрсөлдөгчид, түншүүд, зуучлагчдынхаа талаар судлах ёстой.

3.4.2. Маркетингийн стратеги: Маркетингийн стратеги гэдэг нь зах зээл рүү хандсан төлөвлөгөө буюу амжилт олохын тулд танай байгууллагын хэрэглэж буй арга замууд.

3.4.3. Маркетингийн иж бүрдэл: Танай байгууллага зах зээл рүүгээ хандах арга зам буюу стратегиа тодорхойлсон бол одоо зах зээл дээр таатай байдал үүсгэхийн тулд байгууллагын ашигладаг хүчин зүйлс буюу маркетингийн иж бүрдлийг хэрхэн бүрдүүлэх вэ? Маркетингийн иж бүрдэлд үйлчилгээ, үнэ, идэвхжүүлэлт, хуваарилалтын талаар тусгана.

3.5. Менежментийн төлөвлөгөө: Бизнес төлөвлөгөөний энэ бүлэгт удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний хэрэгцээ зэрэг асуудлуудыг багтааж оруулна.

3.5.1. Удирдах баг: Бизнес төлөвлөгөөний энэ хэсэгт удирдах багийн гишүүд нь банк санхүү, менежментийн чиглэлээр хэр мэргэшсэн, бие биеэ орлох чадвар нь ямар болох, мэргэжил дадлага туршлагатай байх шаардлагыг хэр хангасан болон эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилсан байдал зэргийг харуулна. Удирдах багийн болон мэргэжилтэн (хуулийн зөвлөх г.м.), тэргүүлэх ажилтны (салбаруудын удирдлага г.м.) дадлага, туршлага, тухайн салбарт ажилласан байдал, үүрэг хариуцлага зэрэг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдээлэл бүхий намтрыг бизнес төлөвлөгөөндөө хавсаргах шаардлагатай. Түүнчлэн удирдах багийн гишүүн бүрийн эрх үүрэг хариуцлагыг нягт тогтоож, хэн нь хэнд захирагддаг, хэн эцсийн шийдвэр гаргадгийг зааж байгууллагын дүрэмд оруулан баталгаажуулж, төлөвлөгөөндөө хавсаргаж болно.

3.5.2. Зохион байгуулалтын бүтэц: Удирдах багийн дор зохион байгуулалтын шат дамжлага багатай, хамгийн үр ашигтай бүтцийг тогтоох нь чухал. Цөөн хүнтэй хамт олны зохион байгуулалтын бүтцийн үр ашигтай байх үндэс зарчим нь нэг удирдлагатай байх, ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдагч мэдээллээр сайн хангагддаг байх, ажилтнууд ажлынхаа үр дүнг сонирхдог байх, хяналт ил тод байх явдал болно. Энэхүү зарчмыг баримтлан зохион байгуулалтын бүтцээ тогтоож бизнес төлөвлөгөөндөө оруулна.

3.5.3. Боловсон хүчин: Энэ хэсэгт шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин тэдгээрийн тоо түүнчлэн мэргэжил дээшлүүлэх сургалтын асуудлуудыг төлөвлөнө. Энэ хэсэгт

нийт ажилтан болон шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, уг ажлыг гүйцэтгэх ажилтны тоо, нийт ажилтны сар, жилийн цалингийн хэмжээ, цалингийн шимтгэлийг тооцоолж төлөвлөнө. Сургалтад зориулсан зардал хэдийгээр гаднаас нь харахад ашиггүй мэт боловч үр ашгаа зүй ёсоор өгдөг гэдгийг анхаарвал зохистой.

3.6. Санхүүгийн төлөвлөгөө: Санхүүгийн төлөвлөгөөнд дараах хэсгүүд орно:

- 3.6.1. нийт орлогын тооцоо;
- 3.6.2. үйлт орлогын тооцоо;
- 3.6.3. ашиг/ алдагдлын тооцоо;
- 3.6.4. алдагдалгүй ажиллагааны тооцоо;
- 3.6.5. мөнгөн урсгалын тооцоо орно.

3.7. Эрсдэлийн шинжилгээ: Эрсдэлийн шинжилгээнд дараах зүйлсийг тооцно.

3.7.1. Эрсдэлийн төрлүүд: Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд 4 төрлийн үндсэн эрсдэлийг тооцоолно:

- 3.7.1.а. техник, тоног төхөөрөмжийн;
- 3.7.1.б. санхүүгийн буюу зээлийн;
- 3.7.1.в. хүний хүчин зүйлийн;
- 3.7.1.г. хууль зүйн;

3.7.2. Эрсдэлийг багасгах боломжууд: Эдгээр эрсдэлээс чухам ямар нь танай бизнест тохиолдож болох магадлал илүү вэ? Түүнийг доод хэмжээнд байлгахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих. Даатгалд хамруулж болох эрсдэлийг ангилж ямар нөхцөлөөр аль даатгалын компанитай гэрээ хийхээ тодорхойлж бичнэ. Даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дүнд мэргэжлийн байгууллагын ашигт ажиллагаа хэрхэн хадгалагдаж үлдэхийг төлөвлөсөн үр дүнтэй жишиж харьцуулна.

ГУРАВ. ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЭМЖ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЭНГИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ

А. Зөвшөөрөл хүссэн өргөдлийн маягтыг бөглөх

1. Өргөдөл гаргагчийн нэр нүдэнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дэх оноосон нэр, регистрийн дугаарыг бичнэ. Нэмэлт зөвшөөрлийн төрлийг сонгож тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, иргэний овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, сонгох тохиолдолд тохирох нүдэнд “√ ” тэмдгийг тавина.

Өргөдөл/хүсэлт гаргагч нэр нүдэнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дэх оноосон нэр, регистрийн дугаарыг бичнэ.

Өргөдөл гаргагчийг төлөөлж өргөдлийг үнэн зөв бөглөснөө баталж, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өөрийн овог, нэрийг бичиж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

2.Зөвшөөрөл төрлийг сонгохдоо: Зохицуулалттай үйл ажиллагаа нэмж эрхлэх төрлөөс тохирохыг нь сонгоно.

Хэсэг 1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд нэмж эрхлэх үйл ажиллагаа

Зохицуулалттай үйл ажиллагаа нэмж эрхлэх төрлийг сонгоно. Хэрэв тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг нэмж эрхлэх тохиолдолд үйл ажиллагааны төрлөөс хамааран тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

Хэрэв тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх гэж байгаа бол эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгож, СЗХ03001 маягтыг зааврын дагуу бөглөнө.

Хэсэг 2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах: Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах аль нь болохыг тодорхойлно.

1.Шинээр хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн оноосон нэр, засаг захиргааны албан ёсны харьяалал, улсын бүртгэлийн гэрчилгээ дэх регистрийн дугаар хуулийн

этгээдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг хувьцааны тоо, хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь тус бүрээр хүснэгт дэх асуулгын дагуу нөхнө.

2.Шинээр хувьцаа эзэмшигч нь иргэн бол иргэний овог нэр, засаг захиргааны албан ёсны харьяалал, регистрийн дугаар, хувьцаа эзэмшигчээс хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг хувьцааны тоо, хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь тус бүрээр хүснэгт дэх асуулгын дагуу нөхнө.

3.Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлтийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу нөхөж, нийт хувь хөрөнгөнд эзлэх хувийг тодорхойлно. Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн байна.

Хэсэг 3. Зохицуулалттай этгээд салбар, төлөөлөгчийн газар байгуулах

1.Салбар, **төлөөлөгчийн газрын** ерөнхий мэдээлэл хэсгийг бөглөхдөө:

1.1.Оноосон нэр хэсэгт зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг бичнэ.

1.2.Салбар, төлөөлөгчийн газар байгуулах талаар төлөөлөн удирдах зөвлөл/хувьцаа эзэмшигчид хуралдаж, шийдвэр гаргах бөгөөд хуралдсан он, сар, өдөр, шийдвэрийн дугаарыг хүснэгтийн дагуу оруулна.

1.3.Нэгжийн хэлбэрийг сонгож, үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхой бичнэ.

1.4.Салбар, **төлөөлөгчийн газрын** байршлын талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу оруулах ба энэ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд тусгагдсан хаяг байршил байна.

1.5.Салбар, **төлөөлөгчийн газрын** албан ёсны цахим хуудас, хаягийг бичнэ. Цахим хуудас байхгүй бол бөглөх шаардлагагүй.

1.6.Салбар, төлөөлөгчийн газрын боловсон хүчний мэдээллийг ажилтан тус бүрээр бөглөнө.

1.7.Ашиглах техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээллийг бөглөхдөө:

1.7.1.үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжийг нэр, төрөл бүрээр

түүний хүчин чадал, багтаамж, тоо ширхэг, үнийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бөглөх ба тухайн тоног төхөөрөмжийг худалдаж авсан түрээсэлсэн аль нь болохыг тодорхой бичнэ. Тоног төхөөрөмжийн үнэ нь худалдан авсан өртөг байна.

1.7.2.программ хангамжийн зориулалт баганад тухайн программыг ямар зориулалтаар ашиглах талаар бичнэ. Жишээ нь нягтлан бодох бүртгэл, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах, өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулах гэх мэт.

Хэсэг 4. Оноосон нэр өөрчлөх: Хуулийн этгээд нь улсын бүртгэлийн гэрчилгээ дэх оноосон нэр, регистрийн дугаар болон хуулийн этгээдийн шинэчилсэн нэр, оноосон нэрээ өөрчлөх болсон шалтгааныг тодорхой бичиж, гүйцэтгэх удирдлагын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

Хэсэг 5. Зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх удирдлага өөрчлөгдөх:

- 1.Өөрчлөлт орсон албан тушаалтны талаарх мэдээллийг хүснэгтийн дагуу гаргана.
- 2.Шинээр томилогдсон албан тушаалтны мэдээллийг хүснэгтийн дагуу гаргана.
- 3.Хүсэлт гаргагч хуулийн этгээдийг төлөөлж өргөдлийг үнэн зөв бөглөснөө баталж, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өөрийн овог, нэр, хуулийн этгээдийн нэрийг бичиж, гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тамгыг дарна.

Б. Өргөдөлд хавсаргах баримт бичиг

- 1.Зөвшөөрлийн маягтаар гаргасан өргөдөлд, зөвшөөрлийн төрлөөс хамааруулан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана.
- 2.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчилсөнтэй холбогдуулан компанийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийг тусгасан компанийн дүрмийн төсөл (дүрэм өөрчлөгдөх шаардлагатай бол).
- 3.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хувьцаа эзэмшигч нарын оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг. Хэрвээ баримт бичгийн эх хувийг хавсаргах боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргана. /Ногдол ашиг хуваарилсан талаарх шийдвэр, төлбөрийн баримт, дансны хуулга, худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, хадгаламжийн дэвтрийн хуулбар гэх мэт/
- 4.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт орж байгаа тохиолдолд энэхүү өөрчлөлтийг хийхээр шийдвэрлэсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр эсхүл түүний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
- 5.Дээр дурдсан шинэ хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бөгөөд компанийн нэгдлийн оролцогч бол нийт компанийн нэгдэлд оролцогчдын мэдээллийг гаргана.
- 6.Компанийн хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 6 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу “Тохиромжтой этгээдийн тодорхойлолт”-ыг гаргана.
- 7.Хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан компанийн хувьд компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд өөрчлөгдсөн тухай Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн тодорхойлолт, хувьцаа эзэмшигчийн дансны үлдэгдэл бүхий хуулга.

ДӨРӨВ. ХАЯГ, БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨГДӨХ ТОХИОЛДОЛД ИРҮҮЛЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

А. Маягтыг нөхөх

1.Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, иргэний овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, сонгох тохиолдолд тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

Хэсэг 1. Хаяг, байршлын өөрчлөлт: Шинэ хаяг, байршлыг тодорхой бичих бөгөөд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дүрэм болон Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан байх шаардлагатай.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ийн хоёрдугаар хавсралт

АНДЕРРАЙТЕР, ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫГ ТООЦОХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлж байгаа зохицуулалттай этгээдийн төлбөрийн чадварыг тодорхойлох аргачлал, шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоож, түүний биелэлтэд хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

1.2. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн үйл ажиллагаа эрхэлж буй зохицуулалттай этгээд нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай хууль тогтоомжид заасан хөрөнгөтэй байна.

1.3. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журам болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны “Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн заавар” болон бусад эрх зүйн актыг баримтална.

ХОЁР. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварын байдлыг тодорхойлохдоо “Хөрөнгийн зохистой харьцаа” үзүүлэлтээр тооцно.

2.2. “Хөрөнгийн зохистой харьцаа”-г тооцохдоо андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хассан дүн буюу эздийн өмчийн дүн /цаашид “өөрийн хөрөнгө” гэх/-гээс эргэлтийн бус хөрөнгийг хассан үзүүлэлтийг хараат, хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт /цаашид “урт хугацаат хөрөнгө оруулалт” гэх/, тайлант хугацааны богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөрийн нийлбэр дүн /цаашид “өр төлбөр” гэх/, компанийн элэгдлийн зардал ороогүй үндсэн үйл ажиллагааны явцад үүсэж буй үр ашгийн бууралт /цаашид “үйл ажиллагааны зардал” гэх/-ын эрсдэлээр жигнэсэн нийлбэрт хувааж тооцно.

$$\text{Хөрөнгийн Зохистой харьцаа} = \frac{\text{(Өөрийн хөрөнгө - Эргэлтийн бус хөрөнгө)}}{\text{Урт хугацаат хөрөнгө оруулалт} * x + \text{Нийт өр төлбөр} * y + \text{(Үйл ажиллагааны зардал - элэгдлийн зардал)} * z} * 100\%$$

2.3. Эрсдэл жигнэх хувь буюу x, y, z итгэлцүүрийн хэмжээг зах зээлийн нөхцөл байдал, төрөөс баримталж буй бодлоготой уялдуулан Хорооноос тогтооно.

2.4. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт нь 100 хувь буюу түүнээс их байна.

2.5. Хэрэв андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт 100 хувиас доош байвал тухайн зохицуулалттай этгээдийн төлбөр гүйцэтгэх чадвар алдагдсанд тооцно.

2.6. Андеррайтерийн компанийн хувьд дээрх үзүүлэлтээс гадна эргэлтийн хөрөнгийн хувийн жин гэсэн үзүүлэлтийг нэмж тооцно.

2.7. “Эргэлтийн хөрөнгийн хувийн жин”-г тооцохдоо нийт эргэлтийн хөрөнгийг балансын цэвэр дүн буюу нийт хөрөнгийн дүнд харьцуулж, хувиар илэрхийлэн тогтооно.

$$\text{Эргэлтийн хөрөнгийн хувийн жин} = \frac{\text{Эргэлтийн хөрөнгө}}{\text{Нийт хөрөнгө}} * 100\%$$

2.8. Андеррайтерийн компанийн эргэлтийн хөрөнгийн хувийн жин нь 70 хувь буюу түүнээс дээш байна.

2.9. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компани нь хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн тайлан дээр үндэслэн энэхүү журмын 2.2, 2.7-д заасан нөхцөлөөр, журмын хавсралтад заасан маягтын дагуу өөрийн төлбөрийн чадварын үзүүлэлтийг тооцно.

2.10. Төлбөрийн чадварын үзүүлэлтийг тооцсон баримт дээр тухайн зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал, түүнийг орлож буй этгээд болон нягтлан бодогч гарын үсэг зурж, компанийн тамга дарж баталгаажуулан Хороо болон өөрийн гишүүнчлэл бүхий өөрийгөө зохицуулах байгууллагад хүргүүлнэ.

2.11. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн гишүүнчлэлтэй өөрийгөө зохицуулах байгууллага нь гишүүн компанийн санхүү, төлбөрийн чадварын байдалд байнгын хяналт тавих, тэдгээрийн мэргэжлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авах үүрэгтэй.

2.12. Тухайн андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компани нь төлбөрийн чадваргүй болсонд тооцогдож болзошгүй, эсхүл төлбөрийн чадваргүй болсон бол энэ талаар тус компанийн гишүүн өөрийгөө зохицуулах байгууллагаас Хороонд ажлын 2 өдөрт багтаан, албан бичгээр мэдэгдэх үүрэг хүлээнэ.

2.13. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компани нь холбогдох журамд заасны дагуу эхний хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхдээ төлбөрийн чадварын үзүүлэлтийн тайланг хавсарган ирүүлнэ.

2.14. Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд улирлаарх төлбөрийн чадварын үзүүлэлтийн тайлан болон санхүүгийн тайланг цаасан болон цахим хэлбэрээр андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компани нь Хороонд ирүүлэх үүрэгтэй.

ГУРАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

3.1. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцсон ажиллагаанд тухайн компанийн гишүүнчлэлтэй өөрийгөө зохицуулах байгууллага болон Хорооны Хяналт шалгалт хариуцсан нэгж хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл газар дээрх шалгалтыг хийнэ.

3.2. Төлбөрийн чадваргүй болсонд тооцогдож болзошгүй, эсхүл төлбөрийн чадваргүй болсон талаарх анх мэдэгдэл ирүүлсэн, эсхүл хяналт шалгалтын дүнд тогтоогдсон тохиолдолд Хорооноос дараах арга хэмжээг авна. Үүнд:

3.2.1. албан бичгээр анхааруулах;

3.2.2. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийг шаардах.

3.3. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компани Хорооноос тогтоосон төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг гурван санхүүгийн тайлангийн жил дараалан хангаж ажиллаагүй

~~тохиолдолд тухайн компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авна.~~

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 378 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.4. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-- ооОоо --

“Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн
төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам”-
ын хавсралт

“.....” ХХК-ИЙН 20.. ОНЫ ... ХАГАС ЖИЛ/ЖИЛИЙН ЭЦСИЙН
ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Итгэлцүүр (хувь)	Тооцсон дүн (төгрөг)
1	Нийт хөрөнгө		
2	Өөрийн хөрөнгө		
3	Эргэлтийн бус хөрөнгө		
4	Урт хугацаат хөрөнгө оруулалт * x	(x = 100)	
5	(Урт хугацаат өр төлбөр + Богино хугацаат өр төлбөр) * y	(y = 100)	
6	(Үйл ажиллагааны зардал - элэгдлийн зардал) * z	(z = 100)	
7	Хөрөнгийн зохистой харьцаа /(2-3)/(4+5+6)x100%≥100%/		
8	Эргэлтийн хөрөнгө /андеррайтерийн компанийн хувьд/		
9	Эргэлтийн хөрөнгийн хөрөнгийн хувийн жин /8/1x100%/≥70%/		

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал: _____ огноо _____

Нягтлан бодогч: _____ огноо _____

/тамга/ гарын үсэг/

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ын гуравдугаар хавсралт

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны эрсдэл буюу тухайн компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор албан тушаалтны санаатай болон санамсар болгоомжгүй үйлдэл болон тухайн зохицуулалттай этгээдийн дотоод хяналтын тогтолцоо муугийн улмаас харилцагч, хөрөнгө оруулагчдад учруулсан хохирлыг нөхөн барагдуулах зорилгоор эрсдэлийн санг бүрдүүлэх, түүний хөрөнгийг хадгалах, ашиглах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ САНГ БАЙГУУЛАХ

2.1. Хорооноос үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан зохицуулалттай этгээд нь өөрсдийн харилцагч, хөрөнгө оруулагчдыг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор үйл ажиллагааны эрсдэлийн санг байгуулна.

2.2. Брокер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх компани нь үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах санг Хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д заасны дагуу компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 3-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр байгуулна.

2.3. Эрсдэлээс хамгаалах сангийн 30.0 хүртлэх сая төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, үлдсэн хэсгийг Хөрөнгийн биржийн ТОП-20 индекст багтсан ХК-ийн хувьцаа, Засгийн газрын богино хугацаат өрийн бичгээр бүрдүүлж болно.

2.4. Үйл ажиллагааны эрсдэлийн сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкинд тусгайлсан данс нээж, тогтмол байршуулах бөгөөд сангийн үлдэгдлийн талаарх мэдээллийг улирал тутам Хороонд хүргүүлнэ.

2.5. Компанийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашиг, хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр эрсдэлийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх бөгөөд түүнийг нэмэгдүүлэх эх үүсвэрийн тооцоолол, үндэслэлийг гүйцэтгэх захирлын өргөн мэдүүлснээр компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр баталгаажуулна.

2.6. Үйл ажиллагааны эрсдэлийн сангийн хөрөнгийг зөвхөн компани, түүний албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас харилцагч, хөрөнгө оруулагчид учруулсан хохирлыг барагдуулахад зарцуулах бөгөөд компани өөрийн бусад хөрөнгөөр барагдуулж болох ба Хорооны Улсын байцаагчийн албан шаардлагаар үүрэг болгосон тохиолдолд ажлын 5 өдрийн дотор барагдуулна.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН САНГИЙН БҮРТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг Хорооны нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн зааврын дагуу балансын активын эргэлтийн хөрөнгө хэсэгт бүртгэнэ.

3.2. Зохицуулалттай этгээд нь үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.2.1. Компани таван жилийн бизнес төлөвлөгөөндөө үйл ажиллагааны эрсдэлийг хэрхэн удирдах талаар тодорхой тусгаж, түүний хэрэгжилт, явцын байдалд ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигч/ болон дотоод хяналт хариуцсан ажилтан байнгын хяналт тавьж ажиллах;

3.2.2. Компанийн дотоод хяналтын ажилтны үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, үр ашигтай хяналтын тогтолцоог бүрдүүлэх, ажлын сахилга, хариуцлагыг дотоод хяналтын журмаар нарийвчлан зохицуулж, түүнийг мөрдүүлэх чиглэлээр компанийн удирдлагаас тогтмол анхаарч, жил тутам дотоод үнэлгээ хийж, дүгнэлтийг Хороонд ирүүлэх;

3.2.3. Компанийн удирдлагаас ажилтнуудынхаа үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах.

3.3. Компанийн дотоод хяналтын ажилтан нь үйл ажиллагааны эрсдэлийн сангийн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, хяналтыг зохион байгуулна.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН САНГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, САНГИЙН ХӨРӨНГИЙГ НӨХӨН БАЙРШУУЛАХ

4.1. Үйл ажиллагааны эрсдэлийн сангийн хөрөнгийг зөвхөн энэхүү журамд заасан зорилгоор захиран зарцуулж, ашиглана.

4.2. Харилцагч, хөрөнгө оруулагч нь зохицуулалттай этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас хууль ёсны эрх ашиг нь зөрчигдсөн гэж үзвэл зохицуулалттай этгээдийн удирдах албан тушаалтанд, шаардлагатай гэж үзвэл Хороонд хандаж өргөдөл гаргана.

4.3. Өөрийн компанийн буруутай үйл ажиллагааны улмаас харилцагч, хөрөнгө оруулагчид хохирол учруулсан болох нь тогтоогдвол дотоод хяналтын ажилтан гүйцэтгэх удирдлагад танилцуулан хохирлыг барагдуулах арга хэмжээг цаг тухайд авч хэрэгжүүлнэ.

4.4. Энэ журмын 4.3-т заасан арга хэмжээ, Хорооны Улсын байцаагчийн албан шаардлагаар үйл ажиллагааны эрсдэлийн сангаас харилцагч, хөрөнгө оруулагчид учруулсан хохирлыг барагдуулсан нөхцөлд сангийн хөрөнгийг нөхөн бүрдүүлж, энэ талаарх холбогдох баримтыг Хороонд ирүүлнэ.

4.5. Энэ журмын 4.4-т заасан нөхцөл байдал үүсэж, үйл ажиллагааны эрсдэлийн сангийн мөнгөн хөрөнгө энэхүү журамд заасан хэмжээнээс багассан тохиолдолд ажлын 5 өдрийн дотор тогтоосон хэмжээнд нөхөн бүрдүүлнэ.

4.6. Улсын байцаагчийн албан шаардлагаар хохирол барагдуулах үүрэг даалгаврыг биелүүлээгүй, эсхүл сангийн хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан хугацаанд нөхөн байршуулаагүй тохиолдолд брокер, дилерийн компанийн үнэт цаасны арилжаанд орох эрхийг түр хугацаагаар зогсоож, зөрчлөө арилгах арга хэмжээ авахуулна.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ийн дөрөвдүгээр хавсралт т

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДЭЭС МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл ирүүлэх үүрэг хүлээсэн этгээд /цаашид “мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээд” гэх/-ээс ирүүлэх мэдээллийн төрөл, хугацаа, түүнийг хянах, ашиглах, хадгалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээд нь энэхүү журамд заасан мэдээллийг хавсралтад заасан маягтын дагуу үнэн зөв бэлтгэж, долоо хоног бүр, сар бүр ирүүлэх мэдээллийг цахим хэлбэрээр, тухай бүр болон улирал бүр ирүүлэх мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр Хороонд ирүүлнэ.

1.3. Энэ журамд заасан тухай бүр ирүүлэх мэдээллийг ажлын 10 өдөрт, 7 хоногийн мэдээллийг дараа долоо хоногийн Лхагва гаригт, сарын мэдээллийг дараа сарын 10-ны өдөрт, улирлын мэдээллийг дараа улирлын эхний сарын 10-ны өдөрт тус тус багтаан Хороонд ирүүлнэ.

1.4. Цахим хэлбэрээр ирүүлэхдээ Хорооны албан ёсны цахим хуудаст байрлах “Цахим тайлан” цэсээр дамжуулан, тайлан хүлээн авах зориулалт бүхий системд ирүүлнэ.

1.5. Энэ журмаар тогтоосон хугацаанд ирүүлсэн арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан, кастодиан, брокер, дилер, андеррайтерийн үйлчилгээний талаарх мэдээллүүдийг бүрдүүлэх, боловсруулах, хянах, ашиглах үүргийг Үнэт цаасны бодлого, зохицуулалт хариуцсан нэгж, Хяналт шалгалт, зохицуулалт хариуцсан нэгж, Судалгаа, эрсдэлийн шинжилгээ хариуцсан нэгж, мэдээллийг нэгдсэн серверт хадгалах, найдвартай байдлыг хангах үүргийг Хорооны Мэдээллийн технологи хариуцсан нэгж тус тус хариуцна.

ХОЁР. МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ

2.1. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.11 дэх заалтад заасан үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан этгээд нь энэ журмын нэгдүгээр хавсралт дахь МС-1 маягтад заасан мэдээллийг ирүүлнэ.

2.2. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.9 дэх заалтад заасан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээд нь энэ журмын хоёрдугаар хавсралт дахь МС-2 маягтад заасан мэдээллийг ирүүлнэ.

2.3. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.7, 24.1.8 дахь заалтад заасан үнэт цаасны төлбөр, тооцооны тусгай зөвшөөрлийг авсан этгээд нь энэ журмын гуравдугаар хавсралт дахь МС-3 маягтад заасан мэдээллийг ирүүлнэ.

2.4. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1, 24.1.2, 24.1.3, 24.1.4, 24.1.5, 24.1.12, 24.1.13 дахь заалтад заасан үнэт цаасны брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, үнэт цаасны итгэмжлэн удирдах, андеррайтер, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан этгээд нь энэ журмын дөрөвдүгээр хавсралт дахь МС-4 маягтад заасан мэдээллийг ирүүлнэ.

2.5. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.10 дахь заалтад заасан кастодианы тусгай зөвшөөрлийг авсан этгээд нь энэ журмын тавдугаар хавсралт дахь МС-5 маягтад заасан мэдээллийг ирүүлнэ.

2.6. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч нь энэ журмын зургаадугаар хавсралт дахь МС-6 маягтад заасан мэдээллийг ирүүлнэ.

2.7. Мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдээс ирүүлсэн мэдээллийг доорх хэлбэрээр хянана.

2.7.1. мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд гаргаж ирүүлсэн эсэх;

2.7.2. тухайн мэдээллийг өмнө нь өгч байсан бол түүнтэй нийцэж буй эсэх;

2.7.3. мэдээллийг маягтын дагуу бүрэн ирүүлсэн эсэх;

2.7.4. шаардлагатай гэж үзсэн бусад ажиллагаа.

2.8. Мэдээллийн санд ирүүлсэн мэдээлэлтэй холбоотой хяналтыг Хяналт шалгалт, зохицуулалт хариуцсан нэгжийн мэдээлэл хариуцсан хянан шалгагч /цаашид “мэдээлэл хариуцсан ажилтан” гэх/ гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт, шалгалтыг удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.

2.9. Маягтын дагуу гаргаагүй, бүрдэл дутуу мэдээллийг ирүүлсэнд тооцохгүй бөгөөд энэ талаар албан бичгээр мэдэгдэж дахин ирүүлэхийг шаардана.

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ЗОРИУЛАЛТ

3.1. Үнэт цаасны зах зээлийн мэдээллийг салбарын тойм мэдээлэл гаргах, статистик эконометрикийн судалгаа шинжилгээ хийх, салбарын хөгжлийн бодлогыг боловсруулах, зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор ашиглана.

3.2. Үнэт цаасны зах зээлийн мэдээллийг энэхүү журмын 3.1-т зааснаас бусад хувийн зорилгоор ашиглахгүй.

3.3. Монголбанк, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, шүүх, прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагаас бичгээр хүсэлт ирүүлсэн тохиолдолд мэдээллийн нэгдсэн сангаас холбогдох мэдээллийг хүргүүлнэ.

3.4. Энэ журмын 3.3-т зааснаас гадна харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байгууллагад Хорооны нэгжийн удирдлагын зөвшөөрлөөр холбогдох мэдээллийг хүргүүлж болно.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН ХАДГАЛАЛТ

4.1. Үнэт цаасны зах зээлийн мэдээллийг цахим хэлбэрээр Хорооны нэгдсэн мэдээллийн санд, хэвлэмэл хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдийн хувийн хэрэгт тус тус хадгална.

4.2. Мэдээллийн аюулгүй байдлыг Мэдээллийн технологи хариуцсан нэгж хариуцна.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээд нь энэ журмаар заасан мэдээллийг тогтоосон хугацаанд, зохих маягтын дагуу, үнэн зөвөөр, бүрэн ирүүлээгүй тохиолдолд мэдээлэл ирүүлэх үүрэг бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

5.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--o0o--

"Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс
мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам"-ын
нэгдүгээр хавсралт

“Маягт МС-1”

Хүснэгт 1.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ /сараар/

№	Үзүүлэлтүүд	Сар бүр	Өссөн дүн
1	Арилжаа явагдсан өдөр		
2	Үнэт цаас нь бүртгэгдсэн компанийн тоо Үүнээс: Төрийн өмчийн Төрийн өмчийн оролцоотой Хувийн өмчийн		
3	Бүртгэлтэй үнэт цаасны нийт тоо ширхэг Үүнээс: Төрийн өмчийн Хувийн өмчийн		
4	Зах зээлийн нийт үнэлгээ /төгрөг/		
5	Арилжааны төрөл Үүнээс: Энгийн арилжааны үнийн дүн /төгрөг/ Багцын арилжааны үнийн дүн /төгрөг/ Тендер саналын арилжаа үнийн дүн /төгрөг/		
6	Үнэт цаасны анхдагч зах зээлийн гүйлгээний дүн /төгрөг/ Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд /анхдагч зах зээлд/ Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа /нэгж эрх/ Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл		
7	Анхдагч зах зээлийн үнэт цаасны тоо ширхэг Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл		
8	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн гүйлгээний дүн /төгрөг/ Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд /хоёрдогч зах зээлд/ Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл		

9	Хоёрдогч зах зээлд арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл		
10	Дундаж ханш Үүнээс: Компанийн хувьцаа Засгийн газрын бонд Компанийн бонд Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа Хадгаламжийн бичиг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Үүсмэл санхүүгийн хэрэгсэл		
11	Индекс Дундаж Хамгийн их Хамгийн бага Хаалт		
12	Арилжигдсан үнэт цаасны тоо Үүнээс: Ханш өссөн Ханш буурсан Ханш тогтмол		
13	Хийгдсэн хэлцэл		

Хүснэгт 1.2. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ /сараар/

№	Үнэт цаас		Нэрлэсэн үнэ	Арилжалсан тоо	Арилжааны үнийн дүн	Ханш			Арилжаа - ны огноо		Хувьцааны 5%-аас дээш хувийг худалдан авсан этгээдийн		Эзэмшсэн тоо ширхэг
	Нэр	Төрөл				Дээд	Доод	Дундаж	Эхэлсэн	Дууссан	Нэр	Дансны	

Хүснэгт 1.3. ШИНЭЭР БОЛОН НЭМЖ ҮНЭТ ЦААС ГАРГАСАН ХУВЬЦААТ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /сараар/

№	Симбол	Хувьцаат компанийн нэр	Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө		Бүртгэгдсэн хувьцааны тоо	Бүртгэгдсэн огноо
			Хувьцааны тоо ширхэг	Нийт үнийн дүн		

Хүснэгт 1.4. ХАНШИЙН ХЭЛБЭЛЗЭЛ ИХТЭЙ ҮНЭТ ЦААС /тухайн сард/

ХАНШИЙН ӨСӨЛТГЭЙ ҮНЭТ ЦААС						
№	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
			Сарын эхэнд	Сарын эцэст		
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ҮНЭТ ЦААС						
№	Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	Өөрчлөлт хувиар
			Сарын эхэнд	Сарын эцэст		
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						

Хүснэгт 1.5. НОГДОЛ АШИГ ТАРААХААР ШИЙДВЭРЛЭСЭН ХУВЬЦААТ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /сараар/

№	Компанийн нэр	Байршил	Нийт гаргасан хувьцааны тоо	Ногдол ашгийн хэмжээ /нэгж хувьцаанд, төг/	Ногдол ашгаа тараасан хэлбэр	Ногдол ашгаа тараалгасан байгууллага

Хүснэгт 1.6. АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭ /сараар/

Индекс			Салбар А			Салбар Б			Салбар В			Салбар Г		
Н	сары	өөрчлөл	Н	сары	өөрчлөл	Н	сары	өөрчлөл	Н	сары	өөрчлөл	Н	сары	өөрчлөл

Хүснэгт 1.7. ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙН ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ /тухайн сар, улирлаар/

№	Гишүүн БДК-ийн нэр	Арилжаанд оролцсон өдөр	Худалдсан үнэт цаас		Худалдан авсан үнэт цаас		Зөрчил гаргасан эсэх
			тоо ширхэг	үнийн дүн	тоо ширхэг	үнийн дүн	

Хүснэгт 1.8. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ БҮРДҮҮЛЭГЧ ХУВЬЦААТ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /сараар/

№	Компанийн нэр	Үнэт цаасны тоо ширхэг	Тухайн сарын хаалтын ханш	Зах зээлийн үнэлгээ

Хүснэгт 1.9. АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ИНДЕКСИЙН САГСАНД ОРСОН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /сараар/

№	Компанийн нэр	Үнэт цаасны тоо ширхэг	Тухайн сарын хаалтын ханш	Зах зээлийн үнэлгээ

Хүснэгт 1.10. АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭ /сараар/

Арилжааны шимтгэл	Арилжааны дүн	Худалдах захиалгын шимтгэл	Худалдан авсан захиалгын шимтгэл	Тухайн сард арилжаа эрхлэх байгууллагын дансанд төвлөрсөн шимтгэлийн орлогын дүн /төгрөг/

Жишээ нь <1,000,000,000 /нэг тэрбум төгрөг хүртэл/			
>1,000,000,000 /нэг тэрбум төгрөгөөс дээш бол/			

Хүснэгт 1.11. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ /сараар/

Салбарын ангилал		Өөрчлөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	Өсөлт, бууралт /хувиар/
Үнэлгээ буурсан салбар	Барилгын салбар		
	Уул уурхайн салбар		

	Үйлчилгээ		
	Харилцаа холбоо гэх мэт		
Үнэлгээ өссөн салбар	Үйлдвэрлэл		
	Үл хөдлөх хөрөнгө		
	Хөдөө аж ахуй гэх мэт		
Нийт дүн			

Хүснэгт 1.12. АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ /сараар/

№	Үзүүлэлтүү д	Тоо хэмжээ /ширхэг/
1	Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ хүргүүлсэн хувьцаат компани	
2	Санхүүгийн тайлангаа олон нийтэд мэдээлсэн компани	
3	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлан хуралдуулсан компанийн тоо	
4	Хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээ томилсон компани	

Хүснэгт 1.13. АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА /тухай бүр/

Үзүүлэлтүү д	Мэдээлэл
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо, гэрчилгээний дугаар	
Тусгай зөвшөөрлийн огноо, дугаар	
Байгуулагдсан огноо, шийдвэр	
Өөрчлөн байгуулагдсан огноо, шийдвэрийн дугаар	
Хувь нийлүүлсэн хөрөнгө, өмчийн хэлбэр, өмчлөгч	
ГУЗ-ийн дарга: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
ГУЗ-ийн гишүүд:	
1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
5. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
6. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
7. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын	

	туршлага	
8. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага		
Гүйцэтгэх захирал: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага		
Албадын захирлууд:		
1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага		
2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага		
3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага		

/Энэ мэдээг өөрчлөлт оруулсан тухай бүр ирүүлнэ./

Хүснэгт 1.14. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ /7 хоногоор/

Арилжаалагдсан үнэт цаас												
№	Симбол	Үнэт цаасны	Даваа /огноо/		Мягмар /огноо/		Лхагва /огноо/		Пүрэв /огноо/		Баасан /огноо/	
			г	н	г	н	г	н	г	н	г	н
Нийт												

Хүснэгт 1.15. АРИЛЖААНЫ ТАЙЛАН /7 хоногоор/

Үзүүлэлт	Арилжаа явагдсан өдөр					Нийт
	Даваа /огноо/	Мягмар /огноо/	Лхагва /огноо/	Пүрэв /огноо/	Баасан /огноо/	
Нийт арилжигдсан ширхэг						
Энгийн арилжаа						
Багцын арилжаа						
Тендер арилжаа						
Анхдагч зах зээлийн арилжаа						
Компанийн бонд /Анхдагч/						
Компанийн бонд /Хоёрдогч/						
Анхдагч зах зээлийн арилжаа /ЗГҮЦ/						
Хоёрдогч зах зээлийн арилжаа /ЗГҮЦ/						
Нийт арилжааны үнийн дүн /төг/						
Энгийн арилжаа						
Багцын арилжаа						
Тендер арилжаа						
Анхдагч зах зээлийн арилжаа						
Компанийн бонд /Анхдагч/						
Компанийн бонд /Хоёрдогч/						
Анхдагч зах зээлийн арилжаа /ЗГҮЦ/						
Хоёрдогч зах зээлийн арилжаа /ЗГҮЦ/						
Хувьцааны индекс /хаалт/						
өөрчлөлт /хувиар/						
Зах зээлийн үнэлгээ /тэрбум төг/						
өөрчлөлт /хувиар/						
Нийт хийгдсэн хэлцлийн тоо						
Арилжигдсан үнэт цаасны тоо /хувьцаа/						
Ханш өссөн						

Ханш буурсан						
Ханш тогтмол						

Хүснэгт 1.16. ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙН ГҮЙЛГЭЭ /7 хоногоор/

Огноо: оны .. сарын .. өдрөөс оны .. сарын .. өдөр хүртэл

№	Симбол	Компанийн нэр	Авсан тоо	Авсан үнийн дүн	Зарсан тоо	Зарсан үнийн дүн	Нийт	
							Тоо ширхэг	Үнийн дүн
Нийт								

Хүснэгт 1.17. ХУВЬЦААНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА /7 хоногоор/

Огноо	Үнэт цаасны нэр	Симбол	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Үнийн дүн
Нийт					

Хүснэгт 1.18. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА /7 хоногоор/

№	Арилжааны символ	Худалдан авсан ҮЦК-ийн нэр	Үнэ	Тоо ширхэг	Нийт үнийн дүн	Огноо	Хугацаа /долоо хоног/	Хүү /хувиар/
Нийт								

Хүснэгт 1.19. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА /7 хоногоор/

№	Өдөр	Үнэт цаасны нэр	Нэгж үнэ	Арилжааны ширхэг	Үнийн дүн	Хугацаа /7 хоног/	Өгөөж
Нийт							

Хүснэгт 1.20. КОМПАНИЙН БОНДЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА /7 хоногоор/

Огноо	Хугацаа /долоо хоног/	Хүү /хувиар /	Хямдруулса н үнэ	Тоо ширхэ г	Үний н дүн	Худалдан авсан ҮЦК- ийн нэр
Нийт						

"Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс
мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих
журам"-ын хоёрдугаар хавсралт
"Маягт МС-2"

Хүснэгт 2.1. ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ /сараар/

Код	Үнэт цаасны нэр	Хувьцаа эзэмшигчдийн тоо			
		1-ээс дээш хувь	5-аас дээш хувь	10 -аас дээш хувь	33.3-аас дээш хувь

Хүснэгт 2.2. ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН БҮРТГЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ /сараар/

№	Код	Үнэт цаасны нэр	Үнэт цаасны тоо /сарын эхэнд/	Бүртгэлд орсон өөрчлөлт		Үнэт цаасны тоо /сарын эцэст/	Тайлбар
				Нэмэгдсэн	Хасагдсан		

Хүснэгт 2.3. ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ ДАХЬ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭ, ҮЛДЭГДЛИЙН МЭДЭЭЛЭЛ /сараар//мянган ширхэг/

№	Мөнгөн хөрөнгийн гүйлгээ	Тухайн сард	Өссөн дүн
1	Төвлөрсөн хадгаламжийн дансаар хийгдсэн орлогын гүйлгээ Үүнээс: Харилцагчийн тоо Дансны гүйлгээ /удаа/ Үнийн дүн /төгрөг/		
2	Төвлөрсөн хадгаламжийн дансаар хийгдсэн зарлагын гүйлгээ Үүнээс: Харилцагчийн тоо Дансны гүйлгээ /удаа/ Үнийн дүн /төгрөг/		
3	Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны гүйлгээ /төгрөг/ Үүнээс: ХААН банк Голомт банк ХАС банк Худалдаа хөгжлийн банк		

Хүснэгт 2.7. ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГУУЛАХ ЗОРИЛГООР ЗЭЭЛИЙН БАРЬЦААНД ТУСГААРЛАСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭ /сараар/

№	Огноо	Зээлдэгч				Зээлдүүлэгч				Шимтгэл		Ханш	Зээлийн хүү /сараар/
		Данс	Овог, нэр	ҮЦ	Тоо	Алба	Зээл, барьд	Зээлийн	Хугаца	Нэг өдрийн	Нийт		

Хүснэгт 2.8. ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРЭЭР ҮНЭТ ЦААС ТУСГААРЛАСАН БОЛОН ЧӨЛӨӨЛСӨН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ /сараар/

Огноо	Тусгаарласан болон чөлөөлсөн үнэт цаасны нэр	Үнэт цаасны эзэмшигчийн			Тоо ширхэг	Шимтгэл	Тайлбар
		Овог нэр	Регистр	Дансны дугаар			

Хүснэгт 2.9. ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД ХАДГАЛАГДАЖ БУЙ ҮНЭТ ЦААС /сараар/ /мянган ширхэг/

Үзүүлэлт	Тухай сард	Өссөн дүн
Төрийн мэдлийн бус хувьцаа		
Төрийн мэдлийн хувьцаа		
Орон нутгийн оролцоотой компани		
Нийт хувьцааны дүн		
Засгийн газрын хямдруулсан бонд		
Компанийн бонд		
Нийт бондын дүн		
Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас /мянган ширхгээр/		
Компанийн бонд		
Засгийн газрын хямдруулсан бонд		

Хүснэгт 2.10. ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА /сараар/

Үзүүлэлтүүд	Мэдээлэл
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо, гэрчилгээний дугаар	
Тусгай зөвшөөрлийн огноо, дугаар	
Байгуулагдсан огноо, шийдвэр	
Өөрчлөн байгуулагдсан огноо, шийдвэрийн дугаар	
Хувь нийлүүлсэн хөрөнгө, өмчийн хэлбэр, өмчлөгч	
ГУЗ-ийн дарга: овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	

ТУЗ-ийн гишүүд:	
1. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
2. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
3. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	
4. овог, нэр, эрхэлж буй албан тушаал, мэргэжил, боловсрол, ажлын туршлага	

Хүснэгт 3.7. БОНДЫН ХҮҮ ҮНДСЭН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ /сараар/

Бондын төрөл	Бондын нэр	Хүү /хямдралын хэмжээ/	Нийт төлөгдөөгүй үлдэгдэл		Төлөгдсөн дүн	
			Үндсэн төлбөр	Хүү	Үндсэн төлбөр	Хүү

Хүснэгт 3.8. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ
/сараар/
/тэрбум төгрөг/

	Хийсэн гүйлгээ				Нийт гүйлгээ
	Гадаадын хуулийн этгээд	Гадаадын иргэн	Дотоодын хуулийн этгээд	Дотоодын иргэн	
Тухайн сард					
Өссөн дүнгээр					

"Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс
мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам"-ын
дөрөвдүгээр хавсралт
"Маягт МС-4"

**Хүснэгт 4.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛЖ БУЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА /тухай бүр/**

№	Байгууллагын нэр	
1	Үүсгэн байгуулагдсан огноо	
2	Компанийн улсын бүртгэлийн болон гэрчилгээний дугаар	
3	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бол гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний дугаар	
4	Тусгай зөвшөөрөл олгосон тогтоолын дугаар, гэрчилгээний дугаар	
5	Үнэт цаасны арилжаа эрхлэх ямар байгууллагын гишүүн болох	
6	Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээний төрөл, явуулсан хугацаа	
7	Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, хувь, нэрлэсэн үнэ	
8	Орон нутагт салбар үйл ажиллагаа эрхэлдэг эсэх /аймаг, сум/	
9	Нийт харилцагчийн тоо	
10	ТУЗ-ийн дарга, гишүүдийн танилцуулга: овог нэр, гэрийн хаяг, утас, цахим хаяг, мэргэжил, ажлын туршлага	
11	Гүйцэтгэх захирлын танилцуулга: овог нэр, мэргэжлийн үнэмлэхний дугаар, дуусах хугацаа, утас, цахим хаяг, мэргэжил, өмнө эрхэлж байсан ажил, албан тушаал	
12	Компанийн хаяг байршил, холбоо барих утас, цахим хаяг	
13	Сүүлийн 3 жилд арилжааны хэлцэл буцаагдаж байсан эсэх /тийм, үгүй аль нэгийг сонгож, ямар шалтгаанаар буцаагдсан талаар тайлбар бичих	
14	Сүүлийн 3 жилд Хороо, Арилжаа эрхлэх байгууллагаас компани болон ажилтанд хариуцлага хүлээлгэж байсан эсэх /хүлээлгэсэн огноо, шийтгэлийн төрөл, ямар зөрчилд оногдуулсан тайлбар/	

/Энэ мэдээг өөрчлөлт оруулсан тухай бүр ирүүлнэ./

**Хүснэгт 4.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛЖ БУЙ АНДЕРРАЙТЕР, БРОКЕР, ДИЛЕР, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ,
МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТАНИЛЦУУЛГА /тухай бүр/**

№	Регистрийн дугаар	Овог	Нэр	Албан тушаал	Төгссөн сургууль, мэргэжил	ҮЦЗЗ дээр ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхний дугаар, дуусах хугацаа	Холбоо барих утас

/Энэ мэдээг өөрчлөлт оруулсан тухай бүр ирүүлнэ./

Хүснэгт 4.3. АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ /улирал бүр/

Үйлчлүүлэгчийн нэр	Үзүүлэхээр гэрээ байгуулсан үйлчилгээний хэлбэр	Бусад этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан бол	
		Хамтран ажиллах чиглэл	Этгээдийн нэр

Андеррайтерийн үйлчилгээний гэрээний биелэлтийн тухай мэдээлэл:

Хүснэгт 4.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /улирал бүр/

№	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ААН	Үйлчилгээний төлбөрийн хэмжээ	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн иргэн	Үйлчилгээний төлбөрийн хэмжээ

Хүснэгт 4.5. ДИЛЕРИЙН КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙСЭН АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ /улирал бүр/

Худалдан авсан			Худалдсан		
Үнэт цаасны нэр	Тоо	Үнийн дүн	Үнэт цаасны нэр	Тоо	Үнийн дүн

Хүснэгт 4.6. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, АЖИЛТНУУДЫН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ /улирал бүр/

№	Эрх бүхий албан тушаалтан, ажилтны овог нэр	Албан тушаал	Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар	Холбогдох этгээдүүдийн /эхнэр, нөхөр, хүүхэд гэх мэт/ овог, нэр	Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар
		ГУЗ-ийн дарга, гишүүд			

		Гүйцэтгэх захирал			
		Брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх гэх мэт			

Тайлбар: Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтан ажилтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх болон бусад захирлууд, газар хэлтэс, тасаг албадын дарга нар салбар төлөөлөгчийн газрын дарга нар, ажилтанд брокер, дилер, нягтлан бодогчоор ажиллаж буй хүмүүс хамаарна.

Хүснэгт 4.7. КОМПАНИЙН САЛБАР/ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ
/улирал бүр/

№	Код	Компанийн нэр	Үйлчилгээ үзүүлэх эрхтэй орон нутаг	Компанийн үндсэн хаяг, утас	Салбарын хаяг	Салбарын захирлын нэр, холбоо барих утас	Брокерийн нэр, холбоо барих утас

Хүснэгт 4.8. ГАДААД УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХАД ЗУУЧЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БРОКЕРИЙН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /улирал бүр/

№	Брокерийн компанийн нэр	Зөвшөөрөл олгосон тогтоолын дугаар	Гадаадын зуучлагч брокерийн компани	Арилжаа хийгдсэн бирж	Харилцагчийн тоо	Арилжаа дүн /төгрөг/

Хүснэгт 4.9. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ /улирал бүр/

Удирдаж байгаа сангийн		Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрчлөлт орсон байдал /тайлбар бичнэ/
Цэвэр актив /төгрөг/	Активын цэвэр өртгийн хэмжээ /төгрөг/	

"Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс
мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам"-ын тавдугаар хавсралт
"Маягт МС-5"

Хүснэгт 5.1. ХАРИЛЦАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ /Сар бүр/

Үзүүлэлт			Харилцагчдын тоо
Харилцагч	Иргэн	Гадаад	
		Дотоод	
	Аж ахуйн нэгж	Гадаад	
		Дотоод	
Нийт харилцагчдын тоо			

Хүснэгт 5.2. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ ХӨРӨНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ /сар бүр/

Үзүүлэлтүүд			Төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн
Харилцагчдын эзэмшиж буй үнэт цаас	Хувьцаа	Нээлттэй ХК	Дотоод		
			Гадаад		
		Хаалттай ХК	Дотоод		
			Гадаад		
		ЗГҮЦ	Дотоод		
			Гадаад		
		Компанийн бонд	Дотоод		
			Гадаад		
		Орон нутгийн өрийн хэрэгсэл	Дотоод		
			Гадаад		
Мөнгөн хөрөнгө	Үндэсний валют	Төгрөг			
	Гадаад валют	Ам.доллар			
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	Үнэт цаас	Барьцаат			
		Баталгаат			
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	Гэрээнүүд	Зохицуулалттай зах зээл	Фьючерс, опцион, варрант		
		Биржийн бус зах зээл	Форвард, своп, опцион		
Уул уурхайн бүтээгдэхүүн	Үнэт металл	Алт, мөнгө	Грамм		
	Бусад	Арилжаалах боломжтой	Тонн		
Үл хөдлөх эд хөрөнгө	Эзэмших эрх	Гэрчилгээ			

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... тогтоолоор
 баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл
 ажиллагааны багц журам”-ийн дөрөвдүгээр хавсралтаар баталсан
 “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс
 мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын зургаадугаар хавсралт
 “Маягт МС-6”

Хүснэгт 6.1. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ /сараар/

№	Үзүүлэлтүү д	Сар	Өссөн дүнгээр
1	Баталгаат үнэт цаасны нийт хэмжээ		
1.1	Энгийн баталгаат үнэт цаас /төгрөг/		
1.2	Давуу эрхтэй баталгаат үнэт цаас /төгрөг/		
2	Баталгаат үнэт цаасны тоо		
2.1	Энгийн баталгаат үнэт цаас /ширхэг/		
2.2	Давуу эрхтэй баталгаат үнэт цаас /ширхэг/		
3	Баталгаат үнэт цаасны жилийн хүү		
3.1	Энгийн баталгаат үнэт цаас /хувь/		
3.2	Давуу эрхтэй баталгаат үнэт цаас /хувь/		
4	Баталгаат үнэт цаасны үндсэн төлбөрийн дүн		
4.1	Энгийн баталгаат үнэт цаас /төгрөг/		
4.2	Давуу эрхтэй баталгаат үнэт цаас /төгрөг/		
5	Баталгаат үнэт цаас гаргагчийн тоо		
6	Зээлдэгчийн тоо		
7	Барьцаат хөрөнгийн үнэлгээ		
7.1	Үндсэн барьцаат хөрөнгийн үнэлгээ		
7.2	Нэмэлт барьцаат хөрөнгийн үнэлгээ		
8	Барьцаат хөрөнгийн тоо		
8.1	Үндсэн барьцаат хөрөнгийн тоо		
8.2	Нэмэлт барьцаат хөрөнгийн тоо		

Хүснэгт 6.2. ХОРООНД БҮРТГҮҮЛСЭН БАРЬЦААТ ХӨРӨНГИЙН ТОО /сараар/

№	Он	Сар	Өссөн дүнгээр
1	Нийт хөрөнгийн тоо		
2	Баруун бүсийн аймгууд		
2.1			
3	Хангайн бүсийн аймгууд		
3.1			
4	Төвийн бүсийн аймгууд		
4.1			
5	Зүүн бүсийн аймгууд		

5.1			
6	Улаанбаатар хотын дүүргүүд		
6.1			

Хүснэгт 6.3. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ
/сараар/

Хуулийн этгээдийн нэр (тусгай зориулалтын компани)	Нийт гаргасан Баталгаат үнэт цаас /тэрбум төгрөг/	“ҮЦТХТ” ХХК- д Бүртгэгдсэн үнэт цаас /тэрбум төгрөг/	Зээлдэг - чийн тоо	Тайлант хугацааны үлдэгдэл /тэрбум төгрөг/	Төлөгдсөн үндсэн төлбөр /тэрбум төгрөг/

Хүснэгт 6.4. БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ/сараар/

Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ /төгрөг/	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ /төгрөг/	Эзлэх хувь
Энгийн баталгаат үнэт цаас						
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас						
Нийт						

Хүснэгт 6.5. ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ
/сараар/

№	Анхны үүрэг гүйцэтгэгч	Зээлийн багц хөрөнгө /төгрөг/	Нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ	Зээлийн дансны тоо

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ын тавдугаар хавсралт

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭД, ҮНЭТ ЦААС ГАРГАГЧААС ЗАР СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчдаас нийтэд санал болгон үнэт цаас гаргахтай холбоотой зар сурталчилгаа явуулахад тавигдах шаардлагыг тодорхойлох, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ЗАР СУРТАЛЧИЛГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчийн зар сурталчилгаа нь Зар сурталчилгааны тухай хуулийн 6.2, 6.3-т заасан шаардлагаас гадна зар сурталчилгаа захиалагчийн нэр, түүнтэй холбоо барих хаяг, утас зэрэг мэдээллийг заавал агуулсан байна.

2.2. Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч нь олон нийтэд хандсан зар сурталчилгаа хүргэхдээ үнэт цаасны арилжаа болон үнэт цаасыг нийтэд худалдахаар санал болгох явцад, эрхэлж буй үйл ажиллагааны талаар болон үнэт цаасны бүрдүүлбэр, гаргасан нөхцөл, уг үнэт цаастай холбоотой бусад хэлцлийн талаар үнэн зөв, бодитой, бүрэн гүйцэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

2.3. Зар сурталчилгаанд үнэт цаасны арилжаанаас олсон орлого, үнэт цаасны зах зээлд оролцогчдын өнгөрсөн хугацаанд олсон ашгийн талаарх мэдээллийг ашигласан тохиолдолд өнгөрсөн хугацаанд олсон орлого, ашгийн хэмжээ нь ирээдүйд олох орлогын баталгаа биш болох талаар заавал дурдсан байна.

2.4. Зар сурталчилгаа нь тухайн зар сурталчилгааг захиалагчидтай ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй эсхүл, ижил төрлийн үнэт цаас гаргасан зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчийн сул талыг агуулаагүй байна.

2.5. Хэрэв зар сурталчилгаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийн талаар ямар нэгэн мэдээлэл орсон тохиолдолд харилцагч, хөрөнгө оруулагчийн ирээдүйд олж болох орлогод нөлөөлөх нөхцөл байдал, тэдгээрийн төлөх нийт зардлын талаар бүрэн мэдээллийг тусгах үүрэгтэй.

2.6. Холбогдох хууль тогтоомжийн дагуу нийтэд нээлттэй байх бүхий л мэдээлэл, Хороо болон бусад этгээдийн үйл ажиллагааны явцад нийтэд ил болгосон мэдээ мэдээлэл, нийтэд санал болгон үнэт цаас гаргасан талаарх болон уг үнэт цаасанд хуваарилахаар шийдвэрлэсэн болон хуваарилсан ногдол ашгийн талаарх мэдээллийг зар сурталчилгаанд тооцохгүй.

2.7. Зар сурталчилгаа захиалагчид зар сурталчилгааг бүтээх, түгээх үйл ажиллагааны үед Зар сурталчилгааны тухай хуулийн 17.2 дахь хэсгийг баримтална.

ГУРАВ. ЗАР СУРТАЛЧИЛГААНД ХЯНАЛТ ТАВИХ

3.1. Энэ журмын 2 дугаар бүлэг болох Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчийн зар сурталчилгаанд тавигдах шаардлагыг биелүүлж буй байдалд зохицуулалттай этгээдийн гишүүнээр элссэн өөрийгөө зохицуулах байгууллага хяналт тавина.

3.2. Өөрийгөө зохицуулах байгууллага нь тухайн зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчийн зар сурталчилгааг Зар сурталчилгааны тухай хууль болон энэхүү журмыг зөрчсөн гэж үзсэн тохиолдолд Хороонд мэдээлнэ.

3.3. Хуулиар хориглосон зар сурталчилгаа явуулсан эсэх талаар өөрийгөө зохицуулах байгууллагын үндэслэл бүхий мэдээлэлд Хороо хяналт тавьж, хуулийн дагуу арга хэмжээ авна.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны тогтоолоор баталсан
“Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл
ажиллагааны багц журам”-ын зургаадугаар хавсралт

ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДСЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ БУСДАД БЭЛЭГЛЭХ, ӨВЛҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэл, өв залгамжлалын журмаар шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмын 1.1-д заасан харилцааг зохицуулахад Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ журмыг мөрдлөг болгоно.

1.3. Энэхүү журам нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэхээс бусад арга, хэлбэрээр үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад шилжүүлэхтэй холбогдсон харилцаанд үйлчлэхгүй.

1.4. Энэхүү журамд зааснаас бусад нарийвчилсан харилцааг зохицуулах журмыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд баталж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оор батламжлуулна.

1.5. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг гагцхүү тухайн үнэт цаасыг өмчлөгч, эсхүл түүний эрх олгосон итгэмжлэгдсэн төлөөлөгч бусдад бэлэглэж болно. Тухайн үнэт цаасыг өмчлөх эрхгүй буюу хууль ёсны өмчлөгчийг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлөх эрхгүй этгээд үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

1.6. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэл, эсхүл өв залгамжлалын журмаар шилжүүлэн авч байгаа иргэн, хуулийн этгээд нь үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагад өөрийн нэр дээр урьдчилан данс нээлгэсэн байх ба үйлчилгээний шимтгэл төлөхөд хангалттай хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан байна.

ХОЁР. ХОРОО БОЛОН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Хороо дараах эрх, үүргийг хүлээнэ:

2.1.1. Хороо шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулна;

2.1.2. хянан шалгалтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу арга хэмжээ авна;

2.2. Үнэт цаасны төлбөр, тооцоо, хадгаламж болон кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээд дараах эрх үүргийг хүлээнэ:

2.2.1. үнэт цаасны төлбөр, тооцоо, хадгаламж, кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэл болон өв залгамжлалын журмаар шилжүүлэх үйлчилгээний шимтгэлийг дотооддоо тогтоож мөрдүүлнэ;

2.2.2. энэхүү журмын 2.2.1-д заасан үйлчилгээний шимтгэлийг тогтоосон үнийн

дүнгээр болон тогтоосон хувь хэмжээгээр тооцон авна;

2.2.3.үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон шаардлагыг хангасан үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэл, эсхүл өв залгамжлалын замаар шилжүүлсэн тухай бүртгэлийг хийж, тухай бүр үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллагад мэдээллэнэ;

2.2.4.үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь энэхүү журмын 2.2.3-д заасан мэдээлэлд үндэслэн холбогдох ажиллагааг хэрэгжүүлэхдээ үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх эзэмшигчээс үйлчилгээний шимтгэл тооцохгүй;

2.2.5.үнэт цаасны төлбөр, тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэл болон өв залгамжлалын журмаар бусдад шилжүүлсэн аливаа гүйлгээний талаарх дараах мэдээллийг гүйлгээ хийснээс хойш ажлын 1 өдрийн дотор нийтийн хүртээл болгох үүрэгтэй:

2.2.5.1.үнэт цаас гаргагчийн оноосон нэр, үнэт цаасны нэр, төрөл, код;

2.2.5.2.өмчлөх эрх шилжсэн арга;

2.2.5.3.өмчлөх эрх шилжсэн үнэт цаасны тоо;

2.2.5.4.өмчлөх эрх шилжсэн үнэт цаасны нийт дүн нь тухайн үнэт цаасыг гаргасан хуулийн этгээдийн нийт гаргасан үнэт цаасны хэдэн хувийг эзэлж буй тухай.

ГУРАВ. ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДСЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ БУСДАД БЭЛЭГЛЭХ

3.1.Бэлэглэж буй үнэт цаасыг өмчлөх эрх нь тухайн үнэт цаасны өмчлөгчийн бүртгэлд үнэт цаасны төлбөр, тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх болон кастодианы байгууллага, өөрчлөлт оруулж бэлэг хүлээн авагчийн нэр дээр өмчлөх эрхийг бүртгэсэнээр шилжинэ.

3.2.Бэлэглэгч иргэн нь өөрийн эхнэр, эсхүл нөхөр, өөрийн болон эхнэр, эсхүл нөхрийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, авга, нагац, ах, эгч, дүү, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхэд, ач зээ, тэдгээрийн хүүхэд зэрэг төрөл, садангийн хүнээс гадна хүргэн, бэрд бэлэглэж байгаа бол дараах баримт бичгийг бүрдүүлсний үндсэн дээр өмчлөх эрхийг шилжүүлэх хүсэлтийг гаргана:

3.2.1.талуудын хооронд бичгээр байгуулсан бэлэглэлийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.2.2.бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийн хүсэлт, мэдэгдэл (энэхүү журмын 1 дүгээр хавсралт ёсоор батлагдсан маягтын дагуу гаргана);

3.2.3.энэхүү журмын 3.2-т заасан төрөл садангийн талаарх иргэний бүртгэлийн байгууллагын лавлагаа, эсхүл уг холбоог нотлох бусад баримт;

3.2.4.шаардлагатай бусад.

3.3.Бэлэглэгч нь энэхүү журмын 3.2-т зааснаас бусад иргэн, хуулийн этгээдэд бэлэглэж байгаа бол дараах бичиг баримтыг бүрдүүлсний үндсэн дээр өмчлөх эрхийг шилжүүлэх хүсэлтийг гаргана:

3.3.1. талуудын хооронд бичгээр байгуулсан бэлэглэлийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.3.2. бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийн хүсэлт, мэдэгдэл (энэхүү журмын 1 дүгээр хавсралт ёсоор батлагдсан маягтын дагуу гаргана);

3.3.3. бэлэглэгч нь компани бөгөөд тухайн бэлэглэл нь их хэмжээний буюу сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохоор бол холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр.

3.4. Энэ журмын 3.2.1, 3.3.1-г заасан бэлэглэлийн гэрээнд дараахь зүйлийг заавал тусгана:

3.4.1. бэлэглэгч болон бэлэг хүлээн авагчийн овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суух хаяг, холбоо барих утасны дугаар (хуулийн этгээд бол оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, оршин суух хаяг болон холбоо барих утасны дугаар), талуудын дансны дугаар;

3.4.2. бэлэглэж буй үнэт цаасны төрөл, тоо;

3.4.3. бэлэглэж буй үнэт цаас нь бусдад худалдагдаагүй, барьцаалагдаагүй, битүүмжлэгдээгүй тухай мэдэгдэл.

ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДСЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ БУСДАД ӨВЛҮҮЛЭХ

4.1. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг хуульд зааснаар өвлөгч иргэн нь Иргэний хуульд заасан журмын дагуу өөрийн өвлөх эрх үүссэн болон өв нээгдсэн тухай холбогдох баримтыг үнэт цаасны төлбөр, тооцоо, кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллагад гаргаж өгөх замаар өмчлөх эрхийг өөрийн дансанд шилжүүлэн авч болно.

4.2. Үнэт цаасны төлбөр, тооцоо, кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг хуульд зааснаар өвлөгч иргэний өмчлөлд шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэхдээ Иргэний хуульд заасан журмын дагуу өв нээгдсэн эсэх, хүсэлт гаргасан иргэнд өвлөх эрх үүссэн эсэх болон тухайн үнэт цаасыг өвлөх өөр бусад эрхтэй иргэн байгаа эсэх (хууль ёсны дагуу болон гэрээслэлээр), хэрэв байгаа бол тэдгээр нь өвөөс татгалзсан эсэх зэрэг асуудлыг холбогдох баримтад үндэслэн тогтоосны үндсэн дээр гүйцэтгэнэ.

4.3. Үнэт цаасны төлбөр тооцоо, кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг гэрээслэлийн дагуу шилжүүлэхэд Иргэний хуульд заасан журмын дагуу үйлдсэн гэрээслэл, түүнд дурдсан үнэт цаасны тоо нь тухайн дансанд байгаа эсэх, өв нээгдсэн эсэх, гэрээслэлээр өв хүлээн авагч нь өвийг хүлээн авах хүсэл зоригоо илэрхийлсэн эсэх зэрэг асуудлыг холбогдох баримтад үндэслэн тогтоосны үндсэн дээр гүйцэтгэнэ.

4.4. Өв залгамжлалын журмаар шилжүүлэх үнэт цаасны тоо нь өвлүүлэгчийн дансанд байгаа үнэт цаасны тоо хэмжээнээс зөрсөн нөхцөлд үнэт цаасны төлбөр, тооцоо, кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь энэ талаар хүсэлт гаргагчид мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авна.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

5.1. Бэлэглэл болон өв залгамжлалын замаар үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг

шилжүүлэх явцад өмчлөх эрхийн талаар маргаан гарсан, эсхүл өмчлөх эрх нь тодорхойгүй, хянан шалгах шаардлагатай, эсхүл уг өмчлөх эрхтэй холбоотой эрх бүхий байгууллага шалгалт явуулж байгаа бол энэ тухай мэдсэн даруй үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж болон кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь холбогдох гүйлгээ, төлбөр тооцооны үйлчилгээг гүйцэтгэх ажиллагааг зогсоож, энэ талаар Хороонд мэдэгдэнэ.

5.2.Бэлэглэл болон өв залгамжлалын замаар үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх явцад энэхүү журмын 5.1-д заасан маргаан үүссэн тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас эцсийн шатны шийдвэр гарсан үед өмчлөх эрх шилжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

5.3.Үнэт цаасны төлбөр, тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь тухайн улирал бүрд үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрхийг бэлэглэлийн журмаар шилжүүлэх гүйлгээний талаарх тайланг энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу, өв залгамжлалын журмаар шилжүүлэх гүйлгээний талаарх тайланг энэхүү журмын 3 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу гаргаж дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

5.4.Үнэт цаасаар гэрчлэгдэх өмчлөх эрхийг бэлэглэл болон өв залгамжлалын журмаар шилжүүлэх гүйлгээ тус бүрээр тайланд тусгана.

5.5.Энэхүү журмын дагуу тодорхой компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны 5 буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлэн авсан иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөлд шилжүүлж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор Хороонд мэдэгдэх үүрэгтэй.

5.6.Компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшиж буй иргэн, хуулийн этгээд нь үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхээ бэлэглэлийн замаар бусдад шилжүүлж буй тохиолдолд энэ тухай бэлэглэлийн гэрээг байгуулахаас өмнө ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нэгээс доошгүй удаа мэдээлж, энэ талаар өөрийн бүртгэлтэй үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад болон Хороонд мэдэгдэнэ:

5.6.1.энэхүү журмын 5.6-д заасан олон нийтэд хүргэх мэдэгдэлд бэлэглэж буй үнэт цаасны төрөл, нийт бэлэглэх үнэт цаасны тоо, бэлэг хүлээн авагчийг тодорхойлсон үндэслэлийг тусгасан байна;

5.6.2.энэхүү журмын 5.6-д заасан өөрийн бүртгэлтэй үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд ирүүлэх мэдэгдэлд олон нийтэд тараасан мэдээллээс гадна бэлэглэгчийн овог, өөрийн нэр, регистрийн дугаар, /хуулийн этгээд бол оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, холбоо барих утасны дугаар, хаяг байршил/ дансны дугаарыг /хэрэв бэлэг хүлээн авагч нь тодорхой бол түүний дансны дугаарыг/ заавал тусгасан байна.

Зургаа. Хариуцлага

6.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

“Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай журам”-ын нэгдүгээр хавсралт

БЭЛЭГЛЭГЧ, БЭЛЭГ ХҮЛЭЭН АВАГЧИЙН ХҮСЭЛТ, МЭДЭГДЭЛ

Хүсэлт гаргагчийн талаарх мэдээлэл

<u>Бэлэглэгч</u>	<u>Бэлэг хүлээн авагч</u>
Иргэн/ Хуулийн этгээдийн нэр: <i>(Иргэний овог, эцгийн нэр, өөрийн нэр, Хуулийн этгээдийн оноосон нэр)</i> Иргэн/Хуулийн этгээдийн регистрийн дугаар: Иргэнийүнэмлэхний /Хуулийнэтгээдийнулсын бүртгэлийн гэрчилгээний дугаар Оршин суух хаяг: Шуудангийн хаяг: Холбоо барих утас:	Иргэн/ Хуулийн этгээдийн нэр: <i>(Иргэний овог, эцгийн нэр, өөрийн нэр, Хуулийн этгээдийн оноосон нэр)</i> Иргэн/Хуулийн этгээдийн регистрийн дугаар: Иргэнийүнэмлэхний /Хуулийнэтгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар Оршин суух хаяг: Шуудангийн хаяг: Холбоо барих утас:

Хүсэлтийн талаарх тэмдэглэл

Хүсэлт гаргагчийн мэдэгдэл

Бэлэглэгч, бэлэг хүлээн авагч бид энэхүү бэлэглэлийн үйлдлийг хийхдээ бэлэглэж буй үнэт цаастай холбоотой бусдын өмнө хүлээсэн ямар нэг /татвар, хураамж, төлбөр төлөх, ажил гүйцэтгэх, үйлдэл хийх гэх мэт/ үүргээс зайлсхийхийг зориогүй, худалдах, худалдан болон бусад ямар нэг хэлцлийг халхавчлах зорилгоор хийгээгүй болно. Энэхүү мэдэгдэл нь худал, хуулийн хүчин төгөлдөр бус байвал бидний байгуулсан хэлцлийг буцааж, бидний хүсэл зоригоос үл хамааран гүйлгээг хүчингүй болгоход татгалзах зүйлгүй бөгөөд холбогдох хохирлыг бүрэн хариуцаж, хуулийн хариуцлага хүлээхээ үүгээр мэдэгдэж байна.

Бид энэхүү хүсэлтийн дагуу үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх шилжихтэй холбоотой, хууль тогтоомжоор харилцан болон бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг бүрэн ухамсарлаж, шаардлагатай үйлдлийг зохих журмын дагуу, тогтоосон хугацаанд гүйцэтгэх болно.

ХҮСЭЛТ, МЭДЭГДЭЛ ГАРГАСАН

БЭЛЭГЛЭГЧ /

/:

(Иргэний овог, эцгийн нэр, өөрийн нэр, Хуулийн этгээдийн төлөөлөгчийн овог, нэр)
(Гарын үсэг)

БЭЛЭГ ХҮЛЭЭН АВАГЧ/

/:

(Иргэний овог, эцгийн нэр, өөрийн нэр, Хуулийн этгээдийн төлөөлөгчийн овог, нэр)
(Гарын үсэг)

Хүсэлт гаргасан хугацаа: оны дүгээр сарын-ны өдөр цаг минут

Тусгай тэмдэглэл

/Энэ хэсэгт зөвхөн үнэт цаасны төлбөр, тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажилтан тэмдэглэл үйлдэнэ./

**Хүлээн авсан ----- ийн
тушаалтай**

албан

(Үнэт цаасны хадгаламжийн байгууллагын нэр)

/

/

(овог, нэр)

(гарын үсэг)

Хүлээн авсан хугацаа: оны дүгээр сарын-ны өдөр цаг минут

Тайлан гаргасан ажилтан:

(Албан тушаал)

(Овог, нэр)

(гарын үсэг)

¹ Тайлбар: Нэг хүсэлт, мэдэгдлээр нэгээс дээш төрлийн үнэт цаас шилжүүлсэн тохиолдолд тус бүрийг харгалзах нүдэнд багтсан дэд нүд тус бүрт бичнэ.

² Тайлбар: Журмын 1.15-д заасны дагуу тогтоосон үнэ

³ Тайлбар: Журмын 2.2-т заасан холбооны талаар

“Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай журам”-ын гуравдугаар хавсралт

**ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДСЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН
ЖУРМААР ШИЛЖҮҮЛСЭН ГҮЙЛГЭЭНИЙ
.... ОНЫ ... ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН**

Тайлан гаргасан хугацаа: оны сарын..... өдөр

Тайлангийн хамарсан хугацаа: оны сарын өдрөөс оны сарынөдөр

Г	Тух	Тух	Г	Ү	Үй	Ө	Өв	Өв	Өв	Өв	Өв	Өв	Өв
Ү	айн	айн	Ү	й	лч	в	лү	лү	лү	залг	залг	зал	
й	гүй	гүй	й	л	ил	л	үлэ	үл	үл	амж	амж	гам	
л	лгээ	лгээ	л	ч	гээ	ү	гчи	эг	эг	лагч	лагч	жла	
г	гээр	гээр	г	и	ни	ү	йн	чи	чи	ийн	ийн	гчи	
э	өмч	өмч	э	л	й	л	ово	йн	йн	дан	ово	йн	
э	лөл	лөх	э	гэ	ш	эг	г,	ир	на	сны	г,	ирг	
х	шил	эрх	н	э	им	ч	нэр	гэ	сб	дуг	нэр	эни	
и	жүү	шил	и	н	тгэ	и		ни	ар	аар		й	
й	лсэ	жүү	й	и	ли	й		й	сн			бүр	
с	н	лсэ	ү	й	йн	н		бү	ы			тгэ	
э	үнэ	н	н	ш	үн	д		рт	гэ			лий	
н	т	үнэ	и	и	ий	а		гэ	рч			н	
о	цаа	тца	й	м	н	н		ли	ил			дуг	
г	сны	асн	н	тг	дү	с		йн	гээ			аар	
н	нэр,	ы	д	э	н	н		ду	ни				
о	тоо ¹	нэг	ү	л		ы		га	й				
о		жий	н	и		д		ар	ду				
		н		й		у			га				
		үнэ ²		н		га			ар				
				х		р							
				у									
				в									
				ь									

Тухайн улиралд хийгдсэн гүйлгээний нийт үнийн дүн:

Тухайн улиралд хийгдсэн гүйлгээнээс Санхүүгийн зохицуулах хороонд төлсөн зохицуулалтын үйлчилгээний хөлсний нийт үнийн дүн:

ТАМГА

Гүйцэтгэх захирал: /
/ (Овог, нэр) (гарын үсэг)

Тайлан гаргасан ажилтан:
(Албан тушаал) (Овог, нэр) / / (гарын үсэг)

¹ Тайлбар: Нэг хүсэлт, мэдэгдлээр нэгээс дээш төрлийн үнэт цаас шилжүүлсэн тохиолдолд тус бүрийг

² Тайлбар: Журмын 1.15-д заасны дагуу тогтоосон үнэ

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ын долоодугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕР, ДИЛЕР, АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭД ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд /цаашид "зохицуулалттай этгээд" гэх/-тэй холбоотой дампуурлын хэрэг үүссэн, татан буулгаж болзошгүй нөхцөл байдал бий болсонтой холбоотой харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч өөрийн үйл ажиллагаандаа Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооноос батлан гаргасан холбогдох журмыг баримтална.

1.3. Хорооноос онцгой нөхцөл байдал үүссэн гэж үзэж, эрх хүлээн авагч томилсонтой холбогдуулан тухайн зохицуулалттай этгээд шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд ийнхүү гомдол гаргасан нь эрх хүлээн авагчийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, зогсоох үндэслэл болохгүй.

ХОЁР. ХОРООНООС АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ЭРХ ХҮЛЭЭН АВАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87.1-д заасан болон дараах тохиолдолд онцгой нөхцөл байдал үүссэн гэж үзнэ:

2.1.1. Зохицуулалттай этгээд буюу хариуцагч үүргээ биелүүлж чадахгүй болсныг өөрөө мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан;

2.1.2. Хорооноос тогтоосон төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангахгүй болж тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанаас хойш 3 сарын хугацаанд зөрчлийг засаж, үзүүлэлтийг хангаагүй;

2.1.3. Хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 8 дугаар бүлэгт заасны дагуу тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон.

2.2. Энэ журмын 2.1-д заасан онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд Хорооны шийдвэрээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87.2-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх хүлээн авагчийг нэн даруй томилно.

2.3. Хорооны уг шийдвэрт дор дурдсан зүйлсийг тусгах бөгөөд шийдвэрийн талаар нийтэд мэдээлнэ.

2.3.1. Эрх хүлээн авагч томилогдсон зохицуулалттай этгээд, түүний салбарын нэр, оршин байгаа газар, хаяг;

2.3.2. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авах арга хэмжээ авах үндэслэл

2.3.3. Зохицуулалттай этгээдэд эрх хүлээн авах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх болон түүний үргэлжлэх хугацаа;

2.3.4. Хорооноос томилогдсон эрх хүлээн авагчийн овог нэр, түүнд туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүн.

2.4. Шаардлагатай гэж үзвэл Хорооны шийдвэрээр эрх хүлээн авагч болон түүнд туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөх буюу бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацааг нь сунгаж болно. Сунгах болсон шалтгаан, нөхцөлийг шийдвэрт тодорхой тусгасан байна.

2.5. Эрх хүлээн авагч нь Хорооны ажилтан, үнэт цаасны зах зээлийн ажлын туршлагатай иргэн болон хуулийн этгээд байж болох бөгөөд тухайн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

2.5.1. Хорооны ажилтан болон бусад иргэн бол:

2.5.1.1. эдийн засаг, эрх зүйн дээд боловсролтой, ажлын туршлагатай, ёс зүйн төлөвшилтэй байх;

2.5.1.2. ял шийтгэлгүй байх;

2.5.1.3. тухайн зохицуулалттай этгээдтэй бизнесийн харилцаагүй бөгөөд сонирхлын зөрчилгүй байх

2.5.1.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29, 4.1.30-д заасан этгээд биш байх;

2.5.1.5. үнэт цаасны зах зээлд 5-аас доошгүй жил ажилласан байх.

2.5.2 Эрх хүлээн авагч нь хуулийн этгээд бол энэ журмын 2.5.1-д зааснаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна

2.5.2.1. үйл ажиллагаанаас үүдэн гарах хариуцлагыг хүлээх хангалттай хэмжээний хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй байх;

2.5.2.2. зохицуулалттай этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хэвийн хангаж чадах туршлагатай нь урьд болон одоо эрхэлж байгаа үйл ажиллагааны үр дүнгээр тодорхойлогдсон байх;

2.5.2.3. хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх.

2.6. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч нь үйл ажиллагаандаа тусгай тэмдэг, албан хэвлэмэл хуудас, маягтыг хэрэглэж болно.

2.7. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагчийн ажиллах нөхцөл, бусад зүйлийг Хороо болон эрх хүлээн авагчийн хооронд байгуулах гэрээнд нарийвчлан тусгана.

2.8. Онцгой нөхцөл байдал үүссэн зохицуулалттай этгээдийн бүртгэлийг Хороо хөтөлнө.

ГУРАВ. ЭРХ ХҮЛЭЭН АВАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Онцгой нөхцөл байдал үүссэн зохицуулалттай этгээдийн удирдлагын бүрэн эрх нь эрх хүлээн авагчид шилжинэ.

3.2. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87.4-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.2.1. Зохицуулалттай этгээдийн тодорхой үйл ажиллагааг үргэлжлүүлэх, зогсоох;

3.2.2. Зохицуулалттай этгээдийн бусдад төлөх төлбөрийг зогсоох, төлбөрийн хэмжээг хязгаарлах;

3.2.3. Зохицуулалттай этгээдийн хөрөнгө оруулалт хийхээр байгуулсан гэрээг цуцлах, зээлийн хүү, үйлчилгээний хөлсний хувь хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах;

3.2.4. Зохицуулалттай этгээдийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах;

3.2.5. Зохицуулалттай этгээдийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд зохицуулалттай этгээдийг төлөөлөн оролцох.

3.3. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87.4-д заасан эрх хэмжээний хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дор дурдсан үүргийг хүлээнэ:

3.3.1. өөрийн үйл ажиллагаандаа Үнэт цаасны зах зээлийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан эрх зүйн актыг мөрдөх;

3.3.2. томилогдсон өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор тухайн зохицуулалттай этгээдийн санхүү, төлбөрийн чадварын байдалд дүгнэлт гаргах, авах арга хэмжээний талаарх саналыг гаргах;

3.3.3. цаашид авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар сар бүр Хороонд мэдээлэл хүргэх.

3.4. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87.2-д заасан арга хэмжээг нэн даруй авахаас гадна дараах арга хэмжээг авна:

3.4.1. тус зохицуулалттай этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн талаар тухайн этгээдийн удирдлага, нийт ажилтнуудад танилцуулж, энэ талаарх мэдэгдлийг нийтэд хүргэх;

3.4.2. зохицуулалттай этгээдийн бүх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар бие даан шийдвэр гаргаж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

3.4.3. эрх хүлээн авагч томилогдсон өдрөөр тасалбар болгон тус зохицуулалттай этгээдийн санхүүгийн гүйлгээг хааж, орлого, зарлагын тайлан тэнцлийг гаргуулан, гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогчоор гарын үсэг зуруулж, тамга тэмдэг даруулах;

3.4.4. зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч, дотоод хяналтын ажилтнаас албан үүргээ гүйцэтгэх хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг авах;

3.4.5. томилогдсон өдрийн байдлаар зохицуулалттай этгээд, түүний бүх эд хөрөнгө, баримт бичиг боловсон хүчний хувийн хэрэг, материал, архив, бичиг хэрэг, тэнцлийн гадуурх данс тооцоо/-ийг тоолж, бүртгэн энэ тухай тайлан мэдээг доорх хавсралтын дагуу гаргуулан хяналтандаа авна:

3.4.5.1. зохицуулалттай этгээд, түүний нэгжийн захирал, ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч нарын хариуцаж өгсөн мэдээ, бүртгэлийг баталгаа тодорхойлолтын дагуу /Хавсралт 1/;

3.4.5.2. зохицуулалттай этгээдийн санхүүгийн тайланг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 221/331 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа

эрхлэх этгээдэд мөрдөгдөх дансны жишиг жагсаалт, санхүүгийн тайлан болон түүний тодруулгын маягт"-ын дагуу;

3.4.5.3. зохицуулалттай этгээдийн касс үнэ бүхий зүйлсийг тоолж шалгасан тухай дүнг актаар /Хавсралт 2/;

3.4.5.4. зохицуулалттай этгээдийн төлбөр хийхээр хүлээлгэж буй баримтыг жагсаалтаар /Хавсралт 3/;

3.4.5.5. Хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм"-ийн 3 дугаар хавсралтаар батлагдсан "Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн журам"-д заасан үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах сангийн хүрэлцээний тухай тайлан;

3.4.5.6. зохицуулалттай этгээдийн үнэт цаасны хадгаламжийн байгууллагад хадгалагдаж буй үнэт цаасыг жагсаалтаар /Хавсралт 4/;

3.4.5.7. зохицуулалттай этгээдийн төлбөр тооцоо гүйцэтгэх банк дахь дансдын үлдэгдлийн талаарх тайлан /Хавсралт 5/;

3.4.5.8. зохицуулалттай этгээдийн сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн хэлцлийг жагсаалтаар /Хавсралт 6/;

3.4.5.9. зохицуулалттай этгээдийн харилцагчдын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл /Хавсралт 7/;

3.4.5.10. зохицуулалттай этгээдийн харилцагчдын данснаас гарсан мөнгөн хөрөнгийн жагсаалт

3.4.5.11. зохицуулалттай этгээдийн өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн жагсаалт /Хавсралт 8/;

3.4.5.12. зохицуулалттай этгээдийн үндсэн хөрөнгө, эд хогшлын бүртгэл /Хавсралт 9/;

3.4.5.13. зохицуулалттай этгээдийн хангамжийн материалын бүртгэл /Хавсралт 10/;

3.4.5.14. зохицуулалттай этгээдийн өр төлбөрийн судалгаа /Хавсралт 11/;

3.4.5.15. зохицуулалттай этгээдийн архивын маягт, захиалгын гэрээнүүдийн бүртгэлийн жагсаалт /Хавсралт 12/;

3.4.5.16. зохицуулалттай этгээдийн тамга, тэмдэг хүлээлцсэн тухай акт /Хавсралт 13/;

3.4.5.17. зохицуулалттай этгээдийн номинал данс дахь харилцагчийн үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн тухайлсан бүртгэлийн жагсаалт;

3.4.5.18. харилцагчтай байгуулсан үнэт цаасны данс нээлгэх гэрээ, холбогдох бусад баримтууд;

3.4.5.19. зохицуулалттай этгээдийн ашиглаж байсан програм хангамжид бүртгэгдсэн харилцагчийн мэдээллүүд, захиалгын бүртгэл;

3.4.5.20. даатгалын баримт бичиг, зохицуулалттай этгээдээс шүүхэд гаргасан нэхэмжлэл, шүүхээс гарсан шийдвэр, хэрэгжилтийн талаар хэрэг бүрээр хийсэн бүртгэл;

3.4.5.21. хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцийн судалгаа;

3.4.5.22. бусад шаардлагатай баримт, материал.

3.4.6. Үйл ажиллагааны тайланг гаргаж Хороонд хүргүүлэх, зохицуулалттай этгээдийг татан буулгах нэхэмжлэлийг шүүхэд гаргах.

3.5 Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч нь энэ журмын 3.4-д дурдсан ажиллагааг гүйцэтгэх явцад зөрчил дутагдал илэрвэл хууль тогтоомжид заасны дагуу холбогдох арга хэмжээг авч, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлаар хууль, хяналтын байгууллагуудад хандаж шийдвэрлүүлнэ.

3.6. Тайлан тэнцлийн холбогдох дансдын үлдэгдэл үндсэн баримттай зөрвөл энэ талаар тухайн этгээдийн удирдлага, холбогдох бусад этгээдэд мэдэгдэж, зөрүүг тохируулах, баримтжуулах, холбогдох эрх бүхий байгууллагад зөрчилтэй асуудлыг шийдвэрлүүлнэ. Тавьж

3.7. Зохицуулалттай этгээдээс хийгдсэн төлбөр, шилжүүлэг нь зарим этгээдийн эрх ашгийг бусдаас илүүтэй үзсэн шинжтэй бол тухайн этгээдийн эрхийг хүлээн авах ажиллагаа эхлэхээс өмнөх гурван сарын дотор хийгдсэн төлбөрийг, хэрэв төлбөр хүлээн авагч нь тухайн этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, тэдгээрт холбогдох этгээд байвал эрхийг хүлээн авах үйл ажиллагаа эхлэхээс өмнөх 12 сарын дотор хийгдсэн бүх төлбөрийг дор дурдсанаас бусад тохиолдолд хүчингүйд тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргана:

3.7.1 бусдад шилжүүлсэн эд хөрөнгө нь уг эд хөрөнгийн зах зээлийн үнээр төлөгдсөн;

3.7.2 зохицуулалттай этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтанд олгосон цалин хөлс нь тэдгээрт урьд олгож байсан цалин хөлсний ердийн хэмжээнээс хэтрээгүй /шагнал, бусад тусгай нэмэгдэл үүнд хамаарахгүй/.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ХАРИЛЦАГЧИЙГ БУСАД ЭТГЭЭДЭД ШИЛЖҮҮЛЭХ

4.1. Онцгой нөхцөл байдал үүссэн зохицуулалттай этгээдийн харилцагчдыг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр өөр этгээдэд шилжүүлнэ.

4.2. Эрх хүлээн авагчийн санал болгосон 7 хүний бүрэлдэхүүнтэй уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах комисс /цаашид "комисс" гэх/ -ыг Хорооны даргын шийдвэрээр томилно. Уг комисс нь Хорооноос 3, гишүүнчлэл бүхий арилжаа эрхлэх байгууллага, мэргэжлийн холбоо, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төлбөр тооцооны байгууллагаас тус бүр 1 төлөөллөөс бүрдэнэ.

4.3. Комисс уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахдаа Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

4.4. Уралдаант шалгаруулалтад оролцох сонирхолтой эрх бүхий компанийг шаардлагатай мэдээллээр хангах үүргийг комисс хүлээнэ.

4.5. Комиссын гишүүд эрх бүхий зохицуулалттай этгээдүүдээс ирүүлсэн уралдаант шалгаруулалтын материалтай танилцаж, гишүүн тус бүр энэ журмын 5.1, 5.2-т заасан заалт тус бүрээр 3 хүртэл оноо өгч дүгнэнэ.

4.6. Комисс уралдаант шалгаруулалтад ирүүлсэн материалуудыг уралдаант шалгаруулалтын материал хүлээж авах сүүлчийн хугацаанаас хойш ажлын 10 өдрийн дотор

шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг хугацааг ажлын 5 хүртэл өдрөөр сунгаж болно.

4.7. Комисс нь уралдаант шалгаруулалтын эцсийн дүнг гаргаж тухайн зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагчид танилцуулах бөгөөд эрх хүлээн авагч нь онцгой нөхцөл байдал үүссэн этгээдийн харилцагчдыг шалгарсан эрх бүхий компанид шилжүүлэх саналыг Хороонд ажлын 3 өдрийн дотор танилцуулна.

4.8. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч нь онцгой нөхцөл байдал үүссэн этгээдийн үйл ажиллагаа явуулж байсан хугацааны хэлцлийн жагсаалт, харилцагчдын талаарх мэдээлэл, харилцагчийн данснаас гарсан мөнгөний жагсаалтыг Хорооны шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор акт үйлдэн шалгарсан эрх бүхий компанид хүлээлгэн өгнө. Актыг 3 хувь үйлдэх бөгөөд хувь тус бүрийг Хороо, эрх хүлээн авагч, уралдаант шалгаруулалтад шалгарсан этгээд хадгална.

ТАВ. УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Уралдаант шалгаруулалтад Хорооноос үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани оролцох бөгөөд тухайн хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1. үйл ажиллагаагаа сүүлийн 3 жилийн хугацаанд тогтмол явуулсан байх

5.1.2. шилжүүлж авсан харилцагчдад үйлчлэх салбар нээн ажиллуулах санхүүгийн болон хүний нөөцийн боломжтой байх;

5.1.3. хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх;

5.1.4. үнэт цаасны төлбөр тооцоо болон харилцагчдын хувьцааг өмчлөгчийн зөвшөөрөлгүй зарах зэрэг хууль бус үйлдэл гаргаж байгаагүй байх;

5.1.5. тухайн жилд компани болон албан тушаалтан Хорооноос захиргааны шийтгэл хүлээгээгүй байх;

5.1.6. үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан журам, зааврыг биелүүлж ажилладаг байх;

5.1.7. комисс нэмэлт шаардлага тавьж, материал шаардаж болох бөгөөд үүнийг комиссын гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

5.2. Уралдаант шалгаруулалтад оролцох компани дараах материалыг комисст битүүмжлэн ирүүлнэ:

5.2.1. уралдаант шалгаруулалтад оролцох болсон шалтгаан, зорилго;

5.2.2. харилцагчдыг шилжүүлэн авснаар үүсэх үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, бизнес төлөвлөгөөнд оруулах өөрчлөлтийн төсөл;

5.2.3. шинээр байгуулах салбарт ажиллах мэргэжилтний талаарх мэдээлэл;

5.2.4. шилжүүлж авах харилцагчдад үйлчлэх салбарын ажлын байрыг хэрхэн шийдвэрлэх талаарх танилцуулга;

5.2.5. харилцагчдад хүргэх үйлчилгээг хэрхэн шуурхай болгож, сайжруулах санал төлөвлөгөө;

5.2.6. салбарын үйл ажиллагааны дотоод журам, салбарын үйл ажиллагаанд хяналт тавих журмуудын төсөл;

5.2.7. онцгой нөхцөл байдал үүссэн зохицуулалттай этгээдээс харилцагчдад учруулсан хохирлыг хариуцах эсэх, хэрэв хариуцвал ямар хэмжээгээр хариуцах.

5.3. Уралдаант шалгаруулалтад оролцох эрх бүхий этгээд нь энэ журмын 5.2-т заасан баримт материалыг уралдаант шалгаруулалт зарлагдсанаас хойш ажлын 20 өдөрт багтаан комисст ирүүлнэ. Уралдаант шалгаруулалтын зарлалд материал хүлээж авах сүүлчийн хугацааг тусгана.

5.4. Энэ журмын 5.3-т заасан хугацаанд ямар нэг этгээдээс хүсэлт ирүүлээгүй тохиолдолд онцгой нөхцөл байдал үүссэн зохицуулалттай этгээдийн харилцагчдыг шилжүүлэх асуудлыг эрх хүлээн авагч тусгай зөвшөөрөл бүхий, аль тохиромжтой, шаардлага хангахуйц этгээдтэй тохиролцож шийдвэрлэх арга хэмжээ авна.

5.5. Онцгой нөхцөл байдал үүссэн зохицуулалттай этгээдийн харилцагчийн зөвшөөрөлгүйгээр тэдний хувьцааг худалдсан, мөнгөн хөрөнгийг ашигласан хууль бус үйлдэлтэй холбоотой асуудлыг тухайн харилцагчийг шилжүүлэн авсан компани хариуцах саналаа энэ журмын 5.2.7-д зааснаар ирүүлээгүй бол хариуцахгүй. Дээрх байдлаар үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх нь зөрчигдсөн харилцагч эрхээ сэргээлгэж, гэм хороо арилгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандахад харилцагчийг шилжүүлэн авсан этгээд шаардлагатай, өөрт байгаа мэдээллээр хангах үүрэгтэй.

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ЭРХ ХҮЛЭЭН АВАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДУУСГАВАР БОЛГОХ

6.1. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагчийн үйл ажиллагаа нь хийж гүйцэтгэсэн ажиллагааны тайланг гаргаж Хороонд танилцуулсан, тухайн хуулийн этгээдийг татан буулгахаар шүүхэд нэхэмжлэл гаргаснаар дуусгавар болно.

6.2. Эрх хүлээн авагч нь хийж гүйцэтгэсэн ажиллагааны тайландаа өглөг, авлагыг барагдуулсан байдлын талаар тодорхой тусгаж, холбогдох санхүүгийн баримтыг хавсаргасан байна.

6.3. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч нь тухайн этгээдийн үнэт цаасны арилжааны хэлцлийн жагсаалтыг үндэслэн дараах баримтыг гишүүнчлэлтэй арилжаа эрхлэх байгууллагад нь хүлээлгэн өгнө:

6.3.1. захиалгын гэрээ, гэрээ дүгнэсэн акт;

6.3.2. харилцагчийн бүртгэл;

6.3.3. дилерийн даалгавар;

6.3.4. баталгаажуулсан хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн үлдэгдэл.

ДОЛОО. ЗАРДАЛ

7.1. Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авахтай холбогдсон үйл ажиллагааны зардалтай холбоотой асуудлыг тухай бүр Хороо шийдвэрлэнэ.

НАЙМ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

8.1 Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авах арга хэмжээний хэрэгжилтэд Хороо хяналт тавина.

8.2 Зохицуулалттай этгээдэд эрх хүлээн авах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх хүлээн авагчийн үйл ажиллагаанд саад учруулж, түүний зөвшөөрөлгүйгээр зохицуулалттай этгээдийн нэрийн өмнөөс, уг зохицуулалттай этгээдийн зардлаар аливаа үйл ажиллагаа явуулсан байвал эрх хүлээн авагч нь хууль бус аливаа үйлдэл /эс үйлдэл/-ийг зогсоож, гэрээ, хэлцлийг хүчингүй болгож, энэ буруутай үйлдэл /эс үйлдэл/-ээс үүдэн гарсан хохирлыг холбогдох этгээдээр нөхөн төлүүлэх болон бусад асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

8.3 Зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлыг өөрөө хариуцна. Үйл ажиллагааны ердийн эрсдэлд хамруулж болох хохирол учирсан нь эрх хүлээн авагчид хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

8.4 Энэ журмын холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын нэгдүгээр хавсралт

Маягт СЗХ03200

ТОДОРХОЙЛОЛТ

СЗХ03200

Огноо

Дугаар

Улаанбаатар хот

"....." ХХК-ийн овогтой. нягтлан бодогч/.. /гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч/овогтой..... би хариуцаж өгсөн мэдээ ,бүртгэлд тусгагдсан мэдээлэл үнэн зөв болохыг баталж байна.

Буруу мэдээлэл өгснөөс болж зохицуулалттай этгээдэд хохирол учирвал миний бие хуулийн дагуу бүрэн хариуцлага хүлээнэ.

"....." ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: / /

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ: / /

Тамга

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын хоёрдугаар хавсралт

“.....” ХХК-ИЙН КАСС, ҮНЭ БҮХИЙ ЗҮЙЛИЙГ ТООЛЖ,
ШАЛГАСАН ТУХАЙ АКТ

СЗХ03201

Төгрөг

Дэвсгэрт	Тоо ширхэг	Дүн
10		
20		
50		
100		
500		
1000		
5000		
10000		
Нийт дүн		

Валют

Валютын нэрс	Дэвсгэрт	Дүн
Доллар	1	
	5	
	10	
	20	
	50	
	100	
Нийт дүн		
DEM		
Иен		
CHF		
GBR		
ITL		
RUR		
Юань		
CAD		
FRF		
ATS		
Бусад		

3. Үнэ бүхий зүйл

№	Үнэ бүхий зүйлийн нэр	Дүн
---	-----------------------	-----

1	Хадгаламжийн дэвтэр	
2	Байгууллагын чек	
3	Үнэт металл, эрдэнийн чулуу	
4	Үнэт цаас	
5	Үнэт эдлэл	
6	Бусад	

ТЭМДЭГЛЭЛ:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Тоолж хянасан:

Зохицуулалттай этгээдийн эрх
хүлээн авагч:

/ /

Зөвшөөрч хүлээн авсан:
Зохицуулалттай гүйцэтгэх
захирал:

/ /

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын гуравдугаар хавсралт

Маягт СЗХ03202

“.....” ХХК-ИЙН ТӨЛБӨР ХИЙХЭЭР ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ БАРИМТЫН
ЖАГСААЛТ
СЗХ03202

.....оны.....сарынөдрийн байдлаар

№	БАРИМТ БН ДУГААР	ГҮЙЛГ ЭЭ ХИЙСЭ Н Огноо	ГҮЙЛГЭЭН ИЙ УТГА	МӨНГ ӨН ДҮН	ХҮЛЭ ЭН АВАГ Ч БАНК	ХҮЛЭЭН АВАГЧ БАЙГУУЛЛАГ А

Тайлан гаргасан:

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

/ /

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

эрх хүлээн авагч:

/ /

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын дөрөвдүгээр хавсралт
Маягт СЗХ03203

“.....” ХХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД
 ХАДГАЛАГДАЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ЖАГСААЛТ

СЗХ03203

Үгү й	Данс	Эзэмшиж буй үнэт цаасны нэр	Үнэт цаасны тоо ширхэг	Тусгаарлагдсан эсэх /Барьцаа/

Тайлан гаргасан:

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

/ /

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

эрх хүлээн авагч:

/ /

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын тавдугаар хавсралт

Маягт СЗХ03204

“.....” ХХК-ИЙН ТӨЛБӨР ТООЦОО ГҮЙЦЭТГЭХ БАНКИН ДАХЬ ДАНСДЫН
ҮЛДЭГДЛИЙН ТАЛААРХ ТАЙЛАН

СЗХ03204

.....оны сарын ... өдрийн байдлаар

№	Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны нэр	Дансны дугаар	Үлдэгдэл

Тайлан гаргасан:

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

/ /

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

эрх хүлээн авагч:

/ /

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын зургаадугаар хавсралт

Маягт СЗХ03205

“.....” ХХК-ийн сүүлийн 3 жилийн хугацааны хэлцлийн
ЖАГСААЛТ

СЗХ03205

.....оны сарын ... өдрийн байдлаар

№	Хэлцлийн утга	Үнэт цаасны нэр	Үнэт цаасны код	Арилжигдсан тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт дүн

Тайлан гаргасан:

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

/ /

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

эрх хүлээн авагч:

/ /

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын долоодугаар хавсралт

Маягт СЗХ03206

“.....” ХХК-ИЙН ХАРИЛЦАГЧДЫН ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ
СЗХ03206

.....оны сарын ... өдрийн байдлаар

№	Харилцагчийн овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суугаа хаяг	Холбоо барих утас, цахим шуудангийн хаяг	ТТГ Банкны дансны мэдээлэл

Тайлан гаргасан:

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

/ /

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

эрх хүлээн авагч:

/ /

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын наймдугаар хавсралт

“.....” ХХК-ийн ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

СЗХ03207

.....оны сарын ... өдрийн байдлаар

№	Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн дугаар	ҮХХБГ-аар үнэлүүлсэн үнэлгээ	ӨБҮХХ-нд бүртгэсэн он сар өдөр	ӨБҮХХ-нд бүртгэсэн шийдвэр	ӨБҮХХ-ийн марк

Тайлан гаргасан:

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

/ /

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

эрх хүлээн авагч:

/ /

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын есдүгээр хавсралт

Маягт СЗХ03208

"....." ХХК-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨ, ЭД ХОГШЛЫН БҮРТГЭЛ СЗХ03208

.....оны сарын ... өдрийн байдлаар

№	ДАН С	ҮНДСЭН ХӨРӨНГӨ, ЭД ХОГШИЛ	АНХНЫ ҮНЭ	БАЙГУУЛСАН Элэгдэл	ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГ
	1501				
		ДҮН			
	1502				
		ДҮН			
	1503				
		ДҮН			

Тайлан гаргасан:

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

эрх хүлээн авагч:

/ /

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын аравдугаар хавсралт

Маягт СЗХ03209

“.....” ХХК-ИЙН ХАНГАМЖИЙН МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛ

СЗХ03209

.....оны сарын өдрийн байдлаар

Үгүй	ДАНС	МАТЕРИАЛ НЭР	АНХНЫ ҮНЭ	ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГ
	1606			
		ДҮН		
	1607			
		ДҮН		

Тайлан гаргасан:

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

эрх хүлээн авагч:

/ /

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын арваннэгдүгээр хавсралт

Маягт СЗХ03210

“.....” ХХК-ИЙН ӨР ТӨЛБӨРИЙН СУДАЛГАА

СЗХ03210

.....оны сарын өдрийн байдлаар

Үгүй	Өр төлбөртэй байгууллагын нэр	Өрийн үлдэгдэл дүн	Хугацаа	Хүүгийн хувь /жилээр/	Дотоод/Гадаад	эх	үүсвэр
					/	/	

Тайлан гаргасан:

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

/ /

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

эрх хүлээн авагч:

/ /

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

"Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам"-ын арванхоёрдугаар хавсралт

Маягт СЗХ03211

"....." ХХК-ИЙН АРХИВЫН МАЯГТ, ЗАХИАЛГЫН ГЭРЭЭНҮҮДИЙН
БҮРТГЭЛИЙН ЖАГСААЛТ

СЗХ03211

...оны сарын өдрийн байдлаар

№	тайлан баланс	кассын баримт	захиалгын гэрээнүүд	тооцоо нийлсэн акт
А				
А	компанийн өөрийн данс	эрсдэлийн сангийн данс		

Хүлээлгэн өгсөн:

Зохицуулалттай этгээдийн

Гүйцэтгэх захирал:

/ /

Ерөнхий нягтлан бодогч:

/ /

Зөвшөөрч хүлээн авсан:

Зохицуулалттай этгээдийн

эрх хүлээн авагч:

/ /

Түүнд туслах ажлын хэсэг:

/ /

/ /

/ /

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай
этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ийн наймдугаар хавсралт

САНХҮҮЖИХ ЧАДАВХЫН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь үнэт цаас гаргагчийн санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох хуулийн этгээд /цаашид “Зэрэглэл тогтоох байгууллага” эсхүл “ЗТБ” гэх/-ийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. ЗТБ нь Хорооноос үнэт цаасны зэрэглэл тогтоохтой холбоотой гаргасан журам, заавар, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөнө.

Хоёр. Нэр томьёо

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. “Үнэт цаас гаргагчийн санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох /цаашид “үнэт цаасны зэрэглэл тогтоох” гэх/” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 50.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг;

2.1.2. “Үнэт цаас гаргагч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.20 дахь заалтад заасан үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Санхүүгийн зохицуулах хороо/цаашид “Хороо” гэх/-нд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлтээ гаргаж байгаа этгээдийг;

2.1.3. “Үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1 дэх хэсэгт заасан санхүүгийн хэрэгсэлүүдийг;

2.1.4. “Харилцагч” гэж тухайн ЗТБ-аар үнэт цаасны зэрэглэлээ тогтоолгохоор гэрээ байгуулсан, зэрэглэл тогтоолгосон үнэт цаас гаргагчийг;

2.1.5. “Дахин хянах” гэж ЗТБ харилцагчийн санхүүгийн чадавхид ээлжит үнэлгээ хийсний үндсэн дээр үнэт цаасны зэрэглэлийг хэвээр хадгалах, нэмэгдүүлэх, бууруулах талаар шийдвэр гаргахыг;

2.1.6. “Холбогдох этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.30 дахь заалтад заасныг.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгох

Нөхцөл шаардлага

3.1. ЗТБ-ын хувьцаа эзэмшигч нь дараах хуулийн этгээдүүд байна:

3.1.1. Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллага;

3.1.2. Монголбанкны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй банк;

3.1.3. сүүлийн таван жилд жилийн аудитлагдсан тайлангаар үйл ажиллагааны борлуулалтын орлого нь нэг тэрбум төгрөгөөс доошгүй, Монгол улсад бүртгэлтэй компани;

3.1.4. зэрэглэл тогтоох үйл ажиллагаа гурваас доошгүй жил эрхэлж буй гадаад улсын зэрэглэл тогтоох байгууллага.

3.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь нэг зуун сая төгрөг байна.

3.3. Үнэт цаасны зэрэглэл тогтоох аргачлал, тэмдэглэгээ, тодорхойлолт, зэрэглэл тогтоох үйл ажиллагааны журам, тайлангийн загвартай байна.

3.4. ЗТБ-ын төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/ нь ашиг сонирхолын зөрчилгүй, энэ журмын 3.7.2, 3.7.3 дахь заалтад заасан шаардлагыг хангасан таваас доошгүй гишүүнтэй байх ба нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүд байна. Хараат бус гишүүд нь Компаний тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасан ТУЗ-ийн хараат бус гишүүний шаардлагыг хангасан байна.

3.5. ЗТБ нь таваас доошгүй гишүүдээс бүрдсэн Зэрэглэлийн хороотой байна

3.6. ЗТБ нь хоёроос доошгүй шинжээчтэй байна.

3.7. ЗТБ-ын Зэрэглэлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, шинжээчид нь дараах шалгуурыг хангасан байна:

3.7.1. үнэт цаасны чиглэлээр мэргэшсэн, дадлага туршлагатай;

3.7.2. санхүү, эдийн засгийн гэмт хэрэгт холбогдоогүй;

3.7.3. мэргэжлийн ёс зүйн арга хэмжээ авагдаж байгаагүй.

3.8. Тогтмол үйл ажиллагаа явуулах ажлын байр, үнэт цаасны зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, программ хангамж, дэд бүтцээр хангагдсан байна.

3.9. ЗТБ нь өөрийн үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын ажилтантай байна.

Бүрдүүлэх баримт бичиг

3.10. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2 дахь хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

3.10.1. энэ журмын Маягт 1 - Маягт 5-ыг бүрдүүлж ирүүлэх;

3.10.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.10.3. зэрэглэл тогтоох аргачлал, тэмдэглэгээ, тодорхойлолт, зэрэглэл тогтоох үйл ажиллагааны тайлангийн загвар;

3.10.4. зэрэглэл тогтоох үйл ажиллагааны журам;

3.10.5. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт мэдээлэл.

Хянаж шийдвэрлэх

3.11. Хороо ЗТБ-аас тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, энэ журмын 3.1-3.9 дэх хэсэгт заасан нөхцөл, шаардлагын дагуу хянаж шийдвэрлэнэ.

3.12. Хороо нэмэлт баримт бичиг шаардсан тохиолдолд баримт бичиг бүрэн ирүүлсэн өдрөөс хяналтын хугацааг тооцно.

3.13. Хороо ЗТБ-д тусгай зөвшөөрөл олгохдоо энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан этгээдийн тохиромжтой эсэх /өр зээл, санхүүгийн мэдээллийн албаны мэдээлэл гэх мэт/ талаар Монголбанктай зөвшилцөнө.

3.14. Хороо тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгоно.

3.15. Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

3.15.1. энэ журмын 3.1-3.9 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангагдаагүй;

3.15.2. тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон;

3.15.3. гүйцэтгэх захирал, шинжээчид нь хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдсон;

3.15.4. энэ журмын 3.13 дахь хэсэгт заасан асуудлаар Монголбанк татгалзсан үндэслэлийг Хороо хүлээн зөвшөөрсөн.

3.16. Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид ажлын арав хоногт багтаан албан бичгээр мэдэгдэнэ.

3.17. Энэ журмын 3.15.2 дахь заалтад заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос Хороо татгалзсан тохиолдолд уг өдрөөс хойш нэг жилийн дотор тухайн ЗТБ-аас тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг дахин хүлээж авахгүй.

Дөрөв. Зэрэглэл тогтоох байгууллагын үйл ажиллагаа

4.1. ЗТБ нь энэ журмын 1 дүгээр хавсралт “Үйл ажиллагааны ёс зүйн дүрэм” болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-с гаргасан “Зэрэглэл тогтоох байгууллагын үйл ажиллагааны ёс зүйн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдөнө.

4.2. ЗТБ нь үнэт цаасны зэрэглэл тогтоолгох харилцагчтай бичгээр гэрээ байгуулна. Гэрээнд дараах зүйлсийг заавал тусгасан байна:

4.2.1. үнэт цаасны зэрэглэл тогтоох үйл ажиллагаатай холбоотой хоёр талын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлно;

4.2.2. зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлсийг нарийвчлан тусгах;

4.2.3. харилцагчийн үнэт цаасны зэрэглэлийг тогтоосон ЗТБ-ын аргачлал нь хүчинтэй байх хугацаанд уг ЗТБ-аар зэрэглэлээ тодорхой хугацааны давтамжтайгаар дахин хянуулж байхыг тохиролцсон байна;

4.2.4. харилцагч нь ЗТБ-д зэрэглэл тогтоох үйл ажиллагааг саадгүй гүйцэтгэн дуусгах нөхцөл боломжоор хангах, зэрэглэл тогтооход шаардлагатай, үнэн зөв мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх тухай;

4.2.5. ЗТБ нь өөрийн нийтэд нээлттэй зарласан, байнга ашигладаг аргачлалаар тогтоосон үнэт цаасны зэрэглэлийг харилцагч зөвшөөрсөн эсэхээс үл хамааран харилцагчид танилцуулан, тайланг хүлээлгэж өгөх тухай;

4.2.6. харилцагч сүүлийн гурван жилийн хугацаанд ямар нэгэн ЗТБ-аар тогтоолгосон зэрэглэл, ЗТБ-ын тогтоосон боловч өөрсдөө хүлээн зөвшөөрөөгүй зэрэглэлийн талаарх мэдээллийг ЗТБ-д гаргаж өгөхийг зөвшөөрсөн байна.

4.3. ЗТБ харилцагчийн үнэт цаасны зэрэглэлд тогтмол мониторинг, шинжилгээ хийнэ.

4.4. ЗТБ харилцагчийн үнэт цаасны зэрэглэлд тодорхой хугацааны давтамжтайгаар дахин хяналт хийж зэрэглэлийг өөрчлөх эсэх талаар шийдвэр гаргана.

4.5. Үнэт цаасны зэрэглэл шинээр тогтоох, зэрэглэлд өөрчлөлт оруулах шийдвэрийг Зэрэглэлийн хороо гаргана.

4.6. Зэрэглэлийн хорооны гишүүд болон шинжээчдийн цалин хөлс, урамшуулал нь зэрэглэл тогтоох үйл ажиллагааны орлого, тогтоосон зэрэглэлээс үл хамаарсан байна.

4.7. ЗТБ үнэт цаасны зэрэглэл шинээр тогтоосон, зэрэглэлд өөрчлөлт оруулсан тухай бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх ба бүртгэлтэй үнэт цаасны хувьд Монголын хөрөнгийн бирж болон тухайн үнэт цаас бүртгэлтэй бүх биржид мэдээлнэ.

4.8. ЗТБ нь зэрэглэл тогтоосон үнэт цаасны зэрэглэлийн тодорхойлолт, тэмдэглэгээг олон нийтэд нээлттэй байлгах ба энэхүү зэрэглэл нь хөрөнгө оруулагч, олон нийтийг уг үнэт цаасыг худалдах, худалдан авах талаар ямар нэгэн зөвлөмж болохгүй гэдгийг анхааруулсан байна.

4.9. ЗТБ тухайн үнэт цаасны зэрэглэлд голлох нөлөө үзүүлсэн эерэг хүчин зүйлс, цаашид эрсдэлтэй байж болох сөрөг хүчин зүйлсийн талаарх шинжилгээ бүхий мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгана.

4.10. Харилцагч ЗТБ-тай хамтран ажиллахаас татгалзсан тохиолдолд ЗТБ боломжит аргаар олж авсан мэдээлэлд суурилан тухайн харилцагчийн үнэт цаасны зэрэглэлд дахин хяналт хийнэ. Энэ тохиолдолд дахин хянах үйл ажиллагаа явагдсан нөхцөл болон үнэт цаасны зэрэглэлд орсон өөрчлөлт нь хязгаарлагдмал мэдээлэлд суурилсан талаар хөрөнгө оруулагчдад мэдээлнэ.

4.11. ЗТБ-ын харилцагч нь Компаний тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу компани нийлүүлэх, нэгтгэх, хуваах, татан буулгахаас бусад тохиолдолд түүний үнэт цаасны зэрэглэлийг цуцлахгүй.

4.12. ЗТБ нь дор дурдсан хууль, журам зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор харилцагчийн үнэт цаасны арилжаанд мониторинг, шинжилгээ хийх журам, тогтолцоо бүрдүүлсэн байна:

4.12.1. Хорооны 2013 оны 506 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”;

4.12.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 72.1.6 дахь заалтад заасан зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэлээлэл ашиглан арилжаанд оролцохоос урьдчилан сэргийлэх тухай журам;

4.12.3. Үнэт цаасны арилжаатай холбоотой бусад хууль, дүрэм, журмууд.

Тав. Зэрэглэл тогтоох байгууллагын үүрэг

5.1. ЗТБ нь үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн тайланг Хороонд ирүүлнэ.

5.2. ЗТБ нь санхүүгийн тайланг улирал тутам Хороонд ирүүлнэ.

5.3. ЗТБ үнэт цаасны зэрэглэл тогтоосон, өөрчилсөн тухай тайлан, шийдвэрийн хувийг Хороонд ажлын тав хоногт багтаан ирүүлнэ.

5.4. Зэрэглэлийн хорооны гишүүд болон шинжээчийн цалин хөлс, урамшууллын тогтолцоог ил тод байлгах, энэ талаарх орсон өөчлөлтийн мэдээллийг тухай бүр Хороонд ирүүлнэ.

5.5. ЗТБ нь энэ журмын 4.11 дэх хэсэгт заасан харилцагчийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр Хороонд ирүүлнэ.

5.6. ЗТБ Хорооноос шаардсан мэдээллийг заасан хугацаанд ирүүлнэ.

5.7. ЗТБ дотоод хяналтын ажилтны бие даасан, хараат бус байдлыг хангасан байна.

5.8. Дотоод хяналтын ажилтан нь ЗТБ-ын үйл ажиллагаанд гарсан аливаа зөрчлийн талаар Хороонд хараат бусаар шууд мэдээлнэ.

5.9. ЗТБ дараах нягтлан бодох бүртгэлийн журнал, тайлан, холбогдох баримт бичгийг таваас доошгүй жил хадгална:

5.8.1. жилийн санхүүгийн тайлан;

5.8.2. жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт;

- 5.8.3. харилцагчидтай байгуулсан гэрээний хувь;
- 5.8.4. харилцагчдаас авсан мэдээлэл;
- 5.8.5. харилцагчдын талаарх мэдээлэл;
- 5.8.6. тогтоосон, өөрчилсөн зэрэглэлүүдийн мэдээлэл;
- 5.8.7. зэрэглэл тогтоох тухай Зэрэглэлийн хорооны хурлын тэмдэглэл, шийдвэр;
- 5.8.8. зэрэглэл тогтоосон тухай мэдэгдэл, албан бичиг;
- 5.8.9. зэрэглэл тогтоох болон бусад төрлийн үйлчилгээний төлбөрийн баримт.

5.10. ЗТБ-ын үйл ажиллагааны шалгалтын тайлан, санхүүгийн аудитын тайланд үнэт цаасны зэрэглэл тогтоох үйл ажиллагаатай холбоотой зөрчил тэмдэглэгдсэн бол хоёр сарын дотор зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

5.11. ЗТБ энэ журмын 3.10.4 дэх заалтад заасан зэрэглэл тогтоох үйл ажиллагааны журмыг нягт мөрдөн ажиллана.

5.12. ЗТБ нь Хороонд үнэн зөв, бодит мэдээ, мэдээлэл, тайлан ирүүлнэ.

5.13. ЗТБ нь энэ журмын 3.10.4 дэх заалтад заасан зэрэглэл тогтоох үйл ажиллагааны журамд орсон өөрчлөлтийг тухай бүр Хороонд ирүүлнэ.

5.14. Зэрэглэлийн тодорхойлолт, тэмдэглэгээ, аргачлалын өөрчлөлт, шинээр ашиглах хэрэгслийн талаар Хороонд урьдчилан мэдэгдэнэ.

5.15. ЗТБ нь харилцагчаас гаргаж өгсөн мэдээллийг хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.

5.16. ЗТБ нь өөрийн харилцагчид үнэт цаасны зэрэглэл тогтоохоос өөр төрлийн төлбөртэй үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

Зургаа. Зэрэглэл тогтооход тавих хязгаарлалт

6.1. ЗТБ-ын хувьцаа эзэмшигч зээл олгогч байгууллага бол түүний удирдах албан тушаалтан, ажилтанууд нь ЗТБ-ын удирдах болон гүйцэтгэх ажилтан, Зэрэглэлийн хорооны гишүүн байхыг хориглоно.

6.2. ЗТБ нь дараах этгээдүүдэд үнэт цаасны зэрэглэл тогтоохыг хориглоно:

- 6.2.1. өөрийн гаргасан үнэт цаас;
- 6.2.2. өөрийн холбогдох этгээд;
- 6.2.3. хувьцаа эзэмшигч;
- 6.2.4. хувьцаа эзэмшигчийн зээлдэгч;
- 6.2.5. хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд;
- 6.2.6. өөрийн ажилтан харилцагч байгууллагад давхар ажил эрхэлдэг бол.

Долоо. Хорооны хяналт, шалгалт

7.1. Хороо ЗТБ-ын үйл ажиллагааг дараах чиглэлээр хянан шалгана:

- 7.1.1. энэ журмын 5.8 дахь хэсэгт заасан баримт бичгийн хадгалалт;
- 7.1.2. энэ журмын 1.2 дахь хэсэг болон бусад холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт;
- 7.1.3. хөрөнгө оруулагч, харилцагч, бусад этгээдүүдээс ЗТБ-ын үйл ажиллагаатай холбоотой тодорхой асуудлаар ирүүлсэн өргөдөл.

7.2. Энэ журмын 7.1 дэх хэсэгт заасны дагуу хяналт, шалгалт хийхдээ ЗТБ-д хуанлийн араваас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

7.3. Хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцтэй гэж Хороо үзвэл гэнэтийн шалгалт хийж болох ба энэ талаар шалгалтын удирдамжид тэмдэглэнэ.

7.4. Энэ журмын 7.1 дэх хэсгийн хүрээнд хийх хяналт нь аливаа үнэт цаасны тогтоосон зэрэглэл тохиромжтой эсэхийг шалгахгүй.

7.5. Үнэт цаасны тогтоосон зэрэглэлийн талаар ирсэн гомдлын дагуу Хороо зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дангаар, эсхүл хөндлөнгийн туршлагатай экспертүүд оролцсон ажлын хэсэг томилон шалгалт хийж болно.

7.6. Шалгалтын хугацаанд ЗТБ дараах үүргийг хүлээнэ:

7.6.1. шалгалтын ажлын хэсгийн гишүүдийг өөрийн байгууллагын нэр дээр ашиглаж буй ажлын болоод бусад зориулалтын байранд саадгүй нэвтрүүлж, шалгалтад бүхий л талаар дэмжлэг үзүүлнэ;

7.6.2. шалгалтын ажлын хэсгийн шаардсан санхүүгийн бүртгэл, тайлан, тайлбар, бусад мэдээллийг заасан хугацаанд гарган өгөх, мэдээллийн санд шалгалт хийх боломжоор хангах, баримт бичгийг шаардлагын дагуу хувилж өгөх;

7.6.3. ажлын хэсэг шалгалтын хугацаанд шалгалттай холбоотой асуудлаар ЗТБ-ын ажилтнуудын тайлбарыг хянан магадлах, баримтжуулах эрхээр хангагдсан байна;

7.7. Шалгалтын ажлын хэсэг шалгалтын тайланг, шаардлагатай бол явцын тайланг бэлтгэн Хорооны удирдлагад танилцуулна.

7.8. Хороо шалгалтын тайлан, дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авна.

Найм. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

8.1. ЗТБ-ын тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

8.1.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр;

8.1.2. санхүүгийн тайлан, мэдээг хоёр улирал дараалан ирүүлээгүй;

8.1.3. энэ журамд заасан ирүүлбэл зохих бусад тайлан, мэдээ, мэдээллийг хугацаанд нь ирүүлээгүй;

8.1.4. зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд төлөөгүй;

8.1.5. энэ журмын нөхцөл шаардлага хангагдахгүй болсон.

8.2. Түдгэлзүүлсэн шалтгаан арилсан гэж үзвэл ЗТБ-ын хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

8.3. ЗТБ-ын тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

8.3.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30.1, болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр;

8.3.2. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаагүй;

8.3.3. хөрөнгө оруулагч, харилцагч, үнэт цаасны зах зээлд хохирол учруулсан;

8.3.4. ёс зүйн болоод мэргэжлийн ноцтой алдаа гаргасан;

8.3.5. татан буугдсан, дампуурсан;

8.3.6. энэ журмын нөхцөл, шаардлага хангагдахгүй болсон.

8.4. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тохиолдолд харилцагчийн эрх ашгийг зайлшгүй хамгаалах шаардлагатай гэж үзвэл эхлүүлсэн зэрэглэл тогтоох үйл ажиллагааг хийж дуусгахыг ЗТБ-д зөвшөөрч болно.

8.5. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, “ХҮЧИНГҮЙ” тэмдэг дарж тухайн байгууллагын хувийн хэрэгт хавсарган, холбогдох журмын дагуу архивт шилжүүлнэ.

8.6. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд Хороо тухайн ЗТБ-тай хамтарсан ажлын хэсэг томилж, зэрэглэл тогтоох үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг, тайлан, мэдээ, мэдээллийг харилцагчдын сонгосон тусгай зөвшөөрөл бүхий ЗТБ-уудад шилжүүлнэ.

8.7. Хороо ЗТБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай олон нийтэд мэдээлнэ.

Ес. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, оноосон нэр өөрчлөх, гүйцэтгэх захирал томилох, чөлөөлөх, салбар нээх

9.1. ЗТБ нь хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, оноосон нэр өөрчлөх, гүйцэтгэх захирал томилох, салбар нээхэд Хорооноос зөвшөөрөл авна.

9.2. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

9.2.1. өөрчлөлт оруулах тухай хүсэлт;

9.2.2. эзэмшиж буй хувьцааг бусдад худалдахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, холбогдох бусад баримт бичиг;

9.2.3. компаний дүрэмд оруулах өөрчлөлт.

9.3. Хороо ЗТБ-ын хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг холбогдох хууль, тогтоомж, энэ журмын дагуу хянаж шийдвэрлэнэ.

9.4. ЗТБ нь нээлттэй хувьцаат компани бол энэ журмын 9.2 дахь хэсэгт хамаарахгүй.

9.5. ЗТБ-ын оноосон нэр өөрчлөхөд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

9.5.1. оноосон нэр өөрчлөх тухай хүсэлт;

9.5.2. оноосон нэрээ өөрчлөх болсон шалтгаан;

9.5.3. ЗТБ-ын оноосон нэр өөрчлөх тухай шийдвэр;

9.5.4. Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан шинэ оноосон нэрийн баталгаажуулах хуудас;

9.5.5. компанийн дүрэмд оруулах өөрчлөлт;

9.5.6. шаардлагатай бусад баримт бичиг.

9.6. Хороо ЗТБ-ын оноосон нэр өөрчлөх тухай хүсэлтийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хянаж шийдвэрлэнэ.

9.7. ЗТБ-ын гүйцэтгэх захирал томилоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

9.7.1. гүйцэтгэх захирал томилох тухай хүсэлт;

9.7.2. гүйцэтгэх захирлыг өөрчилөх тухай шийдвэр, тайлбар.

9.8. Хороо ЗТБ-ын оноосон нэр өөрчлөх тухай хүсэлтийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хянаж шийдвэрлэнэ.

9.9. ЗТБ нь салбартай байж болох бөгөөд салбар нээхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

9.9.1. салбар нээх тухай хүсэлт;

9.9.2. энэ журмын Маягт 1, Маягт 3, Маягт 4-ийг бүрдүүлж ирүүлэх.

9.10. Хороо ЗТБ-ын салбар нээх тухай хүсэлтийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хянаж шийдвэрлэнэ.

Арав. Хариуцлага

10.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэр гарснаас хойш энэ журмын 8.4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд үнэт цаасны зэрэглэл тогтоох үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

10.2. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэнэ.

10.3. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш арван дөрөв хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

---000---

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай
этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ийн есдүгээр хавсралт

ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫГ БҮРТГЭХЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69-р зүйлд тусгагдсан үнэт цаасны зах зээл дэх Өөрийгөө зохицуулах байгууллага (цаашид “ӨЗБ” гэх)-ыг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. “ӨЗБ” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-д заасан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

1.2.2. “ӨЗБ-ыг бүртгэх” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 71.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг бүртгэхийг;

1.2.3. “ӨЗБ-ын үйл ажиллагаанд тавих хяналт” гэж ӨЗБ-ын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд Хороо холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хийж, олон нийтэд мэдээлэхийг.

Хоёр. ӨЗБ-ын үйл ажиллагааны зарчим, хориглох зүйл

2.1. ӨЗБ нь дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллана:

2.1.1. хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журмыг мөрдөх;

2.1.2. гишүүдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, тэдгээрийн санал санаачлагыг дэмжих;

2.1.3. үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөцийн шалгуурыг хангах;

2.1.4. мэргэжлийн ёс зүй, сахилгын хариуцлага хүлээлгэх дотоод хяналтын бүтэцтэй байх;

2.1.5. гишүүнчлэлийн хураамжийн зарцуулалтын тайлагнал ил тод, нээлттэй байх;

2.1.6. үнэт цаасны зах зээлийн нөхцөл байдал, гишүүдийн үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээнийх, гишүүн байгууллагуудад зэрэглэл тогтоох;

2.1.7. ӨЗБ нь дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Гурав. ӨЗБ-ын бүртгэлийн шалгуур

3.1. Бүртгүүлэхийг хүсч буй хуулийн этгээд нь дараах шалгуурыг хангасан байна.

3.1.1. Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;

3.1.2 нийт тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн тавиас дээш хувийн гишүүнчлэлтэй байх;

3.1.3. мэргэжлийн ёс зүй, сахилгын шийтгэл ногдуулах болон дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэшсэн бүтэцтэй байх;

3.1.4. удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага нь сүүлийн 5 жилд зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтнаар ажиллаагүй байх;

3.1.5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 72 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагад

нийцсэн дараах зүйлийг дүрэм, журамдаа тусгаж, бүх гишүүдийн хурлаар батлуулсан байх:

3.1.5.1. гишүүнээр элсүүлэхэд тавих шаардлага, гишүүнчлэлийн хураамж, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах журам;

3.1.5.2. гишүүд, тэдгээрийн ажилтнуудын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм;

3.1.5.3. гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих болон гомдол, маргааныг хянан шийдвэрлэх журам;

3.1.5.4. ӨЗБ-ын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам;

3.1.5.5. гишүүдэд сургалт явуулах, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах журам;

3.1.5.6. зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцохоос урьдчилан сэргийлэх зэрэг шударга арилжааг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах журам.

3.1.6. Үнэт цаасны зах зээл дээр тав болон түүнээс дээш хугацаанд тогтмол үйл ажиллагаа явуулсан байх;

3.1.7. Зах зээлийн дүн, шинжилгээ хийх судлаач болон сургалт хариуцсан орон тооны мэргэжилтэнтэй байх.

Дөрөв. Бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримт

4.1. Бүртгүүлэхийг хүсч буй хуулийн этгээд нь энэхүү журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтыг Хороонд ирүүлнэ.

4.1.1. бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу/;

4.1.2. ӨЗБ-аар бүртгүүлэх тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр;

4.1.3. улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.1.4. ӨЗБ-ын дүрэмд дараахь зүйлийг тусгасан байна:

4.1.4.1. бүх гишүүдийн хурал хуралдах журам;

4.1.4.2. бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон дотоод хяналтын эрх, үүрэг, хариуцлага;

4.1.4.3. удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх журам, бүрэн эрхийн хугацаа;

4.1.4.4. өөрчлөн байгуулах, татан буулгах үндэслэл;

4.1.4.5. дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл;

4.1.4.6. хууль тогтоомжид заасан бусад.

4.1.5. гишүүдийн нэрс болон тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээлэл;

4.1.6. удирдах зөвлөлийн дарга, гишүүний тодорхойлолт /энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу/;

4.1.7. гүйцэтгэх удирдлага, мэргэжилтний тодорхойлолт /энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу/;

4.1.8. Хороонд бүртгүүлсэн аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн улирлын санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулж байгаа бол эхлэлтийн баланс;

4.1.9. ӨЗБ-ын дотоод зохион байгуулалтын бүтэц, танилцуулга;

4.1.10. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт.

Тав. ӨЗБ-ыг бүртгэх

5.1. Бүртгүүлэхээр хүсч ирүүлсэн бичиг баримтыг 30 хоногт багтаан хянана.

5.2. Энэ журмын 5.1-д заасан хугацааг ирүүлсэн бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд ирүүлсэн

өдрөөс эхлэн тооцно.

5.3. Хороо шаардлагатай тохиолдолд бүртгүүлэхийг хүсч ирүүлсэн бичиг, баримтын талаар холбогдох байгууллагаас тодруулах, дүгнэлт гаргуулах, лавлагаа авах эрхтэй.

5.4. Энэ журмын 4.1-д заасан бичиг баримтыг дутуу бүрдүүлж, ирүүлсэн тохиолдолд энэ тухай өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэж, нэмэлт бичиг баримтыгшаардана.

5.5. Бүртгүүлэхийг хүсч буй хуулийн этгээдээс ирүүлсэн бичиг баримтыгдараах тохиолдолд ажлын 10 хоногийн дотор буцаана:

5.5.1. ирүүлсэн бичиг баримт нь холбогдох хууль тогтоомж, энэхүү журмын 3.1-д заасан шалгуурыг хангаагүй;

5.5.2. бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь нотлогдсон.

5.6. Бичиг баримтыг буцаах тохиолдолд өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

5.7. Энэхүү журмын 3.1, 4.1-д заасан шалгуур, нөхцлийг хангасан ӨЗБ-ыг бүртгэх тухай шийдвэрийг Хороо гаргана.

5.8. Хорооны шийдвэрийг үндэслэн ӨЗБ-ыг зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

Зургаа. Бүртгэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

6.1. Хороо дараах үндэслэлээр ӨЗБ-ын бүртгэлийг түдгэлзүүлнэ:

6.1.1. холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журмыг зөрчсөн;

6.1.2. бүртгэлийн шалгуурыг хангахгүй болсон;

6.1.3. Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

6.1.4. эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд биш болсон;

6.1.5. хагас болон жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Хороонд ирүүлээгүй;

6.1.6. энэхүү журмын 7.2.2-д заасан болон Хорооноос шаардсан мэдээллийг удаа дараа хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл алдаатай, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн;

6.1.7. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 75.5-д заасан үүргийг биелүүлээгүй;

6.1.8. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

6.2. ӨЗБ нь бүртгэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд түүнийг сэргээлгэх тухай хүсэлтээ Хороонд ирүүлэх бөгөөд бүртгэлийг түдгэлзүүлсэн шалтгааныг арилсан гэж үзвэл Хорооноос уг бүртгэлийг сэргээнэ.

6.3. Хороо дараах үндэслэлээр бүртгэлийг хүчингүй болгоно:

6.3.1. ӨЗБ хүсэлт гаргасан;

6.3.2. бүртгэлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаж, сэргээлгэх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;

6.3.3. хуулийн этгээд татан буугдсан;

6.3.4. ӨЗБ-ын үйл ажиллагаа явуулахад харшлах бусад нөхцөл байдал үүссэн;

6.3.5. Хороонд бүртгүүлэхдээ хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон.

6.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30.2-д заасны дагуу хүчингүй болсон бүртгэлийг сэргээхгүй.

6.5. Хороо ӨЗБ-ыг бүртгэлээс хассан тохиолдолд тухайн байгууллагын бүрэн эрх дуусгавар

болно.

Долоо. Мэдээллийг ил тод болгох болон Хороонд мэдээлэх

7.1. ӨЗБ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 75.1-д заасны дагуу тухайн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор Хороонд ирүүлж, өөрийн цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлнэ.

7.2. Хороо ӨЗБ-ын үйл ажиллагаанд дараах байдлаар зайны болон газар дээрх хяналтыг хэрэгжүүлнэ:

7.2.1. Хороо газар дээрх хяналтыг бүртгэлийн шалгуур, үндсэн болон санхүүгийнүйл ажиллагаандшалгалт хийх баӨЗБ нь шалгалтын ажлын хэсэгт шаардлагатай баримт, холбогдох тайлбарыг зохих журмын дагуу шуурхай гаргаж өгөх үүрэгтэй.

7.2.2. ӨЗБ нь дараах мэдээллийг Хороонд ирүүлэх үүрэгтэй бөгөөд Хороо энэхүү мэдээлэлд үндэслэн зайны хяналтыг гүйцэтгэнэ:

7.2.2.1. үнэт цаасны зах зээлийн нөхцөл, байдлын судалгаа /улирлаар/;

7.2.2.2. нийт гишүүдийн санхүүгийн тайлангийн нэгтгэл /улирлаар/;

7.2.2.3. зохион байгуулсан сургалтын тайлан /тухай бүр/;

7.2.2.4. байгууллагын дүрэм, дотоод журам, бүтэц, эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний өөрчлөлт /тухай бүр/;

7.2.2.5. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

Найм. Хариуцлага

8.1.ӨЗБ, түүний эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн нь хууль,энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Хороо дараах арга хэмжээг авч, нийтэд мэдээлнэ:

8.1.1. анхааруулга хүргүүлэх;

8.1.2. даалгавар өгөх;

8.1.3. байгууллагын үйл ажиллагаанд зарим хязгаарлалт тогтоох;

8.1.4. бүртгэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

8.1.5. хууль тогтоомжид заасан захиргааны хариуцлага ногдуулах.

8.2. ӨЗБ-ын эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний аливаа хууль, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй гэж Хороо үзвэл, хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

8.3. Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

“Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэхэд тавигдах нөхцөл шаардлага”-ын 2 дугаар хавсралт


ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БОЛОН ГИШҮҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

ӨЗБ-ын эрх бүхий албан тушаалтны аль болохыг тэмдэглэнэ үү.

Удирдах зөвлөлийн дарга -

гишүүн -

Удирдах зөвлөлийн дарга болон гишүүн нь дараах мэдээллийг үнэн зөв бөглөж ирүүлнэ:



Зураг

Овог, нэр:

Төрсөн он, сар, өдөр:

Иргэний харьяалал:

Регистрийн дугаар:

Албан тушаал:

Боловсрол: /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Д/д	Сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

Ажлын туршлага:

Д/д	Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Тайлбар

Нэгдмэл сонирхолтой этгээд:

Д/д	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Эрхлэж буй албан тушаал

..... ӨЗБ-ыг төлөөлж

/албан тушаал/

/...../

/гарын үсэг/


/...../

/овог, нэр/

Огноо:

ӨЗБ-ЫН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, МЭРГЭЖИЛТНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

ӨЗБ-ын гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн нь дараах мэдээллийг бөглөнө:



Овог, нэр:

Албан тушаал:

Төрсөн он, сар, өдөр:

Иргэний харъяалал:

Гэрийн хаяг:

Утасны дугаар:

Регистрийн дугаар:

Боловсрол: /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

Ажлын туршлага:

Д/д	Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Тайлбар

Гүйцэтгэх удирдлага, мэргэжилтний холбогдохэтгээд:

Нэгдмэл сонирхолтой этгээд гэдгийг Компанийн тухай хуулийн97дугаарзүйлд тодорхойлсныг ойлгоно.

Д /д	Таны ноу болох	Овог, нэр	Регистрийн №	Эрхэлж буй албан тушаал	Тайлбар
1					
2					

Нэгдмэл сонирхолтой этгээдийн тайлбарт урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, бусдад өр, зээлтэй эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа эсэхийг бичнэ.

. ӨЗБ-ыг төлөөлж
албан тушаал/

/ /
/гарын үсэг/

/ /
/овог, нэр/

Огноо:

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай
этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ийн аравдугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ УРВУУЛАН АШИГЛАХААС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид "Хороо" гэх/ үнэт цаасны зах зээлд оролцогчид, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээд үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тогтоох, зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, хянан шалгах, зөрчлийг таслан зогсоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах гэдэгт "Үнэт цаасны зах зээлд хуурамч арилжаа хийх, үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогч харилцагчийг хууран мэхлэх үйлдэл" гэж томъёолсон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80.1-80.4 дэх хэсэгт заасныг ойлгоно.

1.3. "Үнэт цаасны зах зээлд оролцогч, зохицуулалттай этгээд, холбогдох этгээд, дотоод мэдээлэл, дотоод мэдээлэл эзэмшигч" гэснийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.16, 4.1.17, 4.1.30, 76.1, 77-д заасныг, "эрх бүхий албан тушаалтан" гэж Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д заасныг буюу үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагч, тэдгээрийн холбогдох этгээд; зохицуулалттай этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн холбогдох этгээд; Хорооны эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн, ажилтан тэдгээрийн холбогдох этгээд; үнэт цаасны дотоод мэдээлэл эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээдийг тус тус ойлгоно.

ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ УРВУУЛАН АШИГЛАХ

2.1. Үнэт цаасны тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсэгт заасан үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах "бусад арга хэлбэр" гэдэгт дараах үйлдлийг ойлгоно:

2.1.1. олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон интернет ашиглан олон нийтийг төөрөгдөлд оруулсан, бодит бус, хуурамч мэдээлэл цацах, амлалт өгөх замаар үнэт цаасны үнэ ханш болон эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөхөөр хуурамч мэдээлэл тараах;

2.1.2. үнэт цаасны арилжааны хаалтын ханшид зохиомлоор нөлөөлөх зорилгоор 2 ба түүнээс дээш удаа цөөн тоо ширхэгээр үнэт цаасыг худалдах, худалдан авах хэлцэл хийх;

2.1.3. тодорхой үнэт цаасны өмчлөгч нь өөрчлөгдөхгүй хуурамч гүйлгээ хийх эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хооронд үнэт цаасыг 2 ба түүнээс дээш удаа худалдах, худалдан авах хэлцэл хийх;

2.1.4. тодорхой үнэт цаасны арилжаа идэвхитэй явагдаж байгаа мэт олон давтамжтай хэлцлүүдийг зах зээлийн оролцогчдыг төөрөгдүүлэх зорилгоор үгсэн тохиролцож хийх;

2.1.5. үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх зорилгоор урьдчилан тохирсон талууд нэг төрлийн үнэт цаасыг ижил үнээр, ижил хэмжээгээр 2 ба түүнээс дээш удаа худалдах, худалдан авах захиалгыг зэрэг өгч хэлцэл хийх;

2.1.6. нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор өсгөх,

(бууруулах) зорилгоор үнэт цаасыг худалдан авах, (худалдах) үнийг өсгөж, бууруулах, цөөн тооны үнэт цаасыг 2 ба түүнээс дээш удаа худалдах, худалдан авах хэлцэл хийж, үнэт цаасны ханш тодорхой түвшинд хүрсний дараа худалдах, худалдан авах замаар ашиг олох;

2.1.7. 2 буюу түүнээс дээш удаад үнэт цаасны ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор идэвхитэй арилжааг урьдчилан зохион байгуулах;

2.1.8. үнэт цаасны зохиомол эрэлт, нийлүүлэлтийг үүсгэж зохиомлоор ханшийн өсөлт, бууралтыг бий болгох;

2.1.9. зохицуулалттай этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан нь өөрсдийн мэдэлд байгаа болон холбогдох этгээдийн дансуудыг ашиглан өөрт байгаа мэдээллээ давуу байдалтайгаар ашиглан захиалга хийх;

2.1.10. зохицуулалттай этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан нь харилцагчийн захиалгаас түрүүлж өөрийн эзэмшлийн данснаас захиалга оруулах, харилцагчийн өгсөн захиалга нь тухайн үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхүйц байгаа тохиолдолд өөрийн болон компанийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах болон худалдан авахыг ятгах;

2.1.11. цахим арилжааны системд биелүүлэх зорилгогүй тодорхой үнэт цаасыг худалдахаар санал болгож буй үнээс бага, худалдан авахаар санал болгож буй үнээс өндөр үнээр захиалга өгч, хэлцэл хийгдэхээс өмнө саналаа 2 ба түүнээс дээш удаа татах замаар үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх оролдлого хийх;

2.1.12. харилцагчийн өгсөн үнэт цаас худалдах болон худалдан авах захиалгын төрөл, хүчинтэй байх хугацаа, тоо ширхэг, нэгж үнийг харилцагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөх;

2.1.13. дотоод мэдээлэл эзэмшигч, түүний холбогдох этгээд үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцох.

2.2. Үнэт цаасны тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсэгт заасан үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах "бусад арга хэлбэр" гэдэгт энэ журмын 2.1.1-2.1.13-т заасан үйлдлүүдээс гадна дараах зорилго бүхий үйлдлүүдийг хамааруулж болно:

2.2.1. үнийг зохиомлоор бууруулан хямд үнээр худалдаж авах эсхүл үнийг зохиомлоор өсгөн өндөр үнээр худалдах үйлдэл, ийм үйлдэл хийхийг тушаасан, даалгасан дээд шатны эрх бүхий этгээдийн бичгээр болон амаар өгсөн шийдвэр;

2.2.2. үнэт цаасны үнийг зохиомлоор өсгөн өндөр үнээр худалдах;

2.2.3. анхдагч зах зээлд гаргаж буй үнэт цаасны үнэд нөлөөлөх;

2.2.4. компанийн хэлбэрийг өөрчлөх үед үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх;

2.2.5. компани хувьцаагаа хуваах, нэгтгэх үед үнэт цаасны үнэ ханш болон хувьцаа хөрвүүлэхэд нөлөө үзүүлэх; 2.2.6. гуравдагч этгээдийн активыг худалдан авах /худалдах сонирхол төрүүлэх болон худалдах/ худалдан авахаас татгалзах нөхцлийг бүрдүүлэх;

2.2.7. хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авахтай холбоотойгоор үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх;

2.2.8. худалдаж авахаар санал болгох үнэ бусад томоохон хэлцэлд зохиомлоор нөлөөлөх;

2.2.9. зах зээлийн индексэд ач холбогдол бүхий үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх;

2.2.10. мэргэжлийн хөрөнгө оруулагчдын санхүүгийн тайланд нөлөөлөх;

2.2.11. мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшиж байгаа үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх;

2.2.12. мэргэжилтэн болон шинжээчдийн дүгнэлт, зөвлөмжид өөрчлөлт үзүүлэх зорилгоор үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх;

2.2.13. тухайн үнэт цаасны арилжааг идэвхитэй харагдуулах зорилгоор арилжааны тОО хэмжээнд зохиомлоор нөлөөлөх;

2.2.14. үнэт цаас гаргагч буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн зүгээс их хэмжээний хэлцэл болон багцын арилжаа явуулахтай холбоотойгоор үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх;

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ УРВУУЛАН АШИГЛАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

3.1. Зохицуулалттай этгээд үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

3.1.1. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д заасан үнэт цаасны зах зээлд хуурамч арилжаа хийх, үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогч, харилцагчийг хууран мэхлэх замаар арилжаанд оролцуулах, эсхүл оролцуулахгүй байх зорилготой үйлдлүүд, энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1.1-2.1.13, 2.2.1-2.2.13 дахь заалтуудад заагдсан үйлдлүүдийг хийхгүй байх;

3.1.2. энэ журмын 3.1.1-д заасан үйлдлүүдийг хийхээс сэргийлсэн дотоод хяналтын тогтолцоо, дараалсан болон давхар хяналтын тогтолцоо бүрдүүлэн ажиллах;

3.1.3. бүртгэлийн болон мэдээлэл, тайлагналын зохистой бүтэц, стандартад шилжих;

3.1.4. үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж зөрчсөн, зах зээлийг урвуулан ашиглах зорилго агуулсан харилцагчийн болон холбогдох этгээдийн үнэт цаасны захиалгыг хүлээн авахгүй, татгалзах; 3.1.5. харилцагчийн олон нийтэд мэдээлэгдээгүй, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлж болохуйц арилжааны мэдээ, санхүүгийн болон бусад нууц мэдээллийг ашиглах, дамжуулахгүй байх;

3.1.6. сонирхолын зөрчилтэй хэлцэл хийхгүй байх, хэрвээ хийсэн бол энэ талаарх мэдээллийг өөрийн компанийн удирдлагад ил тод мэдэгдэх; 3.1.7. дотоод хяналтын ажилтан нь компанийн үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа болон харилцагчийн захиалга хүлээн авах, биелүүлэх үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах;

3.1.8. компанийн болон өөрийн дансаар дамжуулан зах зээлийг урвуулан ашиглах үйлдэл гаргахгүй байх;

3.1.9. харилцагчийн захиалгын гэрээ, дилерийн даалгавар, мөнгө хүссэн өргөдөл зэрэг үнэт цаасны арилжааны аливаа анхан шатны баримтууд, утсаар хүлээн авсан захиалга, харилцагчийн факс, и-мэйлээр ирүүлсэн захиалгыг бүртгэж, хадгалах;

3.2. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр брокер дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1. брокер нь мэргэжлийн үнэмлэх бүхий этгээд мөн эсэхийг шалгах;

3.2.2. брокер нь хууль бус үйл ажиллагаа явуулж байсан эсэх, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхийг шалгах;

3.2.3. брокероор ажилласан түүхийг шалгана. Тухайн брокерийн урьд нь ажиллаж байсан Брокер, дилерийн компани, харилцаж байсан харилцагч нарын талаарх мэдээлэл болон тэдгээр харилцагч нарын мэдээллийг дараагийн арилжаанд ашигласан эсэхийг шалгах;

3.2.4. брокер нь харилцагчид үйлчлэх зохих шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгана. Шаардлагатай түвшний ажлын байр, техник, тоног төхөөрөмж, технологи, программ хангамж, боловсон хүчин байгаа эсэхийг шалгах;

3.3. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дилер дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. дилер нь хөрөнгийн биржэд бүртгэлтэй компанийн хувьцааны үнэ, ханшид нөлөөлж байгаа эсэхийг шалгах;

3.3.2. дилер нь брокерээс авсан захиалгыг үнэн зөв тэмдэглэсэн эсэхийг шалгаж, захиалгын хуудсанд бичигдсэн захиалга болон явагдсан арилжааг тулгах;

3.3.3. их хэмжээний хэлцэл тус бүрийг шалгах;

3.3.4. ханшийн өсөлт, бууралт ихтэй /15 хувиас их/ арилжааг шалгах;

3.3.5. дилерийн дансанд арилжигдсан үнэт цаасны үнэ, ханшийн зөрүү, харилцагчийн дансны үнэ, ханшийн зөрүүг шалгах;

3.3.6. дилерийн хийсэн арилжааны долоо хоног, сар, улирлын давтамжийг шалгах;

3.3.7. Хөрөнгийн биржийн зүгээс дилерийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа эсэхэд давхар хяналт тавих;

3.4. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хөрөнгө оруулалтын зөвлөх нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1. хөрөнгө оруулалтын зөвлөх нь үйлчлүүлэгчийн дотоод мэдээллийг ашиглаж байгаа байдалд хяналт тавих;

3.5. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр итгэмжлэн удирдах этгээд дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.5.1. итгэмжлэн удирдах этгээд итгэмжлүүлэгчийн хувьцааг хувьдаа худалдан авсан эсэхийг шалгах;

3.5.2. итгэмжлэл хүчин төгөлдөр эсэх, итгэмжлэлээр олгосон үйлдэл тодорхой эсэх, зааварчлагатай эсэхийг шалгах;

3.5.3. гэрээний нөхцөл, журмыг шалгах;

3.6. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр

андеррайтер дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.6.1. андеррайтер нь үйл ажиллагаа тогтмол явуулж байгаа эсэхийг шалгах;

3.6.2. андеррайтерийн үйл ажиллагааны талаар олон улсын холбогдох байгууллагуудаас мэдээлэл авч шалгах;

3.6.3. Монгол Банктай хамтарсан шалгалт хийх, Санхүүгийн мэдээллийн албанаас мэдээлэл авч шалгах;

3.6.4. үнэт цаас гаргаж, хөрөнгө босгож байгаа үйл ажиллагаа зориулалтын дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавих, хоёр долоо хоног, нэг сар, улирлаар тайлан авч шалгах;

3.7. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.7.1. өмчлөх эрхийн бүртгэлийн байгууллага дахь бүртгэл үнэн, зөв хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих, хувьцаат компани бүрээр, өмчлөгч бүрээр хийгдэх бүртгэлийг шалгах; 3.7.2. бүртгэлийн үйл ажиллагааг бүхэлд нь хянах;

3.8. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр арилжааны тооцооны үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ: 3.8.1. эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг мэргэшсэн, тогтвортой байдлаар явуулж байгаа эсэхийг шалгах;

3.8.2. ашиглаж байгаа програм хангамж шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах;

3.8.3. IOSCO-ийн зарчмуудыг мөрдөж байгаа эсэхийг шалгах;

3.8.4. тооцооны үйл ажиллагаанд тавих хяналтын горимыг шалгах;

3.8.5. үнэт цаасны арилжааны явцад хийгдсэн гэрээ, хэлцэл цуцлагдах аливаа эрсдлийг бууруулах зорилготой тусгай сангийн үйл ажиллагааг шалгах;

3.9. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр арилжааны төлбөрийн үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.9.1. арилжааны төлбөрийн үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг ашиглаж байгаа байдалд хяналт тавих;

3.9.2. үнэт цаасны зах зээлд давамгайл байдал үүсгэх үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд

хяналт тавих; 3.9.3. харилцагч хууль бусаар татах үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;

3.10. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.10.1. төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааны явц дахь дотоод мэдээллийн нууцлалд хяналт тавих, дотоод мэдээлэл эзэмшигчдэд хяналт тавих;

3.10.2. мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавих;

3.10.3. төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааны явц дахь өмчлөх эрхийн шилжилт, хөдөлгөөнд хяналт тавих;

3.10.4. төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааны автоматжуулалт, мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандарт мөрдөж байгаа байдал, боловсон хүчний бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих;

3.10.5. мэдээллийн нөөц хувилбарын хадгалалт, архивлалт, нууцлалтад хяналт тавих;

3.11. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр кастодианы үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.11.1. өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих;

ДӨРӨВ. АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

4.1. Үнэт цаасны арилжааг ил тод, алдаагүй, шударгаар зохион байгуулж, хяналт тавих;

4.2. Үнэт цаасны арилжааны явц болон арилжаа явагдаж дууссаны дараа үнэт цаасны үнэ ханшийн хэлбэлзэл, арилжигдсан тоо ширхэг зэргийг үндэслэн зөрчилтэй байж болзошгүй сэжиг бүхий хэлцлүүдийг бүртгэн нарийвчилсан шалгалт явуулах;

4.3. Арилжааны хэмжээ болон ханшийн өөрчлөлтийн дагуу зах зээлийг урвуулан ашиглах зорилготой хэлцэл, эсхүл үйлдэл хийгдсэн эсэхийг шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд шалгалтын тайланг холбогдох нотлох баримтын хамт Хороонд хүргүүлэх;

4.4. Энэ журмын 6.7.4-т заасан Хорооны Улсын байцаагчийн дүгнэлт гарахаас өмнө шалгалтын талаар олон нийтэд мэдээлэхгүй байх;

ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ БОЛОН ХАРИЛЦАГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТЭДГЭЭРИЙН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

5.1. Энэ журмын 2-д заасан үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйлдэл гаргахгүй байх;

5.2. Зах зээлийг урвуулан ашиглах үйлдэлд тооцогдох, эсхүл үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх зорилго агуулсан худалдах, худалдан авах захиалга өгөхгүй байх;

5.3. Хорооны Улсын байцаагчийг шалгалт хийх нөхцөл бололцоогоор бүрэн хангаж, шаардлагатай мэдээ, мэдээлэл, гэрээ хэлцлийг хугацаанд нь бүрэн гаргаж өгөх;

5.4. Тодорхой үнэт цаасыг худалдан авахад дансан дахь бэлэн мөнгө хүрэлцэхгүй тохиолдолд үнэт цаас худалдан авах захиалга өгөхгүй байх;

5.5. Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам"-ын дагуу олон нийтэд мэдээлж ажиллах;

5.6. Үнэт цаас гаргагч нь халаасны хувьцаа худалдан авах мэдээллийг олон нийтэд мэдээлэх.

ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ УРВУУЛАН АШИГЛАХААС СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТАВИХ ХЯНАЛТ

6.1. Зохицуулалттай этгээд үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

6.2. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасыг зохих журмын дагуу бүртгэн, техник программ хангамжийн найдвартай байдлыг хангаж, олон нийтийг үнэт цаасны арилжааны мэдээ, мэдээллээр хангаж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

6.3. Хорооноос авч явуулах үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт хийх, зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг Хорооны Ажлын Албаны Хяналт шалгалтын газар, улсын байцаагч хэрэгжүүлнэ.

6.4. Хяналт шалгалтын ажлыг дараах хэлбэрээр явуулна.

6.4.1. Зайны хяналт;

6.4.2. Газар дээрх хяналт;

6.5. Үнэт цаасны арилжааны өдөр тутмын үйл ажиллагаанд "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн арилжааны хяналтын "Investgation manager", "Market Replay", "Surveillance" програмуудыг ашиглан зайны хяналт тавина.

6.6. Зайны хяналтын үед:

6.6.1. хяналтын программаар МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудын жагсаалт ба өдөр бүрийн үнэт цаасны арилжааны хэлцлийн задаргааг харж, хяналтын программ дээр үүссэн сэрэмжлүүлэх дохионы дагуу /Alert/ сэжигтэй хэлцлүүдийг дэлгэрүүлэн шалгаж зөрчилтэй гэж үзсэн хэлцлүүдийн баримтыг МХБ, ҮЦК-иас гаргуулан авч нарийвчлан шалгана.

6.6.2. үнэт цаасны хэлцлүүдийг графикаар харуулах, тухайн хэлцлийн худалдан авах, худалдах захиалгыг оруулсан огноо, цаг минутыг хараад үнэт цаасны арилжааны явцад хувьцааны ханш хэт өссөн, буурсан хэлцэл болон цөөн тоо ширхэгээр хийгдсэн хэлцлийг шалгана.

6.6.3. үнэт цаасны үнэ ханшийн хэлбэлзэл, арилжигдсан тоо ширхэг зэргийг үндэслэн зөрчилтэй байж болзошгүй сэжигтэй хэлцлийг худалдан авсан, худалдсан дансны эзэмшигчид нь нэгдмэл сонирхолтой эсэхийг шалгана.

6.6.4. тухайн сэжиг бүхий арилжааны хэлцлүүд, арилжаанд оролцсон талуудын мэдээлэл зэргийг хяналтын програмаас татан авч, хэлцлийн авах, зарах захиалгын дараалал, арилжааны програмд журмын дагуу үнэн, зөв шивж оруулсан эсэх, үнэт цаасны ханшид үзүүлсэн нөлөөлөл, цөөн тоо, ширхэгээр олон давтамжтай арилжаа хийгдсэн эсэхийг шалгана.

6.6.5. зайны хяналтаар сэжиг бүхий хэлцэл хийгдсэн гэж үзсэн тохиолдолд тухайн үнэт цаасны арилжааг шалгуулах тухай хүсэлтийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-д албан бичгээр гаргаж, шалгалтын тайлан, дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулан авна.

6.6.6. анхдагч зах зээлийн арилжаа болон бусад төрлийн үнэт цаасны өрийн хэрэгсэл, үүсмэл үнэт цаас гэх мэт/ арилжаа явагдах тохиолдолд үнэт цаас нийлүүлэх үйл ажиллагаанд арилжаа зохион байгуулагч хэрхэн хяналт тавьж байгааг давхар хянан шалгана.

6.7. Газар дээрх хяналтын үед:

6.7.1. сэжиг бүхий хэлцэл хийхэд оролцсон талууд болох тухайн үнэт цаас гаргагч, түүний толгой, охин болон хараат компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан түүний холбогдох этгээдүүд, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан түүний холбогдох этгээдүүд, хөрөнгө оруулагч, тэдгээрийн холбогдох этгээдүүдийн хийсэн сэжиг бүхий хэлцлүүдийн анхан шатны баримтыг нэг бүрчлэн гаргуулан авна.

6.7.2. дээрх сэжиг бүхий хэлцэл хийхэд оролцсон холбогдох этгээдүүдтэй биечлэн уулзаж, газар дээрх шалгалтын ажлыг зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд албан ёсны тайлбар, тодруулгыг бичгээр гаргуулан авна.

6.7.3. арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаас

шалгалтад шаардлагатай баримт материал, бүртгэл, судалгаа, тайлбар тодруулга зэрэг бүхий л мэдээлийг бичгээр гаргуулан авна.

6.7.4. Хорооны Улсын байцаагч нь дээрх зайны болон газар дээрх хяналт, шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлсний үндсэн дээр, "Монголын хөрөнгийн бирж" ХК-иас ирүүлсэн шалгалтын тайлан, нотлох баримтыг хянаж үзээд арилжаанд оролцсон талууд нь Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашигласан үйлдэл гаргасан эсэхэд дүгнэлт гаргана.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Хорооны Ажлын албаны Хяналт шалгалтын газар энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж, уг журмыг зөрчсөн этгээдэд Хорооны Улсын байцаагч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Зохицуулалттай этгээд тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан нь үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон, зах зээлийг урвуулан ашиглах хууль бус зөрчлийг удаа дараа давтан үйлдсэн бол эрх бүхий албан тушаалтны үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг нь хүчингүй болгох арга хэмжээ авч, зохицуулалттай этгээдийн үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

7.3. Үнэт цаасны зах зээлд оролцогч, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээдийн үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон, зах зээлийг урвуулан ашигласан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.4. Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон, зах зээлийг урвуулан ашигласан үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол тус Хороо холбогдох баримт бичгийг эрх бүхий хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай
этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ийн арваннэгдүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан үнэт цаасны арилжааны тооцооны байгууллагын үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдох арилжаа эрхлэх байгууллагын арилжааны хэлцлийн үр дүнд үүсэх тооцоог боловсруулан баталгаажуулах, төлбөр гүйцэтгэх даалгаврыг эрх бүхий төлбөрийн байгууллагад илгээх, төлбөрийн эрсдэлийг системийн хэмжээнд удирдах, тооцооны үйл ажиллагаанд оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмын харилцаанд Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон Хорооноос тогтоосон бусад хэм хэмжээг дагаж мөрдөнө.

ХОЁР. ЖУРМЫН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Энэхүү журамд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэр томъёоноос гадна дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "Үнэт цаасны арилжааны тооцооны байгууллага" /цаашид "Тооцооны байгууллага" гэх/ гэж үнэт цаасны арилжааны төлбөрий үүргийг гүйцэтгэхэд худалдагчийн өмнө худалдан авагч худалдан авагчийн өмнө худалдагч болж дундын зуучлал үзүүлж буй зохицуулалттай этгээдийг;

2.1.2. "Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа" гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43 дугаар зүйл болон энэхүү журмын 2.1.1-д заасан байгууллагын үйл ажиллагааг;

2.1.3. "Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаанд оролцогч байгууллага" гэж төлбөрийн харилцаанд оролцож буй үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны хадгаламжийн байгууллага, төлбөр гүйцэтгэгч байгууллага болон бусад оролцогч зохицуулалттай этгээдийг;

2.1.4. "Үнэт цаасны төлбөр гүйцэтгэх байгууллага" гэж үнэт цаасны арилжааны тооцооны байгууллагын баталгаажуулсан тооцооллын үндсэн дээр, түүний даалгавраар төлбөрийг гүйцэтгэх банкийг болон үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай этгээдийг;

2.1.5. "Тооцооны байгууллагын гишүүн" гэж тооцооны байгууллагын гишүүнчлэлийн шаардлага, шалгуурыг хангасан зохицуулалттай этгээдийг;

2.1.6. “төлбөрийн чадварын эрсдэл” гэж тооцооны байгууллагын гишүүний /худалдах, худалдан авах тал/ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүсэх болзошгүй алдагдлыг;

2.1.7. "Маржин" гэж үнэт цаасны арилжааны тооцооны байгууллагын баталгаажуулсан арилжааны хэлцлийн анхны үнийн дүн болон тооцооны гишүүн төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд тооцооны байгууллагаас тухайн арилжааны төлбөрийг гүйцэтгэхэд хүлээгдэж буй үнийн дүнгийн зөрүүг;

2.1.8. "Барьцаа" гэж Тооцооны байгууллагын тооцоолсон маржингийн дүнгээр төлбөр гүйцэтгэх байгууллагад тооцооны гишүүний байршуулах хөрөнгийг;

ГУРАВ. ТООЦООНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

3.1. Тооцооны байгууллага нь дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримтална.

3.1.1. эрхлэх үйл ажиллагааны хүрээнд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, түүнд нийцсэн дүрэм, журамтай байх;

3.1.2. ил тод засаглалтай байх ба санхүүгийн зах зээлийн найдвартай, үр ашигтай байдлыг дэмжих, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах;

3.1.3. төлбөр түргэн гүйцэтгэх, үйл ажиллагааны, төлбөрийн чадварын болон бусад эрсдэлийг иж бүрэн удирдах эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх;

3.1.4. тооцооны үйл ажиллагаатай холбоотой оролцогчдын төлбөрийн чадварын эрсдэлийг тооцоолох, хянах, удирдах, тооцооны гишүүн бүрийн төлбөрийн чадварын эрсдэлийг хаах, барагдуулах хангалттай хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй байх;

3.1.5. төлбөрийн эсрэг нийлүүлэлт хийх зарчмыг баримтлах.

ДӨРӨВ. ТООЦООНЫ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Тооцооны байгууллага нь маржингийн тооцооллын үндсэн дээр эрсдэлийг бууруулах зорилгоор тооцооны гишүүнээс барьцаа шаардах эрхтэй бөгөөд маржинг тооцоолох эрсдэлд суурилсан тусгай аргачлал, загварыг батална.

4.2. Барьцаанд байршуулсан барьцааны хадгалалтад тооцооны байгууллага нь хариуцлага хүлээхгүй бөгөөд барьцааг гэрээний үндсэн дээр захиран зарцуулах эрхтэй.

4.3. Тооцооны үйл ажиллагааны журам, гэрээний хэрэгжилтэд тооцооны байгууллага хяналт тавих эрхтэй. гүйцэтгэх баталгааг

4.4. Тооцооны байгууллага нь үнэт цаасны арилжааны төлбөрийг гаргаж, системийн эрсдэлийг удирдах үүрэгтэй.

4.5. Тооцооны байгууллага нь барьцаанд хүлээн зөвшөөрөх үнэт цаасыг тодорхойлох, түүний өртгийг тогтоох үүрэгтэй.

4.6. Тооцооны байгууллага нь үйл ажиллагааны хүрээнд дараах журмыг баталж мөрдөх бөгөөд Хороогоор батламжлуулна. Үүнд:

4.6.1. үнэт цаасны арилжааны тооцоог гүйцэтгэх үйл ажиллагааны журам;

4.6.2. тооцооны үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдэлээс хамгаалах сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам;

4.6.3. тооцооны үйл ажиллагаанд оролцогчдын хооронд мэдээ, мэдээлэл солилцох, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангах журам;

4.6.4. тооцооны байгууллагын гишүүнчлэлийн журам;

4.6.5. тооцооны байгууллагын гишүүдийн төлбөрийн чадварын эрсдэлийг удирдах,

зохицуулах журам;

4.6.6. давагдашгүй хүчин зүйлийн үед авах арга хэмжээний журам;

4.6.7. тооцооны үйл ажиллагаатай холбоотой бусад дүрэм, журам.

4.7. Үнэт цаасны арилжааны тооцоог гүйцэтгэх үйл ажиллагааны журамд дараах харилцааг заавал тусгасан байна:

4.7.1. үнэт цаасны арилжааны тооцоог гүйцэтгэх хугацаа, дараалал;

4.7.2. үнэт цаасны төрлөөс хамаарч тооцооллыг гүйцэтгэх аргачлал;

4.7.3. маржинг тооцоолох аргачлал болон барьцаа байршуулах, түүнийг захиран зарцуулах, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулсан зохицуулалт;

4.7.4. төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд авах арга хэмжээ;

4.8. Тооцооны байгууллага нь оролцогч талуудтай гэрээний үндсэн дээр тооцоог гүйцэтгэх бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

4.8.1. тооцооны үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ;

4.8.2. төлбөр гүйцэтгээгүйгээс учирч болох алдагдлыг хаах арга зам, хэрэгжүүлэх ажиллагаа;

4.8.3. тооцооны үйл ажиллагааны оролцогч болон гишүүдээс арилжааны хэлцлийн мэдээлэл хүлээн авах, дамжуулах, баталгаажуулах маягтын загвар;

4.8.4. хоёр талын шаардлагатай гэж үзсэн бусад асуудлууд.

4.9. Тооцооны байгууллага нь тооцооны гишүүнтэй байгуулах гэрээнд Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах зүйлийг тусгана.

4.9.1. тооцооны байгууллагын үзүүлэх үйлчилгээ, түүний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ;

4.9.2. мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, хадгалалт;

4.9.3. онцгой байдал үүсэх, тооцооны гишүүн төлбөрийн чадваргүй болох тохиолдолд үүсэх эрх, үүргийн харилцаа;

4.9.4. барьцаа болон эрсдэлийн сангийн хөрөнгө байршуулах, түүнийг захиран зарцуулах эрх үүргийн харилцаа;

4.9.5. маргаан шийдвэрлэх;

4.9.6. гэрээг цуцлах, дуусгавар болгох.

4.10. Тооцооны үйл ажиллагааны журамд заасан шаардлага болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, тооцооны үйл ажиллагааг эрсдэлд оруулах үйлдэл гаргасан тохиолдолд тооцооны байгууллагын санаачлагаар тооцооны үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцалж болно. Энэ нь төлбөр төлөгдөхгүй байх нөхцөл болохгүй.

4.11. Тооцооны байгууллага нь төлбөрийн даалгавар илгээх, мэдээллийг тооцооны оролцогчид болон гишүүдэд мэдээлэх үүрэгтэй.

ТАВ. ТООЦООНЫ ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГА БОЛОН ТООЦООНЫ

ГИШҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Тооцооны байгууллага нь үнэт цаасны арилжааны, төлбөрийн болон төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай мэдээлэл солилцох цахим сүлжээнд холбогдон, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна.

5.2. Тооцооны байгууллагын гишүүдийн төлбөр гүйцэтгэхтэй холбоотой хадгалуулж буй барьцааг энэ журмын 6.6-д зааснаар бүрдүүлэх ба мөнгөн хөрөнгийг төлбөр гүйцэтгэх байгууллагад, үнэт цаасыг үнэт цаасны хадгаламжийн байгууллагад гишүүд тус бүрийн нэр дээр болон нэгдсэн дансанд байршуулна.

5.3. Үнэт цаасны төлбөр гүйцэтгэх байгууллагууд нь тооцооны байгууллагын нэр дээр байршуулж буй барьцааны дансны бүртгэлийг гишүүн тус бүрээр хөтлөх үүрэгтэй.

5.4. Барьцаанд байршуулсан хөрөнгийн хадгалалт, аюулгүй найдвартай байдлыг энэхүү журмын 5.2-т заасан байгууллага хариуцах бөгөөд тооцооны байгууллага шаардсан тохиолдолд түүнийг мэдүүлэх үүрэг хүлээнэ.

5.5. Үнэт цаасны төлбөр гүйцэтгэх байгууллага нь тооцооны байгууллагын зөвшөөрөлгүйгээр барьцаанд байршуулсан хөрөнгийг захиран зарцуулах эрхгүй.

5.6. Тооцооны байгууллагаас баталсан тооцооны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг тооцооны оролцогч болон гишүүд дагаж мөрдөх үүрэгтэй.

5.7. Тооцооны байгууллагын гишүүн нь арилжаа эрхлэх байгууллага, өөрийгөө зохицуулах байгууллагын гишүүнчлэлтэй байна.

5.8. Тооцооны байгууллагын гишүүн нь тооцооны журам болон тооцооны байгууллагатай байгуулсан гэрээг зөрчсөн бол арилжаа эрхлэх байгууллага болон төлбөр гүйцэтгэгч банк нь тооцооны байгууллагад, тооцооны байгууллага болон төлбөр гүйцэтгэгч банк нь арилжаа эрхлэх байгууллагад тухайн өдөрт нь багтаан мэдэгдэнэ.

5.9. Тооцооны үйл ажиллагаанд оролцогч байгууллага нь тооцоолол хийхэд шаардагдах мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

5.10. Арилжаа эрхлэх байгууллага нь арилжааны хэлцлийн үнийн дүн, үнэт цаасны тоо ширхэг, хэлцлийн мэдээллийг арилжаа дууссанаас хойш тооцооны хуваарийн дагуу цахим сүлжээгээр болон хэвлэмэл хэлбэрээр тооцооны байгууллагад хүргүүлнэ.

ЗУРГАА. ТООЦООНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. Тооцооны байгууллага нь арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн арилжааны хэлцлийн мэдээг үндэслэн арилжаанд оролцогч талуудын төлбөл зохих төлбөрийг хэлцэл тус бүрээр эсвэл нэгдсэн байдлаар тодорхойлж, төлбөрт оролцогчдын тооцооллыг хийж гүйцэтгэнэ.

6.2. Тооцооллын үр дүнд гарсан тооцооны мэдээг арилжаа эрхлэх байгууллага болон оролцогчдод хүргүүлж, үр дүнг тулган баталгаажуулсны дараа төлбөр гүйцэтгэх даалгаврыг төлбөр гүйцэтгэгч байгууллагуудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлнэ.

6.3. Тооцооны байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43.2-т заасан гишүүнчлэлтэй байх бөгөөд системийн эрсдэлийг бууруулах тусгай сантай байна.

6.4. Энэхүү журмын 6.3-т заасан гишүүнчлэлийн журмыг Тооцооны байгууллага тогтооно.

6.5 Тооцооны байгууллагын төлөөр түргэн гүйцэтгэх чадварын хувь хэмжээг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Хороо тогтооно.

6.6. Тооцооны байгууллагын гишүүний төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь 500 сая төгрөгөөс доошгүй байх ба барьцаа нь бэлэн мөнгө болон түргэн хөрвөх үнэт цааснаас бүрдэнэ.

6.7. Барьцаанд байршуулсан нийт хөрөнгийн 80 хүртэл хувь нь түргэн хөрвөх үнэт цаас, 20 хувиас доошгүй хувь нь бэлэн мөнгө байна.

6.8. Тооцооны байгууллага нь тооцооны хуваарийг тогтоох бөгөөд төлбөр гүйцэтгэгч банкны ажлын цагийг харгалзан арилжаа эрхлэх байгууллагатай зөвшилцөнө. Тооцооны хуваарьт арилжааны хэлцлийг хүлээн авах, арилжааг тулгах, тооцоолол болон баталгаажуулалт хийгдэх, төлбөрийн даалгавар хүргүүлэх хугацаа зэргийг нарийвчлан тусгана.

6.9. Тооцооны байгууллага нь тооцооны оролцогч байгууллага тус бүртэй төлбөр гүйцэтгэх даалгаврын баталгаажуулалтыг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулна.

6.10. Тооцооны байгууллага нь тооцооны үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, тооцооллын дүнд хийгдсэн болон цуцлагдсан хэлцлийн бүртгэлийг хөтөлж хадгалах үүрэгтэй.

Долоо. Эрсдэлийн удирдлага

7.1. Тооцооны үйл ажиллагаанаас санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор тооцооны байгууллага нь эрсдэлийн санг байгуулна.

7.2. Тооцооны байгууллага нь эрсдэлээс хамгаалах санг хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувиас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгөөр байгуулна.

7.3. Эрсдэлийн сангийн хөрөнгийг зөвхөн онцгой нөхцөл байдал үүсэх, өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тооцооны гишүүдэд учруулсан хохирлыг барагдуулах, тооцооны байгууллагын гишүүд төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд зах зээлд учирсан эрсдэлийг хаах зорилгоор зарцуулна.

7.4. Эрсдэлийн сангийн хөрөнгийг арилжааны банкинд тусгайлсан данс нээж байршуулах бөгөөд сангийн зарцуулалт, үлдэгдлийг улирал тутам Хороонд хүргүүлнэ.

7.5. Тооцооны байгууллага нь эрсдэлийн удирдлагын нэгжтэй байна.

7.6. Эрсдэлийн удирдлагын нэгж нь зах зээлд оролцогчдын төлбөрийн чадварыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

7.6.1. тооцооны үйл ажиллагаанд учирч болох /зах зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл/ эрсдэлийн удирдлага, бодлогыг боловсруулж мөрдөх;

7.6.2. тооцооны байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах төлөвлөгөөтэй байх;

7.6.3. үнэт цаасны зах зээлийн тогтолцооны эрсдэлийг шинжилж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаарх зөвлөмжөөр үнэт цаасны арилжааны, төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг хангах;

7.6.4. тооцооны гишүүдийн барьцааны шаардлага, маржинг тооцооны өдөр бүр тооцоолох бөгөөд маржин болон барьцааны хувь хэмжээг төлбөрийн чадварын эрсдэлтэй уялдуулж тогтоох;

7.6.5. тооцооны гишүүдийн төлбөрийн чадварын эрсдэлийг удирдахын тулд эрсдэл

багатай барьцааг хүлээн зөвшөөрч, үнэ цэнийн бууралт, төвлөрлийн хязгаар зэргийг харгалзан тогтоох;

7.6.6. тооцооны үйл ажиллагааны эрсдэл, түүнээс гарсан алдагдлын талаарх мэдээллийг бүртгэх, хадгалах;

7.7. Олон улсын жишигт нийцсэн эрсдэлийн үнэлгээ, стресс тест зэрэг тоон болон чанарын аргачлал, зөвлөмжийг гаргаж, оролцогчдын төлбөрийн эрсдэлийг бууруулах бодлогыг баримтлана.

НАЙМ. МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ

8.1. Тооцооны байгууллага нь дараах мэдээлэлтэй олон нийт танилцах бололцоог хангаж ажиллана. Үүнд:

8.1.1. үүсгэн байгуулах бичиг баримт;

8.1.2. тооцооны байгууллагын дүрэм, журам

8.1.3. жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын тайлангийн хамт;

8.1.4. тооцооны байгууллагын тооцоог нь гүйцэтгэж буй арилжаа эрхлэх байгууллагуудын жагсаалт;

8.1.5. тооцооны байгууллагын төлбөр гүйцэтгэж буй төлбөр гүйцэтгэгч банкуудын жагсаалт;

8.1.6. тооцооллын дүнд үнэт цаастай холбоотой үнэт цаасны өмчлөх эрх баталгаажуулж буй хадгаламжийн байгууллагын жагсаалт;

8.1.7. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

8.2. Тооцооны байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журамд өөрчлөлт орсон тохиолдолд Хороо батламжилсаны дараа олон нийтэд хүргэнэ.

ЕС. ХОРООНД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ

9.1. Тооцооны байгууллага нь Хорооны 2013 оны 457 дугаар тогтоолоор батлагдсан "Зохицуулалттай этгээдийн мэдээллийн сангийн журам"-аас гадна дараах мэдээллийг Хороонд ирүүлнэ. Үүнд:

9.1.1. тооцооны байгууллагын журам, тооцооны гэрээнд орсон нэмэлт өөрчлөлтийг өөрчлөлт орсноос хойш ажлын хоёр өдрийн дотор;

9.1.2. тооцооны байгууллагын үйл ажиллагааны шимтгэл хураамжийн хувь, хэмжээнд өөрчлөлт орсон бол шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор;

9.1.3. тооцооны байгууллага нь тооцооны гишүүн төлбөрийн чадваргүй болсны улмаас түүний төлвөл зохих төлбөрийг барагдуулсан тохиолдолд болон тухайн төлбөрийн чадваргүй болсон этгээдийн талаарх мэдээллийг тухай бүр;

9.1.4. тооцооны байгууллага нь санхүүгийн тайланг улирал бүр Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд;

9.1.5. хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор;

9.1.6. тооцооны байгууллага нь тооцооны үйл ажиллагаанд хийсэн стресс тестийн үр дүн, эрсдэлийн удирдлагын тайланг улирал бүр дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор;

9.1.7. Шаардлагатай тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр хүргүүлэх.

АРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

10.1. Хороо тооцооны байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.2. Газар дээрх хяналт, шалгалт нь зорилгоос хамаарч иж бүрэн болон хэсэгчилсэн, хугацаанаас хамаарч ээлжит болон ээлжит бус гэсэн байдлаар хийгдэнэ.

10.3. Хороо шаардлагатай гэж үзвэл Төлбөр гүйцэтгэгч банкинд газар дээрх хяналт шалгалтыг Монголбанктай хамтран гүйцэтгэж болно.

АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА

11.1. Хороо энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчилд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай
этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ийн арванхоёрдугаар хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Маргаан таслах зөвлөл /цаашид "зөвлөл" гэх/ нь маргааны талаарх хүсэлт /цаашид "хүсэлт" гэх/-ийг хянан шийдвэрлэхдээ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3. Зөвлөл нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хүсэлтийг хянан үзэхгүй, буцааж болох бөгөөд энэ тохиолдолд шалтгаан, үндэслэлийг тодорхой зааж, албан бичгээр мэдэгдэнэ.

1.4. Зөвлөл нь хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд холбогдох мэдээ, мэдээллийг нууцлан хадгалах зарчмыг үйл ажиллагаандаа баримтална.

1.5. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд ил тод, нээлттэй, хуульд захирагдах, шударга ёсны зарчмыг баримтална.

1.6. Энэхүү журмаар нь үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад хамаарах зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагч хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх, зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хүсэлттэй холбоотой зөвлөлөөс гарсан шийдвэрийг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх харилцааг зохицуулна.

ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Зөвлөл нь зөвлөлийн дарга болон 8 гишүүнээс бүрдэх бөгөөд тус зөвлөлийн дарга, гишүүн орон тооны бус байна.

2.2. Зөвлөл нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд нарийн бичгийн дарга нь саналын эрхгүй байна.

2.3. Дарга, гишүүд, нарийн бичгийн даргыг Хороо томилж, чөлөөлнө. Дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг чөлөөлөхөд түүний оронд ажиллах дараагийн хүнийг шууд томилно.

2.4. Зөвлөлийн гишүүдэд дараах нэгж, байгууллагын төлөөлөл тус бүр нэг хүн ажиллана:

2.4.1. Хорооны Ажлын албаны хяналт шалгалт, үнэт цаасны зах зээлийн бодлого зохицуулалт болон эрх зүйн асуудал хариуцсан нэгжүүдийн төлөөлөл;

2.4.2. Арилжаа эрхлэх байгууллагын төлөөлөл;

2.4.3. Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллагын төлөөлөл;

2.4.4. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны төлөөлөл;

2.4.5. Үнэт цаасны зах зээлийн судлаачид буюу мэргэжилтнүүдийн төлөөлөл.

2.5. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Хорооны Ажлын албанаас орж буй албан хаагч нь улсын байцаагч байна.

2.6. Энэ журмын 2.5 дахь хэсэгт заасан албан хаагчид улсын байцаагчийн эрх олгоход Хорооны 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 154 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм"-ийн 5.1 дэх заалт хамаарахгүй.

2.7. Зөвлөлийн нарийн бичгийн дарга Хорооны ажлын албаны үнэт цаасны зах зээлийн бодлого зохицуулалтын асуудал хариуцсан хэлтсийн хянан шалгагч байна.

2.8. Дээрх нэгж, байгууллагууд нь Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх хүний нэрийг Хорооны Хяналт шалгалтын газарт ирүүлэх ба нэгтгэн Хорооны хуралдаанд танилцуулна.

2.9. Хороо нь Зөвлөлийн гишүүдэд нэр дэвшүүлсэн хүний нэрийг буцааж, өөр хүнийг дэвшүүлэхийг санал болгох эрхтэй.

ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН ЭРХ БОЛОН ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1. хүсэлтийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээ судалгааг Хороо болон бусад холбогдох байгууллагаас гаргуулан авах;

3.1.2. маргалдагч талууд болон холбогдох гуравдагч этгээдээс тайлбар, нотлох баримт гаргуулан авах;

3.1.3. шаардлагатай тохиолдолд Хорооны тухайн асуудал хариуцсан хянан шалгагчаар тайлбар, дүгнэлт гаргуулах;

3.1.4. хянан шийдвэрлэж байгаа асуудал нь гэмт хэргийн шинжтэй бол зохих журмын дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

3.2. Зөвлөл нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагчийн хооронд гарсан дараах маргааныг хянан шийдвэрлэнэ:

3.2.1. үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн шимтгэл, хураамжтай холбоотой маргаан;

3.2.2. үнэт цаасны төвлөрсөн хадгаламж, төлбөр тооцоо, арилжаа эрхлэх байгууллагын гаргасан шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой маргаан;

3.2.3. Хорооны хурлаас эсхүл Хорооны даргын шилжүүлсэн маргаан;

3.3. Хүсэлт гаргагч нь зөрчигдсөн эрхээ сэргээн эдлүүлэхийг зөвлөл, Хорооноос шаардах эрхтэй.

3.4. Хүсэлт гаргагч нь өөрийн гаргасан хүсэлттэй холбоотой дараах үүргийг хүлээнэ:

3.4.1. Өөрийн гаргасан хүсэлттэй нь холбогдуулан зөвлөлөөс гаргаж өгөхийг шаардсан

баримт, мэдээллийг үнэн, зөв гаргаж өгөх;

3.4.2. Өөрийн гаргасан хүсэлтийг хянан шийдвэрлэх зөвлөлийн хуралдаанд ирж оролцох;

3.4.3. иргэн, хуулийн этгээдийн зөвлөлд хандан гаргаж байгаа хүсэлтийн хэлбэр нь энэхүү журмын хавсралтад заасан хэлбэрийн шаардлагыг хангах;

3.4.4. Хорооны хурлаар баталгаажсан Зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх;

3.4.5. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

ДӨРӨВ. ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВЧ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛД БЭЛТГЭХ

4.1. Зөвлөлийн дарга, гишүүн нь шаардлагатай гэж үзвэл Хорооны тухайн асуудал хариуцсан хянан шалгагчаар тайлбар, дүгнэлт гаргуулж, бэлтгүүлж болно.

4.2. Зөвлөлд тайлбар, мэдээлэл, дүгнэлт гаргах хянан шалгагч нь үйл ажиллагаандаа энэ журмын 1.2-ыг удирдлага болгоно.

4.3. Зөвлөл хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлэх хугацаа ажлын 20 хоног байна. Шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвлөлийн хурлыг 10 хоногоор сунгаж болно.

4.4. Журмын 4.5-д заасан хугацаанд хүсэлтийг хянан шийдвэрлэж холбогдох саналаа Хорооны хурлаар хэлэлцүүлээгүй тохиолдолд буруутай этгээдэд сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно. Буруутай этгээд нь Хороонд ажилладаггүй тохиолдолд зөвлөлийн гишүүнээс чөлөөлж болно.

4.5. Зөвлөлд ирсэн хүсэлтийг зөвлөлийн дарга хүлээн авч нарийн бичгийн даргад шилжүүлнэ. Тухайн хүсэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцэх эсэх шийдвэрийг уг хүсэлтийг хүлээж авснаас хойш 10 хоногийн дотор зөвлөлийн нарийн бичгийн дарга гаргана.

4.6. Зөвлөлийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр зөвлөлийн хурлын өдөр, цаг, газрыг товлон, тухайн хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулга бэлтгэн гишүүдийн цахим хаягт хүргүүлэх буюу утсаар холбогдон мэдээлнэ.

4.7. Маргааны оролцогчдод хурлын товыг утсаар холбогдон мэдээлнэ.

4.8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг гаргаж зөвлөлийн даргаар батлуулах бөгөөд хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй асуудлыг хурлаар хянан шийдвэрлэж болохгүй.

ТАВ. ХҮСЭЛТИЙГ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ, ХУРЛЫН ИРЦ

5.1. Зөвлөлийн хурал нь журмын 4.7-д заасны дагуу мэдээлэгдсэн хугацаанд, товлогдсон газарт хуралдах бөгөөд уг хуралд хурлыг даргалагч батлагдсан хэлэлцэх асуудлын дагуу асуудлыг хянан шийдвэрлэнэ.

5.2. Хүсэлтийг зөвлөл хурлаараа хянан шийдвэрлээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

5.2.1. Хүсэлтийг бүхлээр нь хүлээн зөвшөөрөх санал;

5.2.2. Хүсэлтийг хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх санал;

5.2.3. Хүсэлтээс бүхлээр татгалзах санал.

5.3. Зөвлөлийн хурал нь нийт гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор хүчин

төгөлдөр болно.

5.4. Зөвлөл хүсэлтийг хянан шийдвэрлэхдээ дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь асуудал шийдвэрлэхэд саналын эрхгүй байна.

5.5. Зөвлөлийн гишүүн хуралд биечлэн оролцоно.

5.6. Зөвлөлийн хурлаас гарсан саналд зөвлөлийн дарга гарын үсэг зурж зөвлөлийн гишүүд танилцсанаар албан ёсоор баталгаажна.

5.7. Зөвлөлөөс гарсан саналыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ.

ЗУРГАА. ЗӨВЛӨЛӨӨС ГАРСАН САНАЛЫГ ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

6.1. Зөвлөлийн саналыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх танилцуулгыг нарийн бичгийн дарга бэлтгэн Хорооны хуралдаанд зөвлөлийн дарга танилцуулна.

6.2. Зөвлөлийн танилцуулсан саналын талаар Хороо нь дараах шийдвэрийн аль нэгийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.2-д заасны дагуу гаргана:

6.2.1. саналыг хэвээр батлах;

6.2.2. саналыг өөрчлөх;

6.2.3. саналыг дахин хянуулахаар Маргаан таслах зөвлөлд буцаах.

6.3. Зөвлөлийн саналтай холбоотой Хорооны хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн холбогдох тогтоолын төслийг боловсруулан зөвлөлийн даргад танилцуулж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. Уг ажлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

ДОЛОО. БУСАД

7.1. Зөвлөлөөс гарах санал, хурлын протокол, зөвлөлд ирсэн хүсэлт болон бусад баримт бичгийг зөвлөлийн нарийн бичгийн дарга жилийн эцсээр Хорооны архивт хүлээлгэн өгнө.

7.2. Зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нь маргааны оролцогчидтой хамаатан, гэр бүлийн, бизнесийн, ашиг сонирхлын холбоотой тохиолдолд өөрийн ёс зүйгээр тухайн хуралдаанаас зөвлөлийн даргын зөвшөөрлөөр татгалзан гарна.

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ
ЗЭЭЛИЙН МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛД ХҮСЭЛТ ГАРГАХ НЬ**

...оны сарын ны өдөр /хүсэлт гаргасан огноо/

Улаанбаатар хот

Хүсэлт гаргагчийн товч мэдээлэл:

Овог нэр:

Регистрийн дугаар:

Оршин суугаа хаяг:

Утасны дугаар:

Зөвлөлөөр шийдвэрлүүлэх гэж буй асуудлын товч утга:

.....
.....
.....
.....
.....

Зөвлөлөөр шийдвэрлүүлэх гэж буй асуудлын дэлгэрэнгүй:

.....
.....
.....
.....

Хүсэлт гаргасан:

...../.....

Гарын үсэг

Гарын үсгийн тайлал

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай
этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ийн арвангуравдугаар хавсралт

МЭРГЭШЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОМИЛОХ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох харилцааг зохицуулна.

Хоёр. Мэргэшлийн зөвлөл

Мэргэшлийн зөвлөл нь Үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах, мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй холбоотой харилцааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлж буй Мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд хяналт тавина.

Мэргэшлийн зөвлөл нь орон тооны бус есөн гишүүдээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хорооноос томилно.

Мэргэшлийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн хурлаар томилно.

Мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Хорооны Үнэт цаасны газрын болон сургалт зохион байгуулагч, үнэт цаасны чиглэлээр эрдмийн зэрэг, цолтой багш судлаачдын төлөөлөл орж болно.

Мэргэшлийн зөвлөлийн хуралдаан нь нийт гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноорхучин төгөлдөр болох бөгөөд асуудлыг хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

мэргэшлийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг хөтөлж, зөвлөлийн дарга, гишүүдэд танилцуулах;

мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг баталгаажуулах, нийтэд мэдээлэх;

мэргэшлийн зөвлөлийн хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө хуралдаанд хэлэлцэх асуудлын жагсаалтыг Мэргэшлийн зөвлөлийн даргаар батлуулж, хэлэлцэх бичиг баримтын хамт гишүүдэд хүргүүлнэ.

Гурав. Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх

Мэргэжилтний эрх олгох болон аттестатчилах мэргэшлийн сургалт, шалгалттай холбоотой өргөдлийг Мэргэшлийн зөвлөл хүлээн авч, шийдвэрлэнэ.

Шалгуулагч шалгалтын дүнтэй санал нийлэхгүй, шалгалтын тесттэй холбоотой өргөдлийг шалгалтын дүн зарлагдсанаас хойш ажлын гурван хоногт багтаан Мэргэшлийн зөвлөлийн даргад бичгээр ирүүлнэ.

Мэргэшлийн зөвлөл өргөдлийг ажлын гурван өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

Шалгалтын дүнтэй холбогдсон маргаан гарвал Мэргэшлийн зөвлөлийн дарга магадлах ажлын хэсгийг томилон, материалыг дахин шалгуулах эрхтэй бөгөөд тухайн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Мэргэшлийн зөвлөл шийдвэр гаргана.

Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргах эрхтэй.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай
этгээдийн үйл ажиллагааны багц журам”-ийн арвандөрөвдүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ДҮРЭМ, ЖУРМЫГ БАТЛАМЖЛАХ, БҮРТГЭХ ТУХАЙ ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү заавраар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.4-д заасны дагуу арилжаа эрхлэх, төлбөр тооцоо хадгаламжийн байгууллагын дүрэм, журмыг батламжлах, мөн хуулийн 72.2-т заасны дагуу өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/ бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хорооны дүрэм, журмын батламжлах, бүртгэх ажиллагаа нь дараах гурван төрөлтэй байна:

1.2.1. Арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын дүрэм, журмыг батламжлах;

1.2.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 72 дугаар зүйлд заасны дагуу өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм, журмыг бүртгэх;

1.2.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1-24.1.5, 24.1.10, 24.1.12, 24.1.13-т заасан зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг бүртгэх, мэдээллийн санд хадгалах.

ХОЁР. АРИЛЖАА ЭРХЛЭХ, ТӨЛБӨР ТООЦОО, ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ, ЖУРМЫГ БАТЛАМЖЛАХ

2.1. Арилжаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.2, Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам"-ын 3.2 дахь хэсэгт заасан гишүүд нь дагаж мөрдөх үүрэг бүхий дараах дүрэм, журмыг Хорооны даргын тушаалаар батламжлуулна:

2.1.1. Үнэт цаасны арилжааг зохион байгуулах журам;

2.1.2. Үнэт цаасны арилжаанд үнэт цаасыг оруулах журам;

2.1.3. Үнэт цаасны арилжааны гэрээ байгуулах, бүртгэх журам;

2.1.4. Үнэт цаасны арилжааны гэрээг биелүүлэх журам;

2.1.5. Үнэт цаасны арилжааны хяналтын журам;

2.1.6. Үнэт цаасны бүртгэлийн журам;

2.1.7. Үнэт цаасны арилжаа эрхлэхэд шаардлагатай бусад дүрэм, журамб

2.2. Арилжаа эрхлэх байгууллагын батламжлуулахаар Хороонд ирүүлсэн дүрэм, журам нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулсан байх;

2.2.2. дүрэм, журмын төслийг боловсруулах шатанд Хороо, төлбөр тооцоо хадгаламжийн байгууллага болон гишүүн байгууллагуудын саналыг авч тусгасан байх;

2.2.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон тус Хорооны холбогдох дүрэм, журмын зохицуулалттай нийцсэн байх.

2.3. Төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам"-ын 3.3, 3.4, 3.5 дахь хэсэгт заасан гишүүд нь дагаж мөрдөх үүрэг бүхий дараах дүрэм, журмыг Хорооны даргын тушаалаар батламжлуулна:

2.3.1. үнэт цаасны төлбөрийн эрсдлийн удирдлагын журам;

2.3.2. хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны төлбөр, тооцооны үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдлээс хамгаалах сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах нөхцлийг тусгасан дотоод журам;

2.3.3. үнэт цаасны арилжааны болон арилжааны бус хэлцлийн төлбөр, тооцоог хийж гүйцэтгэх журам;

2.3.4. мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих тухай журам;

2.3.5. үнэт цаасны тооцооны үйл ажиллагааны журам;

2.3.6. үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх нэгжийн чиг үүргийг онцгойлон заасан үйл ажиллагааны журам;

2.3.7. үнэт цаасны хадгаламж, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам;

2.3.8. төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай бусад дүрэм, журам.

2.4. Төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын батламжлуулахаар Хороонд ирүүлсэн дүрэм, журам нь дараах шаардлагыг хангасан байна:

2.4.1. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулсан байх;

2.4.2. дүрэм, журмын төслийг боловсруулах шатанд Хороо, арилжаа эрхлэх байгууллага болон гишүүн байгууллагуудын саналыг авч тусгасан байх;

2.4.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон тус Хорооны холбогдох дүрэм, журмын зохицуулалттай нийцсэн байх.

2.5. Арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын дүрэм, журам нь энэхүү зааврын 2.2, 2.4-д заасан шаардлагыг хангаагүй нөхцөлд Хорооны дарга батламжлахаас татгалзаж, энэ талаар албан бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВ. ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ДҮРЭМ, ЖУРМЫГ БҮРТГЭХ ТУХАЙ

3.1. Өөрийгөө зохицуулах байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2014 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан "Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх тухай журам"-ын хүрээнд батлахаар заасан дараах дүрэм, журмыг Хорооны дарга тушаалаар бүртгэнэ.

3.1.1. гишүүнээр элсүүлэхэд тавих шаардлага, гишүүнчлэлийн хураамж, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах журам;

3.1.2. гишүүд, тэдгээрийн ажилтнуудын үйл ажиллагаанд баримтлах мэргэжлийн ёс зүйн дүрэм;

3.1.3. гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих болон гомдол, маргааныг хянан шийдвэрлэх журам;

3.1.4. өөрийгөө зохицуулах байгууллагын удирдлага зохион байгуулалт үйл ажиллагааны журам;

3.1.5. гишүүдэд сургалт явуулах, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах журам;

3.1.6. зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцохоос урьдчилан сэргийлэх зэрэг шударга арилжааг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах журам;

3.1.7. өөрийгөө зохицуулах байгууллага үйл ажиллагаагаа эрхлэхэд шаардлагатай бусад холбогдох дүрэм, журам.

3.2. Өөрийгөө зохицуулах байгууллагын бүртгүүлэхээр Хороонд ирүүлсэн дүрэм, журам нь дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1. өөрийгөө зохицуулах байгууллагын бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан байх;

3.2.2. дүрэм, журмыг боловсруулах шатанд Хороо болон арилжаа эрхлэх, төлбөр тооцоо хадгаламжийн байгууллагын саналыг авч тусгасан байх;

3.2.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон Хорооны холбогдох дүрэм, журамд нийцсэн байх.

3.3. Энэхүү зааврын 3.2 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй нөхцөлд Хорооны дарга бүртгэхээс татгалзаж, энэ талаар албан бичгээр мэдэгдэнэ.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ДҮРЭМ, ЖУРМЫГ БҮРТГЭХ ТУХАЙ

4.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1-24.1.5, 24.1.10-24.1.12,13-д заасан зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 57.1.7, 63.1.11-д заасны дагуу Хорооны үнэт цаасны газар хянаж, мэдээллийн санд бүртгэнэ.

4.2. Зохицуулалттай этгээд нь Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам", мөн Хорооны 2014 оны 8 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам", Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 85/А-106 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам"-ын дагуу баталж, үйл ажиллагаанд мөрдөхөөр заасан дүрэм, журмыг Хорооны Үнэт цаасны газарт бүртгүүлэхээр ирүүлнэ.

4.3. Зохицуулалттай этгээдийн бүртгүүлэхээр Хороонд ирүүлсэн дүрэм, журам нь дараах шаардлагыг хангасан байна:

4.3.1. компанийн эрх бүхий этгээдийн шийдвэрээр дүрэм, журмыг баталсан байх;

4.3.2. хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашигт нийцсэн, тэдгээрийн эрх ашгийг зөрчсөн шинжтэй зохицуулалтыг агуулаагүй байх;

4.3.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны холбогдох дүрэм, журамд нийцсэн байх.

4.4. Энэхүү зааврын 4.3-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд зохих журмын дагуу мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

4.5. Энэхүү зааврын 4.3-т заасан шаардлагыг хангаагүй дүрэм, журмыг бүртгэхээс татгалзан, компанийн эрх бүхий албан тушаалтанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны холбогдох дүрэм, журамд нийцүүлэх хугацаатай үүрэг, даалгаврыг хүргүүлнэ.

ТАВ. БУСАД

5.1. Арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, энэхүү зааварын дагуу батлахаар заасан дүрэм, журам тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Хороогоор батламжлуулснаар хүчин төгөлдөр болно.

5.2. Өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны холбогдох дүрэм, журмын дагуу батлахаар заасан дүрэм, журам тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Хороонд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

5.3. Энэхүү зааврын 2.1, 2.3, 3.1-т заасан дүрэм, журмыг Хорооны даргаар батламжлуулж, бүртгүүлээгүй тохиолдолд дээрх дүрэм, журмыг хүчин төгөлдөр бус гэж тооцож, буруутай этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 89.1.9-т заасны дагуу захиргааны хариуцлага ногдуулна.

5.4. Энэхүү зааврын 4.2-т заасан дүрэм, журмыг Хорооны үнэт цаасны газарт бүртгүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан этгээдийн үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авна.